



MINISTRY OF  
FINANCE



ГААЛЬ, ТАТВАР, САНХҮҮГИЙН  
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТӨВ  
INFORMATION TECHNOLOGY CENTER  
OF CUSTOM, TAXATION AND FINANCE



# МОНГОЛ УЛС

**КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН ЯДУУРАЛ,  
ТЭГШ БУС БАЙДЛЫГ ИХ ӨГӨГДӨЛ  
АШИГЛАН СУДЛАХ НЬ.**

2021 оны 5 дугаар сар

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ) нь ядуурал, тэгш бус байдал, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй аливаа шударга бус байдлыг таслан зогсоохын төлөө тэмцдэг НҮБ-ын манлайлагч байгууллага юм. Дэлхийн 170 улс орны мэргэшсэн зөвлөхүүд, түншүүдийн өргөн сүлжээтэй хамтран ажиллаж хүн төрөлхтөн хийгээд эх дэлхийнхээ сайн сайхны төлөө нэгдсэн, баталгаатай, тогтвортой хэрэгжих гарц шийдлийг олоход нь улс үндэстнүүдэд тусалж байдаг.

### **Ерөнхий зүйл:**

Энэ нь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хэвлэн нийтэлж буй бүтээл юм. Энэхүү бүтээлд орсон материалууд нь НҮБХХ, ҮСХ болон Монгол Улсын засгийн газрын үзэл бримтлалын илэрхийлэл болохгүй.

Энэхүү бүтээлийн агуулга, үзэл санаа нь зөвхөн зохиогчдын бөгөөд хамтран хэвлэн нийтэлсэн байгууллагуудын үзэл баримтлал, бодлогын илэрхийлэл болохгүйн зэрэгцээ эдгээр байгууллагууд батламжлаагүй болно. Хэвлэлийн эх бэлтгэсэн байгууллага нь энэхүү бүтээлд орсон тоо мэдээллийн үнэн зөвийг баталгаажуулах үүрэг хүлээгээгүй бөгөөд ашиглах явцад гарах аливаа үр дагаварыг хариуцахгүй болно. Энэхүү бүтээлд нэр дурдсан “улс орон”, газар зүйн бүс нутаг, нутаг дэвсгэр, тэдгээрийн эрх бүхий байгууллагын эрх зүйн статус, хил хязгаартай холбоотой асуудлаар НҮБХХ, ҮСХ, засгийн газрын зүгээс баримталж буй үзэл санааг илэрхийлээгүй болно.

### **© 2021 United Nations Development Programme.**

Зохиогчийн эрх хамгаалагдсан. 2021 онд хэвлэв.

Эх сурвалжийг буюу НҮБХХ-ийг тодорхой дурдсан тохиолдолд хувийн болон ашгийн бус зорилгоор энэхүү бүтээлээс иш татаж буюу хэсэгчлэн хуулбарлан ашиглаж болно. Энэхүү бүтээлийн зохиогчийн эрх эдлэгч НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрт хандаж ашиглах хүсэлтээ бичгээр илэрхийлж зөвшөөрөл авалгүйгээр борлуулах, дамжуулан түгээх болон арилжааны зорилгоор ашиглахыг хориглоно.

**Зохиогчид:** Банзрагчийн Отгонтөгс<sup>1</sup>, Загдбазарын Манлайбаатар<sup>2</sup>, Ганхуягийн Уянга<sup>3</sup>, Төмөртоогогийн Дэлгэрнаран<sup>4</sup>, Авирмэдийн Амарбал<sup>5</sup>, Даваацэрэнгийн Даваажаргал<sup>6</sup>, Лхагвын Ундрал<sup>7</sup>, Маширын Оюунцэцэг<sup>8</sup>, Төмөрийн Батбилэг<sup>9</sup>, Жавхлангийн Ганбаяр<sup>10</sup>, Галбатын Ариунбаяр<sup>11</sup>.

Цахим хаяг:

<http://mn.undp.org>

### **Холбоо барих хаяг:**

#### **Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр**

НҮБ-ын Байр, Нэгдсэн Үндэстний Байгууллагын гудамж 14, Сүхбаатар дүүрэг, 14201  
Улаанбаатар хот, Утас: +976-11-327585

<sup>1</sup> Монгол Улсын Их сургуулийн Эдийн засгийн тэнхим, Профессор otgontugs@num.edu.mn

<sup>2</sup> Монголын Эдийн засгийн судалгааны институт, Судлаач manlaibaatar@deri.mn

<sup>3</sup> НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Бангкок дахь Бүсийн төв, Эдийн засагч uyanga.gankhuyag@undp.org

<sup>4</sup> Монгол Улс дахь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Эдийн засагчаар ажиллаж байсан, delgernaran.tumurtogool@undp.org

<sup>5</sup> Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга, amarbal@nso.mn

<sup>6</sup> Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, Статистикч, davaajargal@nso.mn

<sup>7</sup> Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, Статистикч, undral@nso.mn

<sup>8</sup> Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, Ахлах статистикч, oyuntsetseg@nso.mn

<sup>9</sup> Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн Захирал, batbileg@itc.gov.mn

<sup>10</sup> Монгол Улсын Сангийн яам, Ахлах эдийн засагч, ganbayar\_ji@mof.gov.mn

<sup>11</sup> Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн Мэдээллийн шинжээч, ariunbat@gmail.com

## ӨМНӨХ ҮГ

КОВИД-19 цар тахлын хор уршиг нь дэлхий дахины болон Монгол Улсын хүн амын эрүүл мэнд, нийгэм эдийн засгийг гүн хямралд оруулж байна. Энэхүү гүн хямралаас шалтгаалан өрхийн орлого буурч, ядуурал улам бүр нэмэгдэж, тэгш бус байдал илүү хурцдаж болзошгүй байна. Чухамдаа цар тахлын үр нөлөө, түүнтэй тэмцэх арга хэмжээг сайтар судалж ойлгосноор цар тахлыг илүү үр дүнтэй гэтлэн давах болно.

Бодлого, шийдвэр гаргагчдыг цар тахалтай холбоотой үнэн зөв, бодитой мэдээллээр цаг тухайд нь хангах зорилгоор НҮБХХ, ҮСХ нь Монгол Улсын Их Сургууль (МУИС), Сангийн яам, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв зэрэг байгууллагуудтай хамтарч Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-ын цахим төлбөрийн бүртгэлийн системийн Их өгөгдлийг ашиглан 2020 онд Монгол Улсын хүн амын хэрэглээ, ядуурал, тэгш бус байдалд КОВИД-19 цар тахлын хямрал хэрхэн нөлөөлж байгааг судлах энэхүү туршилтын судалгааг хийсэн болно. Уг судалгааг хийснээр Монгол Улсын айл өрхүүдийн хэрэглээнд гарч буй өөрчлөлтийн талаар гүн гүнзгий ойлголтой болж, ядуурал, тэгш бус байдлын үзүүлэлтүүдийг тооцох шинэлэг хувилбарыг боловсруулах боломж нөхцөл бий болсон. Хамгийн гол нь НӨАТ-ын цахим төлбөрийн бүртгэлийн системийг ашиглан хүн амын хэрэглээ, ядуурал, тэгш бус байдалд гарч буй өөрчлөлтийг өмнөхөөсөө илүү тогтмол шуурхай тооцож хянах боломж бүрдэж байгаа юм.

Маш хурдтайгаар тогтмол шинэчлэгддэг мэдээллийн сантай байж, түүндээ байнга дүн шинжилгээ хийснээр бодлого шийдвэр гаргагчид баталж гаргасан шийдвэрийнхээ үр нөлөөг цаг алдалгүй олж мэдэх төдийгүй шаардлагатай тохиолдолд зохих залруулга хийх боломж бүрдэж байгаа нь ялангуяа эрс хурдацтай нүүрлэж буй хямралын энэ үед нэн чухал юм. Уламжлалт аргаараа мэдээлэл цуглуулах боломж нөхцөл хатуу хязгаарлагдсан энэ цаг үед энэхүү туршилтын судалгаа нь ядуурал, тэгш бус байдал, хямралын нөлөөллийг судлан дүн шинжилгээ хийх арга замыг эрэлхийлж буй бусад оронд ч тун ач холбогдолтой болох юм.

Монгол Улсад Их өгөгдлийн хэрэглээг эрчимжүүлэхэд энэхүү судалгааны үр дүн болон шинээр боловсруулан санал болгож буй аргачлал нь зохих хувь нэмэр оруулна хэмээн найдаж байна.

*Elaine Conkievich*

**Илейн Конкиевич**

Монгол Улс дахь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Суурин төлөөлөгч



**Батмөнхийн Батдаваа**

Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны Дарга

## ХУРААНГУЙ

Их өгөгдлийг ашиглан хийсэн энэхүү дүн шинжилгээний үр дүнгээс ажиглахад Монгол Улсад КОВИД-19 цар тахал дэгдсэн эхний жил болох 2020 онд өрхийн зарлага, ядуурал, өрхийн зарлагын тэгш бус байдалд өөрчлөлт орсон байна. Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-ын цахим төлбөрийн бүртгэлийн системийн Их өгөгдлийг Монгол Улсад анх удаа судалгааны зорилгоор ашиглаж байгаа нь энэ юм.

2020 оны цар тахлын хямралын үед өрхүүдийн зардал дунджаар өсч, харин ядуурлын түвшин болон зарлагын тэгш бус байдал бага зэрэг буурсан нь (2019 оныхтой харьцуулахад 2020 онд ядуурлын түвшин 4.8 пунктээр, Жини коэффициент 0.026 пунктээр тус тус буурсан) ажиглагдаж байна.

Гэсэн хэдий ч Их өгөгдлийг ашиглан эдгээр үзүүлэлтийг сар бүрээр тооцож үзэхэд хүн амын өрхийн хэрэглээ жилийн туршид нилээд хэлбэлзэлтэй байсан төдийгүй нийслэл Улаанбаатар хот болон бусад хот суурин газрууд, аймгуудад хатуу хөл хорио тогтоосон 2020 оны 1 болон 4-р улиралд өрхийн зарлага буурсан байна. Хүн амыг хэрэглээний түвшингээр нь таван тэнцүү бүлэгт хувааж дүн шинжилгээ хийж үзэхэд хамгийн ядуу хорин хувийнх нь хэрэглээнд цар тахлын хямрал онцгой нөлөөлсөн байна. Хот суурин газрын хүн амын өрхийн хэрэглээ ялангуяа хөл хорио тогтоосон хугацаануудад буурсан бол, хөдөө орон нутгийн хүн амын өрхийн хэрэглээнд цар тахлын хямралын нөлөө оны эхний хагаст илүү ихээр нөлөөлсөн нь мал аж ахуйгаас гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспорт хязгаарлагдсанаас шалтгаалсан байж болзошгүй юм.

2020 оны 4-р сараас эдийн засгийн дэмжлэгийн багц хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээр цар тахлын хямралаас улбаатай нийт хүн амын өрхийн хэрэглээ, ялангуяа хүн амын хамгийн ядуу 40 хувьд (зарлагаар нь тооцсон) учрах хүндрэлийг сааруулсан байна. Энэхүү дэмжлэгийн багц хөтөлбөрт нийгмийн хамгааллын томоохон хөтөлбөр багтсан бөгөөд түүний дийлэнх хэсэг нь хүүхэд бүрт үзүүлэх мөнгөн тэтгэмжийг нэмэгдүүлэх хөтөлбөрт зарцуулжээ. Гэхдээ энэхүү хөтөлбөрийн цаашдын санхүүжилт хэр тогтвортой байх нь тодорхой бус байна.

Хэрэглээ, ядуурал, тэгш бус байдлын үзүүлэлтүүдийг Их өгөгдөл ашиглан тооцох нь өрхийн судалгаанд үндэслэж гаргадаг албан ёсны статистик тооцооноос аргачлалын хувьд ялгаатай. Гэсэн хэдий ч энэхүү судалгаанд шинэлэг арга зүй, аргачлалыг хослуулан Их өгөгдлийг ашигласнаар хүн амын хэрэглээнд гарч буй өөрчлөлт, ядуурал, тэгш бус байдлыг хүн амын хэрэглээний түвшингээр тооцох шинэлэг гарц шийдлийг олж өмнөхөөсөө богино хугацаанд эдгээр үзүүлэлтийг тогтмол гаргаж, бодлого шийдвэрт үзүүлж болох нөлөөллийг судлах таатай нөхцөл бүрдсэн. Энэхүү судалгааны зохиомж нь тодорхой зорилгоор хөгжүүлсэн нийтийн албаны Их өгөгдлийн аюулгүй байдал, хувь хүний нууцлалыг алдагдуулалгүйгээр эмпирик болон бодлогын судалгааны мэдээллийн шинэ эх сурвалж болгон ашиглах боломж байгааг харуулсан болно.

## ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааны тайланг боловсруулах, бүрэн гүйцэд хийж дуусгахад хувь нэмэрээ оруулсан бүх хүнд гүн талархал илэрхийлье. Их өгөгдлийг ашиглах энэхүү судалгааны нөр их ажлыг манлайлан удирдсан Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга Авирмэдийн Амарбал, Монгол Улс дахь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Орлогч суурин төлөөлөгч Нашида Саттар нарт онцгойлон талархал илэрхийлье. Энэхүү судалгааны үндсэн санаа, агуулгыг томъёолж, бодитой удирдамж зөвлөгөө өгч, төслийг хэрэгжүүлэх бүхий л явцад мэдээлэлд дүн шинжилгээ хийх ажилд үнэтэй хувь нэмэр оруулсан Бангкок дахь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Бүсийн төвийн эдийн засагч Ганхуягийн Уянга, төслийг амжилттай удирдан зохицуулсан Монгол Улс дахь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн эдийн засагчаар ажиллаж байсан Төмөртоогогийн Дэлгэрнаран, судалгааны тайланг хянаж, үнэтэй зөвлөгөө өгсөн НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Ази, Номхон далайн бүсийн Ахлах эдийн засагч, Стратегийн зөвлөх доктор Балазс Хорват болон Малайз Улс дахь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн эдийн засагч, доктор Ханиза Халид нарт гүн талархал илэрхийлье. Төслийг хэрэгжүүлэх явцад туслалцаа дэмжлэг үзүүлсэн Монгол Улс дахь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Хяналт шинжилгээ, үнэлгээний шинжээч Өлзийхүүгийн Буяндэлгэрт мөн талархал илэрхийлье. Нэмэгдсэн өртгийн албан татварын мэдээллийн сан – Их өгөгдлийг хариуцах эрх үүрэг бүхий талуудын нягт хамтын ажиллагаа, дэмжлэг үгүйгээр энэхүү судалгааг хийх боломжгүй байсан билээ. Үүнтэй холбогдуулан Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн захирал Төмөрийн Батбилэг, Сангийн яамны ахлах эдийн засагч Жавхлангийн Ганбаяр нарт чин сэтгэлээсээ талархал илэрхийлж байна.

Энэхүү шинэлэг судалгаа шинжилгээг хийж, судалгааны үр дүнгийн тайланг боловсруулсан МУИС-ийн Эдийн засгийн тэнхимийн профессор, доктор Банзрагчийн Отгонтөгс, Монгол Улсын Эдийн засгийн судалгааны хүрээлэнгийн судлаач, доктор Загдбаатарын Манлайбаатар нарт талархаж байна. Түүнчлэн судалгааны явцад арга зүйн удирдамжаар хангаж, мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийхэд идэвхтэй оролцсон Үндэсний статистикийн хорооны Ахлах статистикч Маширын Оюунцэцэг, Статистикч Даваацэрэнгийн Даваажаргал, Статистикч Лхагвын Ундрал, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн Мэдээллийн шинжээч Галбатын Ариунбаяр зэрэг төрийн албан хаагчид болон мэдээллийн аюулгүй байдал, хувь хүний нууцлалыг чандлан хамгаалах бүхий л нөхцөлийг бүрдүүлж ажилласан нийт хүмүүст гүн талархал илэрхийлье.

## АГУУЛГА

Өмнөх үг .....	iii
Хураангуй.....	iv
Талархал .....	v
БҮЛЭГ 1. Удиртгал.....	1
БҮЛЭГ 2. Их өгөгдлийн талаарх суурь мэдээлэл.....	5
БҮЛЭГ 3. Статистикийн шинжилгээ .....	8
БҮЛЭГ 4. Үр дүн .....	11
4.1. КОВИД-19 цар тахлын дэгдэлтийн үед өрхийн зарлагад гарсан өөрчлөлт....	11
4.1.1. Өрхийн зарлага, өрхийн тэргүүний хүйсээр .....	14
4.1.2. Зарлага, хот, хөдөөгөөр.....	15
4.1.3. Зарлага, өрхийн хүүхдийнх нь тоогоор.....	17
4.1.4. Зарлага, хүн амын тэнцүү таван бүлгээр .....	18
4.1.5. Зарлага, орлого: хадгаламж, зээлийн хүчин зүйлүүд.....	20
4.2. Ядуурлын үзүүлэлтүүд .....	21
4.3. Тэгш бус байдлын үзүүлэлтүүд.....	24
4.3.1. Индексээр тооцсон тэгш бус байдлын үзүүлэлтүүд.....	24
4.3.2. Тархалтаар нь тооцсон тэгш бус байдлын үзүүлэлтүүд.....	27
БҮЛЭГ 5. Дүгнэлт.....	31
5.1. Судалгааны үр дүнд хийсэн дүгнэлт .....	31
5.2. Их өгөгдлийг ашиглах зөвлөмж.....	33
ХАВСРАЛТУУД .....	38
6.1. Их өгөгдлийг боловсруулах арга зүй, аргачлал .....	38
6.2. Мэдээлэл боловсруулалтын хоёр дахь үе шат.....	42
6.3. Дахин жинлэлт болон зөрүүний тохируулга .....	43
6.4. Тооцооллын аргачлал .....	44
6.4.1. Хэрэглээний (зарлагын) тооцоолол.....	45
6.4.2. Ядуурлын үзүүлэлтүүдийн тооцоо.....	50
6.4.3. Тэгш бус байдлын үзүүлэлтүүдийн тооцоо .....	52

## БҮЛЭГ 1. УДИРТГАЛ

Монгол Улсын хөгжилд учруулах цар тахлын уршиг нөлөөллийг одоогоор бид бүрэн хэмжээгээр нь хараахан мэдэхгүй байгаа ч асар их гэдгийг нь мэдэрч байгаа билээ. Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо (ҮСХ)-ны мэдээлснээр ДНБ 2020 онд 5.3 хувиар буурсан (нэг хүнд ногдох ДНБ 6.3 хувиар буурсан) байна (ҮСХ, 2021). Өмнөх арван жилийн хугацаанд ДНБ-ий жилийн дундаж өсөлт 7.8 хувь байсан (мөн нэг хүнд ногдох ДНБ-ий жилийн дундаж өсөлт 5.6 хувь байсан)-тай харьцуулахад эдийн засгийн өсөлтийн чиг хандлага эрчимтэй буурсан байна.

Дэлхийн болоод Ази, Номхон далайн бүсийн бусад олон улс орнуудтай харьцуулахад цар тахлын дэгдэлтийг Монгол Улс харьцангуй хязгаарлаж байсан. Тухайлбал, 2021 оны 1-р сарын 27-ны байдлаар нийт 1667 хүн КОВИД-19 халдвартай болох нь батлагдсанаас 1256 хүн нь эдгэрч, 4 хүн энджээ. Энэ нь цар тахлын дэгдэлтийн эхний үеэс Монгол Улсын Засгийн газраас бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдал зарлах, хатуу хөл хорио тогтоох, хүн бүр амны хаалт хэрэглэх, засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээг хүн бүр ёсчлон дагаж мөрдөх, хилийн авто боомтуудыг хаах зэрэг олон төрлийн хяналтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэнтэй холбоотой байсан.<sup>12</sup>

2021 оны 3-р сар хүртэл Улаанбаатар хотыг бүхэлд нь хамарсан, улмаар томоохон хотууд, аймгийн төвүүдийг хамарсан хатуу хөл хориог гурван удаа тогтоосон. Эхний хатуу хөл хорио 2020 оны 1-р сарын 27-ноос эхэлсэн бөгөөд сулруулсаар 2020 оны 5-р сарын 1 гэхэд хэвийн горимд шилжсэн билээ. Монгол Улсын Засгийн газраас хүмүүс хоорондын зай барих, олон нийтийг хамруулсан үйл ажиллагааг зогсоох, нийтийн тээврийн хэрэгслийн тоог цөөрүүлэх, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиуд, их, дээд сургуулиуд, боловсролын байгууллагуудын танхимын үйл ажиллагааг зогсоох, амны хаалтыг хүн бүр заавал хэрэглэх зэрэг арга хэмжээг авсан. Олон улсын аялал, жуулчлалыг мөн хориглосон.<sup>13</sup>

2020 оны дийлэнх хугацаанд хөл хорионы хатуу дэглэмийг мөрдөж байсан учир халдварын ихэнх тохиолдол хил дамжин “зөөвөрлөгдөн” орж ирж байсан боловч, хорио цээрийн дэг зөрчигдсөнөөс КОВИД-19-ын халдварыг Монгол Улс дотооддоо алдаж 2020 оны 11-р сарын 11-ний өдрөөс эхлэн халдварын дэгдэлт эрчтэй нэмэгдэж эхэлсэн нь засгийн газраас 2021 оны 1-р сарын 11 хүртэл 60 хоногийн хоёр дахь хатуу хөл хориог дахин тогтооход хүргэсэн. Улсын Онцгой комиссоос эмнэлэг, цахилгаан станц, хүнсний дэлгүүр, шатахуун түгээх станц, эмийн сан зэрэг амин чухал 13 салбараас бусад бүх салбарын аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг зогсоосон. Эрх баригчид хотын тээврийн хөдөлгөөнийг хязгаарлаж,

12 Гэсэн хэдий ч 2020 оны 11-р сараас КОВИД-19-ын халдварыг дотооддоо алдаж, улмаар халдвар эрчимтэй тархсанаар 2021 оны 4-р сарын 14-ний байдлаар халдварын нийт батлагдсан тохиолдол 17,823 болж, нийт 29 нас баралт бүртгэгдсэн байна.

13 Олон улсын нислэгүүд зогсож, тодорхой саруудад тогтоосон өдрүүдэд зөвхөн МИАТ-ын цөөн тооны тусгай үүргийн нислэгээр гадаад гацсан иргэдээ эх орондоо татан авах арга хэмжээг зохион байгуулж байв. Хил боомтууд хаагдаж, зорчигчид, ачаа тээврийн автомашиныг тодорхой зохицуулалттайгаар хилээр нэвтрүүлэх ажлыг зохион байгуулсан.

нийтийн эзэмшлийн газруудад олон нийтийг хамруулсан үйл ажиллагаа зохион байгуулахыг хориглож, боловсролын байгууллагуудын танхимын сургалтууд, худалдааны томоохон цэгүүд, захуудын үйл ажиллагааг зогсоосон. Зөвхөн тэргүүлэх ач холбогдол бүхий 13 салбарын ажилчдад ажлын байрандаа очих, буцах эрхийг олгосон. Дотоодын болон олон улсын нислэг, аялал жуулчлалыг хатуу хязгаарласаар байв. Халдварт вирусн тархалтыг бууруулахын тулд засгийн газар янз бүрийн цэгүүдэд санамсаргүй болон зорилтот тандалт судалгааг зохион байгуулж байсан.

Гурав дахь хатуу хөл хорио 2021 оны 2-р сарын 12-нд билгийн тооллын цагаан сарын босгон дээр эхэлж, 2021 оны 2-р сарын 23 хүртэл үргэлжилсэн. Үүний дараа хатуу хөл хориог чөлөөтэй нээснээр халдварын тархалт эрчимтэй дэгдсэн юм. Бид судалгаандаа зөвхөн 2020 оны өгөгдлийг ашигласан тул гурав дахь хөл хорионы үеийг бид дүн шинжилгээндээ хамруулаагүй болно.

КОВИД-19 цар тахлын хямралаас эдийн засгаа аврахын тулд Монгол Улсын Засгийн газар хэд хэдэн арга хэмжээ авсан.<sup>14</sup> Улсын Онцгой комисс 2020 оны 3-р сарын 27-ны өдрөөс эмзэг бүлгийн өрхүүд, аж ахуйн нэгжүүдийг хамгаалах, эдийн засгийн эрсдлийг бууруулахад чиглэсэн 5.1 их наяд төгрөгийн (2019 оны ДНБ-ий 13.7 хувьтай тэнцэх хэмжээний буюу өнөөгийн үнэ, ханшаар 1.79 тэрбум ам, доллар<sup>15</sup>) төсвийн дэмжлэгийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү хөтөлбөрт хүүхдийн сарын мөнгөн тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмж, хүнсний талоны хувь хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ; зарим төрлийн хүнс, эмнэлгийн хэрэгсэл, зарим төрлийн тоног төхөөрөмжийн импортын татварыг чөлөөлөх; хувь хүний орлогын албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг 2020 оны 9-р сарын эцэс хүртэл түр чөлөөлөх зэрэг арга хэмжээг тусгасан. Эдгээр арга хэмжээ нь эдийн засагт нэн шаардлагатай амь тариа болж байсан хэдий ч тус улсын гадаад өрийн дарамтыг улам бүр нэмэгдүүлж өрийн тогтворгүй байдал руу илүүтэй түлхэн оруулж байгаа юм.

Нийгмийн хамгааллын арга хэмжээ нь төсвийн дэмжлэгийн чухал хэсэг юм. Нийгмийн хамгааллын тэтгэмж тэтгэлэгийн жилийн нийт хэрэгцээ 1.7 их наяд төгрөг (нийт төсвийн дэмжлэгийн багцын 34 орчим хувь) байх бөгөөд үүнийг амлалт ёсоор 2020 оны 4-р сараас 12-р сар хүртэл үргэлжлэх 9 сараар тооцвол, ойролцоогоор 1.3 их наяд төгрөг (нийт төсвийн дэмжлэгийн 26 орчим хувь) шаардагдаж байгаа юм. КОВИД-19 цар тахлаас урьдчилсан сэргийлэх, тэмцэх төсвийн дэмжлэгийн багцын нийгмийн хамгааллын хөтөлбөрийн 80 орчим хувь


14 2020 оны 3-р сарын 11-ний өдөр Монголбанк бодлогын хүүгээ 11-ээс 10 хувь болгон, банкуудын төгрөгийн заавал байлгах нөөцийн хэмжээг 8.5 хувь болгон тус тус бууруулж, хүүний коридорыг бодлогын хүүнээс +/- 1 нэгж хувиар тогтоосон. Нөөцийн доод хэмжээг ийнхүү бууруулснаар банкны системд хөрвөх чадвартай 324 тэрбум төгрөгийн (ДНБ-ний 0.8 хувь) эх үүсвэрийг чөлөөлсөн. 3-р сарын 18-нд Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороо хамтран зарим журмуудын тодорхой зохицуулалт, зээлийн ангилал, бүтцийг тодорхой нөхцөлтэйгээр түр хугацаагаар мөрдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн.

15 1USD=2850MNT



нь хүүхэд бүрт олгох мөнгөн тэтгэмжийг нэмэгдүүлэх<sup>16</sup> хөтөлбөр юм. Сар бүр хүүхэд бүрт олгодог мөнгөн тэтгэмж 20,000 төгрөг байсныг 2020 оны 4-р сард 30,000 төгрөг болгон нэмэгдүүлсэн бөгөөд улмаар 5-р сараас эхлэн хүүхэд бүрт 100,000 төгрөг (35 доллар) олгохоор болгож нэмэгдүүлсэн. Мөн Монгол Улсын Засгийн газраас ядуу өрхүүдэд олгодог хүнсний талон 18,000 төгрөг байсныг 36,000 төгрөг болгон нэмэгдүүлсэн. Түүнчлэн төрийн албан хаагчдын цалинг 2020 оноос нэмэгдүүлэх шийдвэрийг КОВИД-19 цар тахал дэгдэхээс өмнө буюу 2019 оны 11-р сард Монгол Улсын Засгийн газраас гаргасан байв. 2020 онд нийгмийн хамгаалалд зарцуулах нийт зардлын дүнг Зураг 1-д үзүүлэв.<sup>17</sup>

**Зураг 1. КОВИД-19 цар тахлын үеийн буюу 2020 оны Нийгмийн хамгааллын зардал, сараар**



Эх үүсвэр: ҮСХ-ны мэдээлэл, 2020

2020 оны эхний 9 сард ДНБ-ий үйлдвэрлэл буурсан хэдий ч эцсийн бодит хэрэглээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.1 хувиар (ҮСХ, 2020) өссөн нь засгийн газрын тусламжийн багцтай ихээхэн холбоотой байна. Гэсэн хэдий ч бүтэн жилийн хугацаанд хүн амын хэрэглээ дөнгөж 2.7 хувиар өссөн байгаа нь 2020 оны сүүлийн улиралд хэрэглээ ихээхэн хэмжээгээр буурсантай холбоотой юм (ҮСХ, 2021).

Энэхүү судалгаандаа бид Монгол Улсын хүн амын хэрэглээ, ядуурал, тэгш бус байдалд КОВИД-19 цар тахлын хямрал хэрхэн нөлөөлснийг 2020 оны Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-ын цахим төлбөрийн бүртгэлийн системийн Их

<sup>16</sup> КОВИД-19 цар тахалтай тэмцэх төсвийн дэмжлэгийн хөтөлбөрөөс өмнө Монгол Улс хүүхэд бүрт багахан хэмжээний мөнгөн тэтгэмжийг (сард 20000 төгрөг, 7 ам. доллартай тэнцэх хэмжээний) сар бүр олгож байсан.

<sup>17</sup> Хүүхдийн мөнгийг 18 хүртэлх насны хүүхэд бүрт олгодог. Сар бүрийн хүүхдийн мөнгөн тэтгэмж 30,000 төг байсныг 2020 оны 5-р сараас эхлэн 100,000 төг (35 орчим ам.доллар) болгож нэмэгдүүлсэн бөгөөд 4-р сард олгосон хүүхэд бүрийн 30,000 төг дээр зөрүүг (70000 = 100,000-30,000) нь мөн нэмж олгосон байна. Тэгэхлээр 5-р сард хүүхдийн мөнгөнд төсөвлөсөн нийт зардалд 5-р сард хүүхэд бүрт ногдох 100,000 төг дээр нь 4-р сард хүүхэд бүрт ногдох 70,000 төг-ийг нэмж тусгажээ. Ингээд 2020 оны 5-р сараас хойш хүүхдийн мөнгөний зарцуулалт тогтвортой болсон байна.

өгөгдлийг ашиглан судлах зорилго тавьсан билээ. Ингэснээр хүн амын хэрэглээ, ядуурал, тэгш бус байдал, тэдгээрт үзүүлэх цар тахлын хямралын нөлөөлөл зэргийг өнөөг хүртэл ашиглаж ирсэн өрхийн судалгааны аргаас илүү шуурхай, илүү ойрхон давтамжтайгаар хийх боломжтой болж байгаа юм. Ийм нарийвчилсан дүн шинжилгээний үр дүн нь бодлого шийдвэр гаргагчдад өөрсдийн гаргасан шийдвэрээ нийгмийн хамгаалал, нийгмийн эрүүл мэнд, ядуурал, тэгш бус байдалд хэрхэн нөлөөлж байгааг илүү сайн харж ойлгох боломж олгоно гэж үзэж байна. Энэхүү аргачлалыг уламжлалт мэдээлэл цуглуулах боломж нөхцөл нь хязгаарлагдаж байгаа өнөө үед ядуурал, тэгш бус байдал, хямралын нөлөөллийг задлан шинжлэх шинэлэг арга замыг эрэлхийлж буй бусад улс оронд ч хэрэгжүүлэх боломжтой юм.

Иймээс Үндэсний статистикийн хороо, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Монгол Улс дахь суурин төлөөлөгчийн газар, Бангкок дахь Бүсийн төв, Монгол Улсын Их Сургуулийн судлаачид, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн мэдээллийн шинжээчид (цаашид, энэхүү тайланд Татварын мэдээллийн төв гэнэ) хамтран судалгааны нэг баг болж ажилласан болно.

Уг судалгааг хийх явцад дараах асуудалд хариу олохыг бид зорьсон болно. Үүнд:

1. КОВИД-19 цар тахлын хямралын үед Монгол Улсын хүн амын нийт хэрэглээ болон хэрэглээний төрөл ангилал хэрхэн өөрчлөгдөв?
2. КОВИД-19 цар тахлын хямралын үед Монгол Улсын хүн амын хэрэглээнд өрхийн тэргүүний хүйс, байршил, орлогын түвшингээс хамаарч ялгаа гарав уу?
3. КОВИД-19 цар тахлын хямралын үед хэрэглээгээр нь тооцсон ядуурал, тэгш бус байдал өрх болон хувь хүний түвшинд хэрхэн өөрчлөгдөв?
4. Өрхийн судалгаа болон Их өгөгдлийг ашиглан тооцсон тэгш бус байдлын үзүүлэлтүүдийн хооронд ямар ялгаа байна вэ?
5. Цаашдын тооцоололд ашиглах нийт хүн амыг төлөөлөх чадвартай өгөгдлийг бүрдүүлэхийн тулд Нэмэгдсэн өртгийн албан татварын цахим төлбөрийн бүртгэлийн систем болон Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа/HSES-ны тоо мэдээллийг жинлэх аргыг хэрхэн боловсруулах вэ?

Энэхүү судалгаанд, НӨАТ-ын цахим төлбөрийн бүртгэлийн системийн Их өгөгдлөөс тооцсон зардлаар хүн амын хэрэглээг орлуулан тооцсон болно.

Энэхүү тайлангийн бусад бүлгийг дараах байдлаар бэлтгэлээ. Бүлэг 2-т Монгол Улсын Их өгөгдлийн талаарх суурь мэдээллийг өгүүлнэ. Бүлэг 3-т статистикийн шинжилгээний үр дүнг оруулсан. Бүлэг 4-т КОВИД-19 цар тахлын хямралын үед хүн амын зардал, ядуурал, тэгш бус байдалд ямар өөрчлөлт гарч байгаа тухай танилцуулна. Бүлэг 5-д дүгнэлт өгнө. Мэдээллийн боловсруулалт, зардал, ядуурал, тэгш бус байдлын тооцооллын арга зүй, аргачлалын талаарх нэмэлт мэдээллийг Хавсралтад оруулсан болно.

## БҮЛЭГ 2. ИХ ӨГӨГДЛИЙН ТАЛААРХ СУУРЬ ОЙЛГОЛТ

Их өгөгдлийг тодорхойлохдоо ихэвчлэн тухайн мэдээллийн сангийн тоо мэдээллийн багтаамж (их хэмжээний тоо мэдээлэл), төрөл ангилал (маш олон төрлийн тоо мэдээллүүд, тодорхой бүтэц, зохион байгуулалтгүй тоо мэдээллүүд), хурдан шуурхай байдал (тоо мэдээллийг цуглуулж буй хурд) зэргийг нь харгалзаж байна. Сүүлийн жилүүдэд олон нийтэд тэр бүр нийтлэгдээд байдаггүй тоо мэдээллүүд, түүний дотор Их өгөгдлийг эдийн засгийн судалгаанд ашиглах хандлага эрс нэмэгдэж байна (Einav and Levin, 2014).

Монгол Улсад хөгжүүлсэн НӨАТ-ын цахим төлбөрийн бүртгэлийн систем нь дээрх Их өгөгдлийн шинжийг хангаж байгаа бөгөөд хэрэглэгчид болон бизнес эрхлэгчдийн худалдан авалтын ажил үйлчилгээ хийгдэх тутамд автоматаар тус системд төлбөрийн мэдээлэл цугларч байдаг. Хэрэглэгчид цахим төлбөрийн бүртгэлийн E-баримт системд төлбөрийн баримтаа минут тутамд бүртгэж байна. Зөвхөн 2020 онд л гэхэд нийтдээ 931 сая E-баримтыг хэвлэжээ.

Монгол Улсад НӨАТ-ыг борлуулалтын үнийн дүнгийн 10 хувиар тооцож байгаа бөгөөд энэ нь татварын орлогын хамгийн том эх үүсвэр төдийгүй татварын нийт орлогын 25 орчим хувийг бүрдүүлж байна. Монгол Улсын Их Хурлаар 2015 оны 7-р сард НӨАТ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. НӨАТ төлөгчөөр бүртгүүлэх босгыг нэмэгдүүлэхийн<sup>18</sup> зэрэгцээ энэ босгоос дээш орлоготой нийт бизнес эрхлэгчид ПОС (POS) терминал машин ашиглан бүх борлуулалтаа нэгдсэн системд бүртгүүлж байхаар хуульчилж өгсөн. Хуулийн дагуу эцсийн хэрэглэгчид болох НӨАТ төлөгчдөд хонжворт сугалааны систем, НӨАТ-ын 20 хувийн буцаан олголтын системийг нэвтрүүлж<sup>19</sup>, хэрэглэгчдийн зүгээс жижиглэнгийн худалдаа эрхлэгчдээс ПОС терминал машинаар хэвлэсэн төлбөрийн баримт шаардахад түлхэц болсон юм.

Холбогдох хуулийн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар E-баримт гэж нэрлэгдэх болсон цахим төлбөрийн баримтын бүртгэлийн нэгдсэн системийг хөгжүүлж улс даяар ПОС терминал машиныг ашиглаж эхэлсэн. ПОС терминал машин борлуулалтын гүйлгээг уншиж бүртгэх мөчид E-баримтын систем нь өвөрмөц QR кодыг ПОС терминал машин руу илгээнэ. Хэрэглэгчид худалдан авалтаа бүртгүүлэхийн тулд төлбөрийн баримтынхаа QR кодыг сканнердан уншуулах боломж бүхий цахим төлбөрийн бүртгэлийн (ebarimt) аппликейшныг утсандаа суулгасан байна. Хэрэглэгчид суулгасан аппликейшндаа төлбөрийн баримтын QR кодыг уншуулагч уг систем нь хэрэглэгчийн бүртгэлийг борлуулагчийн бүртгэлтэй нэгтгэн гүйлгээ бүрт хоёр бичилт үүсгэнэ.<sup>20</sup>

<sup>18</sup> Монгол Улсын Их хурлаас баталсан 2015 оны НӨАТ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу хуулийн этгээдийн жилийн нийт борлуулалт 50 сая төгрөгөөс (буюу 2020 оны 12-р сарын ханшаар 18,868 ам.доллар) давсан тохиолдолд НӨАТ төлөх үүрэгтэй. 2015 оноос өмнө НӨАТ төлөх нийт борлуулалтын босго түвшин 10 сая төгрөг байсан бөгөөд НӨАТ-ын хувь хэмжээ ч мөн 10 хувь байжээ.


<sup>19</sup> Борлуулалтын үнийн дүнгийн 10 хувь болох НӨАТ-ын 20 хувь гэдэг нь худалдан авалтын 2 хувь юм.

<sup>20</sup> Гэхдээ хэвлэсэн баримтын тоо (борлуулагчдын) нь сканнердаж системд бүртгүүлсэн баримтын тооноос (хэрэглэгчдийн) үргэлж олон байгаа ч, аажмаар зөрүү нь багасч байна. Тухайлбал, 2017 онд нийт хэвлэсэн баримтын тоо сканнердсан баримтын тооноос хоёр дахин олон байсан бол энэ зөрүү 2017 онд 60 орчим хувь, 2018 онд 49 орчим хувь болж буурчээ.

Цахим төлбөрийн бүртгэлийн системийг нэвтрүүлснээс хойш эхэндээ нийт төлөгдсөн НӨАТ-ын 20 хувийн буцаан олголтыг хэрэглэгч бүрт жил бүрийн эцэст илгээж байсан бол 2020 оноос хойш улирал бүрийн эцэст илгээх болсон. Хэрэглэгчид татварын буцаан олголтыг өөрийн банкин дахь бүртгэлтэй дансандаа автоматаар хүлээн авч байна. Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газраас 20 мянгаас 50 сая хүртэлх төгрөгийн хонжворт сугалааг улирал бүр цахимаар зохион байгуулж байна. Хонжворт сугалааны систем нь дараах байдлаар ажиллана. Тухайлбал, хонжворт сугалааны систем нь ялагчийг санамсаргүй түүврийн аргаар сонгож, хожлын тухай мэдэгдлийг E-баримтын аппликейшнаар илгээж, тодорхой хэдэн өдрийн дараа хонжворын мөнгө ялагчийн банкны данс руу шилжнэ.

Зураг 2. E-баримт системд бүртгүүлэх заавар

Алхам 1.



E-баримт аппликейшныг өөрийн гар утас буюу компьютертоо татаж суулгана.

Алхам 2.



E-баримт аппликейшнд төлбөрийн баримтынхаа QR кодыг уншуулах, аль эсвэл сугалааны дугаарыг бичиж оруулна

Алхам 3.



Хичнээн баримт бүртгүүлсэн, хичнээн нь нэгтгэлд орсныг аппликейшн харуулна.

Хууль эрх зүйн болон захиргааны арга хэмжээг хослуулан авч хэрэгжүүлснээр Татварын Мэдээллийн Төвийн удирдаж байгаа НӨАТ-ын E-баримт систем сүүлийн жилүүдэд хурдацтай өргөжин тэлж байна. Шинэчлэгдсэн хууль хэрэгжиж эхлэхээс өмнө тус улсад ердөө 12,000 орчим ПОС терминал машиныг ашиглаж байсан бол 2020 оны эцэс гэхэд уг машины тоо дөрөв дахин нэмэгдэж 54,677 болжээ.

Үүний үр дүнд татварын бааз суурь өргөжин тэлсэн. 2015-2019 оны хооронд НӨАТ-ын орлого 136 хувиар өссөн (нэрлэсэн үнээр), нийт татварын орлогод НӨАТ-ын орлогын эзлэх хувь 20.5 хувиас 25.5 хувь болж өссөн (ҮСХ, 2021).

Энэхүү судалгаа нь ҮСХ-ноос 2018 онд явуулсан өрхийн судалгаа (2018 оны ӨНЭЗ-ийн түүвэр судалгаа)-ны түүвэрт хамрагдсан өрхүүдийн Е-баримт систем ашиглалтын түвшинг тооцох боломжийг бидэнд олгосон юм. Хүснэгт 1-ээс харахад 2018 оны ӨНЭЗ-ийн судалгааны түүвэрт хамрагдсан нийт өрхөөс 43.7 орчим хувь нь<sup>21</sup> 2016 онд Цахим төлбөрийн бүртгэлийн системийг хэрэгжүүлж эхлэх үед төлбөрийн баримтаа бүртгүүлж байсан буюу бүртгэлийн дугаар нь ӨНЭЗС-2018-ныхтай тохирч байгаа бол 2020 он гэхэд энэ хувь 71.3 хувь болж өсчээ. ӨНЭЗ-ийн 2018 оны судалгааны түүвэр нь үндэсний болон орон нутгийн түвшинд төлөөлөх чадвартай тул энэ үзүүлэлтээр нийт өрхийн хэдэн хувь нь Е-баримт системийг ашиглаж байгааг ойролцоогоор тооцох боломжтой.

Үүнээс гадна Е-баримт системийн ашиглалтын түвшинг хүн амын байршлаар судаллаа. ӨНЭЗ-ийн 2018 оны судалгааны түүвэрт орсон өрхүүдийн мэдээллээс үзэхэд 2020 онд Улаанбаатар хотын (нийслэл) нийт өрхийн 80.2 хувь нь Е-баримт аппликейшн-ыг ашиглаж, төлбөрийн баримтаа уг системд бүртгэсэн байна. Үүний нэгэн адил аймгийн төвийн өрхийн 76.4 хувь, сумын төвийн өрхийн 65.5 хувь, хамгийн сонирхолтой нь хөдөө орон нутгийн өрхийн 47.7 хувь (дийлэнх нь малчин өрхүүд) нь төлбөрийн баримтаа Е-баримт системд бүртгэж байжээ.<sup>22</sup>

**Хүснэгт 1. НӨАТ-ын цахим төлбөрийн бүртгэлийн Е-баримт системд хамрагдалт**

	Нийт	Байршил			
		Улаанбаатар	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө
2016	43.7%	60.1%	48.5%	29.2%	10.9%
2017	51.3%	66.7%	57.4%	38.4%	17.5%
2018	59.5%	73.0%	65.8%	49.5%	27.0%
2019	64.7%	76.3%	70.1%	56.3%	36.4%
2020	71.3%	80.2%	76.4%	65.5%	47.7%

**Санамж:** ӨНЭЗ-ийн 2018 оны судалгааны түүвэртэй тохирсон өрхийн хувь – НӨАТ-ын цахим төлбөрийн бүртгэлийн Е-баримт системээс бүртгэлийн дугаар нь олдсон ӨНЭЗС-2018-нд хамрагдсан өрхүүд (дэлгэрэнгүй мэдээллийг 2.2-р хэсгээс үзнэ үү).

**Эх үүсвэр:** ӨНЭЗ-ийн 2018 оны судалгаа, НӨАТ-ын Е-баримт системийн мэдээлэлд үндэслэсэн судлаачдын тооцоо

<sup>21</sup> Энэ болон дараагийн хэсэгт “ӨНЭЗ-ийн 2018 оны судалгааны түүвэртэй тохирсон өрх” гэж нэрлэнэ. ӨНЭЗ-ийн 2018 оны судалгааны түүвэртэй тохирсон өрх гэдэг нь ӨНЭЗ-ийн 2018 оны судалгааны түүвэрт хамрагдсан бөгөөд Бүртгэлийн өвөрмөц дугаарыг нь Е-баримт системд тохируулж олох боломжтой өрхүүд (ӨНЭЗ-ийн 2018 оны судалгаанд хамрагдсан нийт 16646 өрхийн 13733 нь ийм өрхүүд байна) юм. Нэмэлт тайлбарыг 2.2-р хэсгээс үзнэ үү.

<sup>22</sup> Аймгийн төв нь мужтай дүйцэхүйц засаг захиргааны томоохон нэгжийн төв юм. Сумын төв нь тосгон/дүүрэгтэй дүйцэхүйц засаг захиргааны нэгжийн төв болно. Хөдөөгийн хүн ам гэдэг нь суурин газарт амьдардаггүй, өөрөөр хэлбэл нүүдэллэн амьдардаг малчид юм. Улаанбаатар хот болон аймгийн төвүүд нь хот суурин газар гэсэн ангилалд хамаарах бөгөөд сумын төв, хөдөө орон нутаг нь хөдөө гэсэн ангилалд хамаарна.

НӨАТ-ын Их өгөгдөл тусгайлсан нууцлалтай учир олон нийтэд мэдээлдэггүй. Үүний зэрэгцээ бодлого шийдвэр гаргахад ашиглаж болох маш баялаг мэдээллийг агуулж байдаг. Энэхүү мэдээллийн сан нь КОВИД-19 цар тахлын хямралын уршиг нөлөөг арилгахад чиглэсэн төсвийн дэмжлэгийн арга хэрэгсэлийг тодорхойлохоос гадна, татварын холбогдолтой арга хэмжээний үр нөлөөг илүү сайн ойлгох, улмаар татварын бааз суурийг өргөжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм.

Тус судалгааны онцлог нь Их өгөгдлийг судалгаа шинжилгээнд ашиглаж буй анхны тохиолдол болж байна. Судалгааны багийн гишүүд бид энэхүү Их өгөгдлийг боловсруулах аргачлалыг хөгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг сайтар дагаж мөрдөн, мэдээллийн нууцлалыг чандлан хамгаалж, аюулгүй байдлыг нь хангахын зэрэгцээ ул суурьтай нарийвчилсан дүн шинжилгээ хийж, бодитой үр дүн гаргахын тулд хангалттай хэмжээний өгөгдлийг ашиглах зорилт тавьсан болно. Энэхүү аргачлалын талаар дараагийн бүлэгт дэлгэрэнгүй өгүүлнэ.

### **БҮЛЭГ 3. СТАТИСТИКИЙН ШИНЖИЛГЭЭ**

Хүснэгт 2-т бид ӨНЭЗ-ийн 2018 оны судалгааны түүвэрт хамрагдсан нийт өрхүүд болон Их өгөгдлийн түүвэрт орсон өрхүүдийн статистик үзүүлэлтүүдийг харьцуулсан шинжилгээний дүнг үзүүлээ. Түүвэрлэлтийн эдгээр хоёр багцад хамрагдсан өрхүүдийн төлөв байдлын талаарх мэдээллийг ӨНЭЗ-ийн 2018 оны судалгааны мэдээллээс авсан болно.<sup>23</sup> Энэхүү харьцуулсан шинжилгээгээр Их өгөгдлийн түүвэрт хамрагдсан өрхүүдийн төлөв байдал нь ӨНЭЗ-ийн 2018 оны судалгааны түүвэрт хамрагдсан өрхүүдийнхээс ямар ялгаатай болохыг судалсан.

ӨНЭЗ-ийн 2018 оны судалгааны нийт түүвэрт болон Их өгөгдлийн түүвэрт хамрагдсан өрхүүдийн аль алиных нь өрхийн тэргүүний насны байдал тун төстэй байсан боловч тэдгээрийн хүйс, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн байдал зэрэг бусад шинж төлөв нь ялгаатай байна. ӨНЭЗ-ийн 2018 оны судалгааны түүвэрт хамрагдсан өрхүүдийг ажиглахад эрэгтэй тэргүүнтэй өрхийн гишүүд, хөдөлмөр эрхэлдэг, боловсрол сайтай тэргүүнтэй өрхийн гишүүд, ерөнхийдөө өрхийн доторх арай залуу гишүүд зэрэг нь төлбөрийн баримтаа Е-баримт системд түлхүү бүртгүүлж байна.

<sup>23</sup> Их өгөгдлийн түүвэр нь тухайн хувь хүний хамаарах өрх болон тухайн өрхийн шинж төлөвийн талаарх тоо мэдээллийг агуулдаггүй.

**Хүснэгт 2. ӨНЭЗ-ийн 2018 оны судалгаа болон Их өгөгдлийн түүвэрт хамрагдсан өрхүүдийн статистикийн үзүүлэлтүүд**

	ӨНЭЭС 2018	НӨАТ 2018-2020
Нийт өрх	16,454	4,463
<b>Өрхийн тэргүүний хүйс</b>		
Эрэгтэй	75.5%	81.5%
Эмэгтэй	24.5%	18.5%
Өрхийн тэргүүний нас	46.6	44.5
<b>Өрхийн тэргүүний боловсролын түвшин</b>		
Боловсролгүй	3.6%	1.0%
Бага	8.2%	2.8%
Суурь	14.3%	10.5%
Бүрэн дунд	24.7%	26.8%
Техник, мэргэжлийн	17.2%	19.7%
Техникум	7.3%	7.8%
Дипломтой	7.4%	9.1%
Бакалаврын зэрэгтэй	14.9%	19.3%
Мастер, Докторын зэрэгтэй	2.3%	3.1%
<b>Өрхийн тэргүүний хөдөлмөр эрхлэлтийн байдал</b>		
Хөдөлмөр эрхэлдэг	67.0%	76.5%
Ажилгүй	6.0%	5.2%
Суралцаж байгаа	0.4%	0.2%
Ахмад настан	19.7%	12.2%
Хөгжлийн бэрхшээлтэй	3.3%	2.2%
Гэрийн ажилтай, бусдыг асардаг	2.1%	2.0%
Бусад шалтгаанаар хөдөлмөр эрхэлдэггүй	1.4%	1.6%

*Санамж: бүх тооцоо жинэлсэн.*

*Эх үүсвэр: Судлаачийн тооцоо*

Үүний нэгэн адил Их өгөгдлийн түүвэрт хамрагдсан өрхүүдийн орлого, зарлагын үзүүлэлтүүд нь ӨНЭЗ-ийн 2018 оны судалгаанд хамрагдсан өрхүүдийнхээс ялгаатай байгааг статистикийн шинжилгээ харуулж байна.<sup>24</sup> Хүснэгт 3-аас харахад Их өгөгдлийн түүвэрт хамрагдсан өрхүүдийн дундаж орлого, зарлага ӨНЭЗ-ийн 2018 оны судалгаанд хамрагдсан өрхүүдийнхээс арай өндөр байна. Хэдийгээр эдгээр үзүүлэлтүүдийн стандарт хазайлт их байгаа ч хоёр дундажийн хооронд статистикийн хувьд ач холбогдол бүхий ялгаа ажиглагдахгүй байна.

<sup>24</sup> Статистикийн шинжилгээний энэ хэсэгт үзүүлсэн орлого, зарлагын мэдээллийг Их өгөгдлөөс тооцоогүй болно. Харин ӨНЭЗ-ийн 2018 оны судалгааны нийт түүвэр (16454 өрх) болон Их өгөгдлийн түүвэр (4463 өрх)-ийн орлого, зарлагын үзүүлэлтүүдийг ӨНЭЗ-ийн судалгаанаас авч ашигласан болно.

Хүснэгт 3. ӨНЭЗС-2018 болон Их өгөгдлийн түүвэрт хамрагдсан өрхүүдийн орлого, зарлагын үзүүлэлтүүдийн ялгаа

	ӨНЭЗС-2018 (n=16454)*	НӨАТ Их өгөгдөл, түүвэр (n=4463)**
<b>Нэг хүнд ногдох орлого, Төгрөг, сараар</b>		
Дундаж	330,901	344,930
Стандарт хазайлт	(285,792)	(292,027)
<b>Нэг хүнд ногдох зарлага, Төгрөг, сараар</b>		
Дундаж	347,617	373,781
Стандарт хазайлт	(262,569)	(265,152)


Эх үүсвэр: Судлаачдын тооцоо

Санамж: Дундаж болон стандарт хазайлтын үзүүлэлтүүд нь жигнэсэн индексүүд болно.

\* ӨНЭЗ-ийн судалгааны жинг ашиглав \*\*Их өгөгдлийн түүврийн жинг ашиглав

Зураг 3-т дээрх хоёр мэдээллийн эх сурвалжаас тооцсон нэг хүнд ногдох зарлагын тархалтын нягтралаас харахад Их өгөгдлийн түүвэрт хамрагдсан өрхүүдийн зарлага арай өндөр байгаа бөгөөд ӨНЭЗ-ийн 2018 оны судалгаанд хамрагдсан нийт өрхүүдтэй харьцуулахад амьдралын түвшин нь арай илүү мэт ажиглагдаж байна.

Зураг 3. ӨНЭЗС-2018 болон Их өгөгдлийн түүвэрт хамрагдсан өрхүүдийн зарлагын тархалт



Эх үүсвэр: Судлаачдын тооцоо



## БҮЛЭГ 4. ҮР ДҮН<sup>25</sup>


Энэ хэсэгт КОВИД-19 цар тахлын дэгдэлтийн үед өрхийн хэрэглээ, ядуурал, тэгш бус байдал хэрхэн өөрчлөгдсөнийг Их өгөгдлийн түүвэрт хамрагдсан өрхүүдийн мэдээллийг үндэслэн судалж гаргасан үр дүнг танилцуулж байна.

### 4.1 КОВИД-19 цар тахлын дэгдэлтийн үед өрхийн зарлагад гарсан өөрчлөлт

Бид судалгааныхаа зорилт болгон тодорхойлсон таван асуултын эхнийх нь Монгол Улсад КОВИД-19 цар тахлын дэгдэлтийн үед хүн амын нийт хэрэглээ, хэрэглээний төрөл ангилал хэрхэн өөрчлөгдсөнийг судлах байв. Бид хүн амын хэрэглээг орлох гол үзүүлэлт болгон зарлагын үзүүлэлтүүдийг тооцсон. Хүн амын жилийн дундаж зарлага 2020 онд зэрэгцүүлэх үнээр 3 хувиар өссөн нь эерэг өөрчлөлт мэт боловч 2019 оны жилийн дундаж зарлагын өсөлт 10 хувь байсантай зэрэгцүүлбэл нилээд бага хэвээр байна. Ийнхүү зарлагын өсөлт удааширсан нь КОВИД-19 цар тахлын дэгдэлтээс шалтгаалсан байна. Өрхийн зарлагыг сараар задлан шинжилж үзвэл өрхийн зарлагын өөрчлөлтийн чиг хандлагыг нарийвчлан харж болох билээ.

2020 оны 1-р сард хүн амын дундаж зарлага 2019 оны 1-р сарын мөн үеийнхээс 3 хувиар буурсан байна. 2020 оны 2-р сард Билгийн тооллын Сар шинийн баяр болохтой холбогдуулан Засгийн газраас хатуу хөл хорио тогтоосон хэдий ч хүн амын дундаж зарлагын хэмжээ 2019 оны 2-р сарын мөн үетэй харьцуулахад 13 хувиар өссөн байна.<sup>26</sup> Гэхдээ 2020 оны 3-р сард дундаж зарлага 2019 оны 3-р сарын мөн үетэй харьцуулахад 9 хувиар буурч, КОВИД-19 цар тахлаас сэргийлж тогтоосон хатуу хөл хорионы нөлөө гарч эхэлсэн байна. (Зураг 4-ийн а хэсгийг үзнэ үү).

Зураг 4. Өрхийн зарлагын өөрчлөлтийн чиг хандлага, сараар, 2018-2020



(a) Дундаж зарлага

(b) Медиан зарлага

<sup>25</sup> Энэ бүлэгт ашигласан зарлага (зардал)-тай холбоотой бүх тооцоог хийхдээ, хэрэв өөрөөр заагаагүй бол, инфляц (суурь үе = 2018 оны 1-р сар)-ын өөрчлөлтийг тооцсон өрхийн түвшний нэг хүнд ногдох сарын зарлагыг үндэслэв. Түүнчлэн, Монгол Улсын хүн амын хэрэглээ улирлаар ихээхэн хэлбэлзэлтэй байдаг учир ихэнх өөрчлөлтийг жилээр тооцсон.

<sup>26</sup> 2019 оны Цагаан сар 2-р сарын эхэнд (2-р сарын 5-7) байсан бол 2020 онд 2-р сарын сүүлчээр (2-р сарын 24-26) байв. Ихэвчлэн хүмүүс Цагаан сар болохоос өмнөх хоёроос дөрвөн долоо хоногийн туршид баярт бэлтгэж эхэлдэг билээ. Иймээс 2019 онд Цагаан сарын бэлтгэл зардал 1-р сард илүү нэмэгдэж байсан бол 2020 оных 2-р сард илүү байсан ажээ.

2020 оны 3-р сарын 27-нд төсвийн дэмжлэгийн арга хэмжээ авах талаар зарлагдсанаар өрхийн зарлага 2019 оны 4-р сартай харьцуулахад 2020 оны 4-р сард буураагүй байна.<sup>27</sup> Улмаар хүүхдийн мөнгөн тэтгэмж 3 дахин нэмэгдсэн бөгөөд өрхүүд 2020 оны 5, 6, 7-р саруудад илүү их мөнгө зарцуулж эхэлсэн (өмнө жилийн мөн үеэс) төдийгүй 2020 оны 10-р сард өрхийн зарлага 20 хувиар өссөн (өмнө жилийн мөн үеэс) байна. Гэсэн хэдий ч 2020 оны 11-р сарын 11-ний өдрөөс эхлэн халдвараас сэргийлэн дахин хатуу хөл хорио тогтоож эхэлсэн тул өрхийн зарлага 11, 12-р сард (өмнө жилийн мөн үеийнхээс) 11 хувиар буурсан байна.

Медиан/голч зарлагын үзүүлэлтэд гарсан өөрчлөлтийн хандлага ижил төстэй байсан хэдий ч далайцын хувьд бага байжээ (Зураг 4, б хэсгийг үзнэ үү). 2020 оны 1-р сард медиан зарлага 2 хувиар буурсан (өмнөх жилийн мөн үеийнхээс) байна. Цагаан сарын нөлөөгөөр медиан зарлага 2020 оны 2-р сард нэмэгдсэн хэдий ч буцаад медиан зарлага 2019 оны 3-р сарын мөн үетэй харьцуулахад 1 хувиар буурсан байна. КОВИД-19-ын хямралын анхны том цочролын дараа буурч байсан нэг хүнд ногдох зарлага 4-р сараас эхлэн эргээд өсч эхэлжээ. Өмнөх жилийн мөн үеийнхтэй харьцуулахад зарлагын өсөлт 5-р сараас нэмэгдэж эхэлсэн байна. Үүнээс хойшхи саруудад өрхийн зарлага өмнөх оны мөн үеийнхээс өндөр болж байв. 11-р сараас эхэлсэн хоёр дахь хатуу хөл хорио хүртэл энэ хандлага үргэлжилсэн хэдий ч медиан зарлага өмнөх оны мөн үеийнхээс эргээд 5 хувиар буурчээ. 2020 оны 12-р сард медиан зарлага өмнөх жилийн мөн үеийнхтэй харьцуулахад өөрчлөлтгүй буюу тэг хувьтай болсон байна. Иймээс 11-р сард медиан зарлага дундаж зарлагаас доош ортол буурсан бөгөөд 12-р сард дундаж зарлага буурахын хэрээр медиан зарлага бага зэрэг нэмэгджээ.

Судалгааны үр дүнгээс харахад Монгол Улсын эдийн засгийн үйл ажиллагаа ерөнхийдөө суларсан хэдий ч хүн амын хэрэглээг өмнөх жилийнхтэй харьцуулахад 2020 оны хатуу хөл хорио тогтоосон цөөхөн саруудад л буурчээ.<sup>28</sup> КОВИД-19 цар тахлын хямрал нь 2-р сараас бусад үед буюу анхны болон хоёр дахь удаагийн хатуу хөл хорионы үеүдэд хүн амын хэрэглээнд шууд буюу хүндхэн нөлөө үзүүлсэн байна.

2020 оны 4-р сарын дундуур хэрэгжүүлсэн төсвийн дэмжлэгийн арга хэмжээ болон айл өрхүүдэд үзүүлсэн тусламж дэмжлэг өрхийн зарлагад хэрхэн нөлөөлөв? Монгол Улсын Засгийн газраас нийгмийн хамгааллын тусламж дэмжлэгийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг 4-р сараас эхлэн түр түдгэлзүүлсэн билээ (Зураг 1-ийг үзнэ үү). Өрхүүд 5-р сар хүртэл нийгмийн хамгааллын тусламж дэмжлэгийн нэмэгдлийг авч эхлээгүй байсан хэдий ч өрхүүдийн нэг хүнд ногдох сарын дундаж зарлага өмнөх сараас төдийгүй өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 4-р сараас эхлэн нэмэгдсэн байна (Зураг 4-ийг үзнэ үү). Энэ нь нийгмийн хамгааллын тусламж

<sup>27</sup> Өрхүүд 5-р сар хүртэл хүүхдийн мөнгөө аваагүй байсан хэдий ч хүүхдийн мөнгийг нэмэгдүүлэх тухай шийдвэрийг 4-р сард зарласан нь тэдгээрийг урьдчилан илүү их мөнгө зарцуулахад хүргэсэн байж болзошгүй юм.

<sup>28</sup> Билгийн тооллын Цагаан сарын үе буюу 2-р сараас бусад үед.

дэмжлэгээс бусад арга хэмжээ, тухайлбал, орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг түр түдгэлзүүлсэн зэрэг нь өрхүүдийн хэрэглээний өсөлтөд хэдийнээ нөлөөлж эхэлсэн байж болзошгүй гэсэн үг юм. Түүнчлэн хараахан олгогдож эхлээгүй байсан хэдий ч нийгмийн хамгааллын тусламж дэмжлэг нэмэгдэх нь тодорхой болсон тэр үеэс өрхүүд хэрэглээгээ нэмэгдүүлж эхэлсэн байх боломжтой юм. Ингээд 2020 оны 4-р сар гэхэд өрхийн зарлага өсч эхэлсэн байна.

Медиан зарлага нь дундаж зарлагатай буюу тархалтын хамгийн доод бүлгийн зарлага (ядуу өрхийн зарлага)-тай харьцуулахад 2020 онд бага зэрэг буурсан ч эргээд нилээд хэмжээгээр нэмэгдсэн нь 2020 оны эдийн засгийн уналтад бага өртсөн гэсэн үг юм. Тухайлбал, медиан зарлага хоёр дахь хатуу хөл хорионы үед буюу 11, 12-р саруудад буураагүй байна. Энэ нь амьжиргаа сайтай өрхүүдтэй харьцуулахад ядуу болон дундаж амьдралтай өрхүүдийн зардлын эх үүсвэрийн ихээхэн хувийг нь бүрдүүлж байгаа нийгмийн хамгааллын тусламж дэмжлэг нэмэгдсэн нь эдгээр өрхийн зарлага буурахаас урьдчилан сэргийлэхэд зохих үр дүн үзүүлсэн гэсэн үг юм. Хэдийгээр ийм нөхцөл 1-3 дугаар саруудад тогтоосон хатуу хөл хорионы үед мөн адил тохиож байсан ч тоймтой яригдаагүй ажээ. Нөгөөтэйгүүр, нийгмийн хамгааллын тусламж дэмжлэгийг 4-р сард нэмэгдүүлэхээс өмнө Монгол Улсад хүүхдийн мөнгөний хөтөлбөр хэрэгжсэн хэвээр бага хэмжээгээр ч болов олгож байсныг тэмдэглэх нь зүйн хэрэг билээ.

Бидний судалгааны үр дүн АХБ-наас явуулсан судалгааны туршилтын үр дүнтэй нийцэж байгаа юм. АХБ-ны судалгаанд КОВИД-19 цар тахлын эсрэг “Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлж буй богино хугацаатай бодлогын арга хэмжээ нь ач холбогдолтой төдийгүй, эмзэг бүлгийнхэнд чиглэсэнээрээ цар тахлаас улбаалсан бусад улс орнуудад тулгарч байгаа эдийн засгийн олон сөрөг үр дагавраас сэргийлэхэд тустай байсан” (ADB, 2020) хэмээн дүгнэсэн байна.

Бидний судлах зорилт тавьсан хоёр дахь гол асуудал бол: “КОВИД-19 цар тахал дэгдэлтийн энэ үед Монгол Улсын хүн амын өрхийн хэрэглээ нь өрхийн тэргүүний хүйс, хүүхдийн тоо, байршил, орлогын түвшингээс хамаарч ялгаатай байгаа эсэх?” талаар судлах байлаа.

Монгол Улсын хүн амын орлого, хэрэглээ улирлаар ихээхэн ялгаатай байдаг билээ. Иймээс улирлын хэлбэлзлийг харгалзан үзэхийн тулд бид сараар бус жилээр өөрчлөлтийг нь судалсан.<sup>29</sup> 2019, 2020 онуудын хүн амын хэрэглээний талаарх тоо мэдээллийг инфляцийн өөрчлөлтийг нь тооцон тохируулга хийж 2018 оныхтой харьцуулах боломжтой болгосон.

<sup>29</sup> Энэ хэсэгт үзүүлсэн инфляцийн үзүүлэлт сар бүр ялгаатай байгаа нь ажиглагдаж байна.

#### 4.1.1. Өрхийн зарлага, өрхийн тэргүүний хүйсээр

Хамгийн сонирхолтой нь, Их өгөгдлийн түүвэрт хамрагдсан эмэгтэй тэргүүнтэй өрхүүдийн зарлага нь 2020 оны туршид эрэгтэй тэргүүнтэй өрхүүдийн зарлагаас (нэг хүнд ногдох сарын дундаж зарлага болон медиан зарлагын аль аль нь) өндөр байна. Гэсэн хэдий ч зарлагын өөрчлөлтийн чиг хандлага эрэгтэй, эмэгтэй тэргүүнтэй өрхүүдийн аль алинд ихэнх тохиолдолд ижил байна. Зураг 5-аас харахад Их өгөгдлийн түүвэрт хамрагдсан эмэгтэй тэргүүнтэй өрхүүдийн зарлага эрэгтэй тэргүүнтэй өрхүүдийнхээс өндөр төдийгүй, илүү өргөн тархалттай байна. Түүнчлэн ӨНЭЗ-ийн 2018 оны судалгаанд хамрагдсан өрхүүдийнхээс ялгаатай нь 2019-2020 оны дийлэнх хугацаанд хоёр үзүүлэлтийн итгэмжлэлт интервал давхцахгүй байгаа нь зарлагын зөрүү тайлангийн дийлэнх хугацаанд статистикийн хувьд чухал ач холбогдолтой байсныг харуулж байна.


Үүнд дараах шалтгаанууд нөлөөлсөн байж ч болзошгүй юм. Үүнд:

Монгол Улсад эрэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүд боловсролын түвшин илүү өндөр байна (нийт эрэгтэйчүүдийн 38.5 хувь, эмэгтэйчүүдийн 61.5 хувь нь дээд боловсролтой) (ҮСХ, 2019). Түүнчлэн, хөдөлмөр эрхлэлтийг хүйсээр болон салбараар задалж үзвэл бага цалин хөлстэй салбарт эмэгтэйчүүд илүү олноор ажиллаж байгаа хэдий ч санхүүгийн үйлчилгээ, худалдаа зэрэг өндөр цалин хөлстэй салбарт ч мөн олноор ажиллаж байна. Иймээс бусад олон улс оронтой харьцуулахад монгол эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн авч байгаа цалин хөлсний ялгаа харьцангуй бага байж ч болох юм.

Мөн Их өгөгдлийн түүвэрт хамрагдсан өрх толгойлсон эмэгтэйчүүдийн дунд амжиргаа сайтай хэсэг нь ядуу эмзэг бүлгийнхнээс илүү олон байна. Бид НӨАТ-ын систем дэх зарлагын мэдээлэлд үндэслэсэн Их өгөгдлийн түүврээс тооцсон өрхүүдийн зарлагын мэдээллийг ӨНЭЗС-2018-нд хамрагдсан өрхүүдийн зарлагын мэдээлэлтэй харьцуулж үзэхэд НӨАТ-ын Их өгөгдлийн түүвэр болон ӨНЭЗС-ны зарлагын харьцаа дунджаар эмэгтэй тэргүүнтэй өрхийнх 96.2 хувь байгаа бол эрэгтэй тэргүүнтэй өрхийнх ердөө 64.6 хувь байна. Эндээс харахад эмэгтэй тэргүүнтэй өрхүүд эрэгтэй тэргүүнтэй өрхүүдтэй харьцуулахад төлбөрийн баримтаа НӨАТ-ын Е-баримт системд илүү бүрэн бүртгүүлж байгаа нь ажиглагдаж байна.

Эдгээр шалтгааны улмаас, эрэгтэй, эмэгтэй тэргүүнтэй өрхүүдийн зарлагын өөрчлөлтийг зардлын үнэмлэхүй түвшинтэй харьцуулах нь илүү учир утгатай үзүүлэлт болж байна. 2020 оны туршид эмэгтэй тэргүүнтэй өрхүүдийн зарлагад эрэгтэй тэргүүнтэй өрхүүдийнхээс дутахааргүй өөрчлөлт гарсан байна.

**Зураг 5. Өрхийн дундаж зарлага, өрхийн тэргүүний хүйсээр, 2019-2020 он, итгэмжлэх интервал**



*Эх үүсвэр: НӨАТ-ын Их өгөгдлийн түүврийг үндэслэсэн судлаачийн тооцоо*


#### 4.1.2. Өрхийн зарлага, хот, хөдөөгөөр

Өрхийн зарлагыг байршлаар нь тооцсон мэдээллээс харахад хот суурин газрууд буюу нийслэл Улаанбаатар хот болон аймгийн төвийн айл өрхүүдийн зарлагын хэв шинж төстэй байгаа ч аймгийн төвийн айл өрхүүдийн зарлагын түвшин арай бага байна (Зураг 6-г үзнэ үү). Сум, хөдөө орон нутгий<sup>30</sup> айл өрхүүдийн зарлагын түвшин нь Улаанбаатар хот болон аймгийн төвийн айл өрхүүдийнхээс мөн л бага байгаа хэдий ч хэв шинжийн хувьд өөр хоорондоо ижил төстэй байгаа нь сумын төвүүдийн эдийн засаг мал аж ахуйтай нягт холбоотой болохыг харуулж байна. Хөдөө орон нутгийн айл өрхүүдийн зарлага өндөр хэлбэлзэлтэй байгааг дараах хоёр хүчин зүйлээр тайлбарлаж болох юм. Нэг талаас, хөдөөгийн нүүдэлчин малчин айл өрхүүд хэрэгцээт зүйлсээ сумын төв орох үедээ л “бөөндүүлж” худалдан авч байна; Нөгөөтэйгүүр, Их өгөгдлийн түүвэрт хамрагдсан хөдөөгийн өрхийн тоо цөөн байгаа нь хэрэглээний жигд бус хэв шинжэд нөлөөлөх магадлалтай. Өөр нэг ажиглагдсан зүйл бол БНХАУ-д цар тахалын дэгдэлт өндөр болох тэр үед Монгол Улс хилийн боомтуудаа хааж хатуу хорио цээр тогтоож байсан 2020 оны 3, 4-р саруудад хөдөөгийн айл өрхүүдийн зарлага буурсан байна. Үүнд малчид ноос, ноолуур, арьс шир гэх мэт мал аж ахуйн ашиг шим болох түүхий эдээ борлуулах боломжгүй болсон нь тэдний орлого, хэрэглээнд ихээхэн нөлөөлсөн байх талтай. Хожуу саруудад тэдгээр өрхүүдийн хэрэглээ сэргэсэн хэдий ч сум, хөдөө орон нутгийн айл өрхүүдийн хэрэглээ 11, 12-р саруудад буюу нийслэл хот, аймгийн төвүүдийн хэрэглээ буурч эхэлснээс хойш нэг сарын дараанаас дахин буурсан байна. Гэхдээ энэ бууралт хот суурин газрынх шиг тийм хүчтэй биш байжээ.

<sup>30</sup> Хөдөө орон нутгийн айл өрхүүд гэдэгт малчин өрхүүд хамаарна.

Хатуу хөл хориог Улаанбаатар хот болон цөөн тооны аймгийн төвүүдэд тогтоосон нь хөдөө орон нутгийн хэрэглээ ийнхүү хүчтэй буураагүйн үндсэн шалтгаан байж болзошгүй юм.

**Зураг 6. Өрхийн дундаж зарлага, байршлаар**



Эх үүсвэр: НӨАТ-ын Их өгөгдлийг үндэслэсэн судлаачдын тооцоо. Түүврийн хэмжээ 4463 өрх

**Хүснэгт 4. 2020 оны хоёр дахь удаагийн хөл хорионы үед Өрхийн зарлагад гарсан өөрчлөлт**

	Улаанбаатар	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө
11-р сар	-15.5%	-13.8%	-4.3%	7%
12-р сар	-15.7%	-17.6%	3%	-4.6%

Эх үүсвэр: НӨАТ-ын Их өгөгдлийг үндэслэсэн судлаачдын тооцоо. Түүврийн хэмжээ 4463 өрх

Тухайлбал, 2020 оны 11, 12-р саруудад нийслэл Улаанбаатар хотын айл өрхүүдийн зарлага 15.5 хувь, 15.7 хувиар тус тус буурсан байна.<sup>31</sup> Аймгийн төвийн айл өрхүүдийн зарлага дээрх саруудад 13.8 хувь, 17.6 хувиар тус тус буурчээ.


Медиан зарлагын өөрчлөлт нь дундаж зарлагын өөрчлөлттэй мөн төстэй байжээ. Гэхдээ медиан зарлагад гарсан өөрчлөлтийг нягталж үзэхэд хөдөөгийн өрхийн зарлага сумын төвийн өрхийнхтэй ижил төстэй хэв шинжтэйгээр өөрчлөгдөж байна.

<sup>31</sup> Нэг хүнд ногдох, дундаж зарлага

### 4.1.3. Өрхийн зарлага, хүүхдийн тоогоор

Айл өрхийн зарлагын өөрчлөлтөд хүүхдийнх нь тоо хэрхэн нөлөөлж байгааг шинжилж үзэхэд тухайн өрхийн хүүхдийн тоо олон байх тусам нэг хүнд ногдох зарлага бага байсны зэрэгцээ хүүхэдгүй өрхийн нэг хүнд ногдох зарлага хамгийн өндөр байна. Өөр ажиглалтыг ч бас хийж үзлээ. Тухайлбал, нэг хүүхэдтэй өрхийн нэг хүнд ногдох зарлага сард 250-300 мянган төгрөг байгаа бол дөрөв болон түүнээс дээш тооны хүүхэдтэй өрхийн нэг хүнд ногдох зарлага сард 100-200 мянган төгрөг болж хэлбэлзэж байна. Хүүхэд бүрт сар бүр олгож байгаа 100 мянган төгрөгийн тэтгэмжийн ашиг тус их байна. Энэ нь зарим өрхийн зарлагын 25 гаруй хувийг, зарим өрхийн зарлагын 100 хүртэл хувийг бүрдүүлж байна. 1-2 хүүхэдтэй зарим өрхийн хувьд хүүхдийн мөнгө өрхийн зарлагынх нь бүтцэд тодорхой өөрчлөлт үзүүлэхгүй байгаа нь хүүхэдгүй өрхийнхтэй төстэй байна. Жилийн эхнээс буюу хүүхдийн мөнгө болон бусад нийгмийн хамгааллын тэтгэмж тэтгэлэгийг нэмэгдүүлсэн боловч хоёр дахь удаагийн хатуу хөл хорио тогтоосон үед энэ нь хангалттай хамгаалал болж чадаагүй бөгөөд ихэнх айл өрхүүдийн зарлага, хүүхэдтэй, хүүхэдгүй нэгэн адил 11, 12-р саруудад огцом буурсан нь өмнөх жилийн мөн үеийнхээс даруй 7-16 хувиар бага болсон байна.

Зураг 7. Өрхийн зарлага, хүүхдийн тоогоор



Эх үүсвэр: Судлаачийн тооцоо

#### 4.1.4. Өрхийн зарлага, хүн амын тооны тэнцүү 5 бүлгээр

Бид мөн ӨНЭЗС-2018-ны<sup>32</sup> мэдээлэлд үндэслэн хүн амыг хэрэглээний түвшингээр нь тэнцүү таван бүлэг болгон ангилж, 2020 онд тэдгээрийн сар тутмын зарлагад гарсан өөрчлөлтийг Их өгөгдлийг ашиглан өмнөх жилийн мөн үеийнхтэй нь харьцуулж шинжилсэн (Хүснэгт 5-ыг үзнэ үү). Юуны түрүүнд, хоёр удаа тогтоосон хатуу хөл хорио нь эдгээр таван тэнцүү бүлгийн нийт өрхийн зарлагад томоохон нөлөөг шууд үзүүлсэн байгааг тогтоосон (Цагаан сарын баярын үеэр буюу 2-р сард бага зэрэг тогтворжсон). Эхний хөл хорио (1-р сараас 3-р сар) нь хамгийн ядуу хоёр бүлгийн айл өрхүүдэд илүү хүндээр туссан бол хоёр дахь удаагийн хөл хорио (11-12-р сар)-ны үед эдгээр бүлгүүдийн зарлага мэдэгдэхүйц буурсан хэвээр (11-р сард 10 хувиар, 12-р сард 8 хувиар) байсан хэдий ч гурав, дөрөв дэх бүлгийнхтэй харьцуулахад харьцангуй бага хэмжээгээр буурсан байна. Ерөнхийдөө, хоёр дахь удаагийн хөл хорио нь нийт хүн амын зарлагад эхний хөл хорионы үеийнхээс илүү хүнд туссан бөгөөд нийгмийн халамжийн дэмжлэгийг нэмэгдүүлээгүй байсан бол ядуу өрхүүдэд илүү хүнд тусахаар байсан ажээ.

Хоёрдугаарт, Засгийн газраас хатуу хөл хориог сулруулж, нийгмийн халамжийн тусламж дэмжлэгийг нэмэгдүүлэхээ мэдэгдсэн 4-р сараас эхлэн хүн амын зарлага нэмэгдэж эхэлсэн байна. Гэхдээ хамгийн ядуу бүлгийн (Q1) өрхүүдийн зарлага нийгмийн халамжийн тусламжийг хүргэж эхэлсэн 5-р сар хүртэл, харин доороосоо хоёр дахь ядуу бүлгийн (Q2) өрхүүдийн зарлага 6-р сар хүртэл нэмэгдээгүй байна. Үүнээс үзэхэд ядуу өрхүүдийн зарлага нэмэгдэхэд нийгмийн халамжийн тусламж дэмжлэг шууд нөлөөлж байгаа бөгөөд эдгээр бүлгийн өрхүүдийн зарлага 2020 оны хавар, зун, намрын саруудад өмнөх жилийн мөн үеийнхээс 8-20 хувиар нэмэгдсэн байна.

Гуравдугаарт, хамгийн ядуу хоёр дахь бүлгийн (Q2) өрхүүдийн зарлага нь, хамгийн ядуу нэг дэх бүлгийн өрхүүдийнхээс илүү буурсан байна. Тэдгээрийн өрхүүдийн зарлага зөвхөн 2020 оны 9, 10-р саруудад л КОВИД-ын өмнөх үеийнхээс өндөр байжээ. Иймээс нийгмийн халамжийн тусламж дэмжлэгийн хуваарилалт нь хамгийн ядуу бүлгийн өрхүүдийн зарлага тогтворжиход тодорхой нөлөө үзүүлсэн боловч хамгийн ядуу хоёр дахь бүлгийн (Q2) өрхүүдийн зарлагын бүтцэд дорвитой нөлөө үзүүлж чадаагүйгээр барахгүй харин ч цаг хугацаа алдахад хүргэсэн байна. Тухайлбал, 7-р сараас 10-р саруудад айл өрхүүдийн зарлага улам бүр нэмэгдэж байхад хамгийн ядуу хоёр дахь бүлгийн өрхүүдийн зарлага 9-р сар хүртэл нэмэгдээгүй байна.

Гуравдугаарт, гурав болон дөрөв дэх бүлгийн (Q3, Q4) өрхүүдийн зарлага өөр хоорондоо ижил хэв шинжтэй байсан хэдий ч хэмжээ далайц нь өөр өөр байна. Эдгээр бүлгийн өрхүүдийн сарын зарлага нь 3-р сар болон хоёр дахь удаагийн хөл хорионы үеэс бусад хугацаанд өмнөх жилийн мөн үеийнхээс өсчээ. Зарим саруудад тэдгээр айл өрхүүдийн зарлага өмнөх оны мөн үеийнхээс 32 болон 38 хувиар тус тус өссөн байна.

<sup>32</sup> Өөрөө хэлбэл, өрхүүдийг НӨАТ-ын Их өгөгдлийн түүврээс, ӨНЭЗС-2018-ны мэдээлэлд үндэслэн хүн амыг хэрэглээний түвшингээр нь тэнцүү таван бүлэгт хуваасан болно.



Дөрөвдүгээрт, хамгийн чинээлэг буюу сүүлийн бүлэг (Q5)-т хамрагдсан айл өрхүүдийн зарлага 1, 3, 5-р сарууд болон хоёр дахь хөл хорионы саруудад буурсан байна. Хэдийгээр тэд зун, намрын улиралд зарлагаа нэмэгдүүлсэн хэдий ч бусад бүлгүүдийн өрхүүдээс харьцангуй бага хэмжээгээр зарлагаа нэмэгдүүлжээ. Түүнчлэн хамгийн чинээлэг бүлгийн (Q5) зарлагын хэв шинж ихээхэн онцлог байсан бөгөөд ялангуяа хоёр удаагийн хөл хорионы үеэр зарлагаа их хэмжээгээр бууруулж, харин жилийн дундуур зарлагаа аажуухан нэмэгдүүлсэн байна.

Эцэст нь тэмдэглэхэд, хоёр дахь удаагийн хөл хорионы үеэр бүх бүлгүүд зарлагаа эрс багасгаж, нийгмийн хамгааллын тусламж дэмжлэг нэмэгдсэн хэдий ч зарлагаа 8-15 хувиар бууруулсан байгаагаас үзэхэд эдгээр дэмжлэг нь хөл хорионоос үүдэлтэй нөлөөг хангалттай арилгаагүй байна.

**Хүснэгт 5. Өрхийн дундаж зарлагын өөрчлөлт, 2020 он, тэнцүү таван бүлгээр, 2019 оныхтой харьцуулснаар**

2020 сарууд	Q1	Q2	Q3	Q4	Q5
1	-7%	-9%	10%	0%	-10%
2	18%	16%	14%	11%	10%
3	-10%	-15%	-4%	-2%	-11%
4	-1%	-6%	2%	4%	1%
5	8%	0%	11%	3%	-1%
6	20%	3%	13%	5%	1%
7	3%	-4%	8%	12%	15%
8	16%	-1%	6%	13%	3%
9	9%	15%	32%	17%	6%
10	18%	24%	15%	38%	8%
11	-10%	-8%	-11%	-10%	-15%
12	-8%	-13%	-15%	-11%	-9%

*Эх үүсвэр: НӨАТ-ын Их өгөгдлийг үндэслэсэн судлаачдын тооцоо. Түүврийн хэмжээ 4463 өрх.*

Бидний судалгааны үр дүн Үндэсний статистикийн хороо (ҮСХ) болон Дэлхийн банк (ДБ)-ны хамтран явуулсан “КОВИД-19 цар тахлын нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгаа (HRPS)-ны үр дүнгээр баталгаажиж байгаа болно. Судалгааны эхний шатны үр дүнгээр КОВИД-19 цар тахлын эхэн үеийг өмнөх жилийн мөн үеийнхтэй харьцуулахад судалгаанд хамрагдсан нийт өрхийн 16 хувь нь орлого нь тасарсан, 73 хувь нь бизнесийн орлого нь их хэмжээгээр буурсан, малчин өрхийн 70 хувь нь орлого нь огцом буурсан хэмээн мэдээлсэн байна (ҮСХ, Дэлхийн банк, 2020 оны 7-р сар). Уг судалгааны 2-р шатны үр дүнгээс үзэхэд цалин хөлстэй хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн 95 орчим хувь нь хэвийн байдлаараа ажиллах боломжтой байгаа бол судалгаанд хамрагдсан нийт өрхийн 76 хувийнх

нь цалин орлого 6-р сараас хойш хэвийн түвшиндээ оржээ. Энэ үзүүлэлт цар тахал эхэлсний дараах үе буюу эхний шатанд 58 хувь байжээ (ҮСХ, Дэлхийн банк, 2020 оны 12-р сар).

#### 4.1.5. Өрхийн орлого, зарлага: хадгаламж, зээлийн хүчин зүйлүүд

Ядуурал, тэгш бус байдлын дүн шинжилгээг хийхдээ орлогыг хэрэглээгээр орлуулан тооцох аргыг хэрэглэсэн бөгөөд улмаар хэрэглээний тоо мэдээлэлд үндэслэн орлогын ядуурал, тэгш бус байдлын үзүүлэлтүүдийг тооцсон. Орлого болон хэрэглээний нэг гол ялгаа нь хадгаламж/хөрөнгө оруулалт болон зээлийн үзүүлэлтүүдээс хамаарна.

##### *Орлого = Хэрэглээ + Хадгаламж/хөрөнгө оруулалтын өсөлт – Зээлийн өсөлт*

Бидний ашиглаж байгаа Их өгөгдлийн санд хадгаламж, хөрөнгө оруулалт, зээлийн талаарх мэдээлэл байхгүй билээ. Иймээс банкны системийн тайлан балансад тусгагдсан үндэсний хэмжээний мэдээллийг ашиглан өрхүүдийн хадгаламж, зээлийн өөрчлөлтийг судлах боломжийг ашигласан. Эдгээр мэдээллийг шинжилж үзэхэд 2020 онд хувь хүмүүсийн авсан зээлийн үлдэгдэл 969.7 тэрбум төгрөгөөр (344 сая ам.доллар) буурч, найдваргүй зээл 234.9 тэрбум төгрөгөөр (83.4 сая ам.доллар) өсч, нийт хадгаламжийн үлдэгдэл 3.56 их наяд төгрөгөөр (1,263.1 сая ам.доллар) нэмэгдсэн байна (Монгол Банк, 2020a). Иймээс 2020 онд өрхүүдийн хадгаламж нэмэгдэж, зээлийн эргэн төлөлт сайжирсан зэрэг нь улс орны эдийн засагт бүхэлд нь эерэгээр нөлөөлж айл өрхүүдийн орлого хэрэглээнээс нь давж өссөн болохыг харуулж байна. Ялангуяа хүн амын хамгийн чинээлэг бүлгийн (Q5) хэрэглээ хөл хорионы үеэр буурсан нь тэдгээр өрхүүдийн хэрэглээ хумигдаж, хадгаламж нь нэмэгдэх нөхцөл үүссэн байна. Үүний зэрэгцээ чанаргүй зээлийн хэмжээ 2020 онд өссөн нь хөл хорионы үеэр хамгийн ядуу болон чинээлэг бус бүлгийн өрхүүдэд санхүүгийн бэрхшээл учирч байсантай холбоотой байж болзошгүй юм.

Банкны системд бүртгэгдсэн зээлийн болон хадгаламжийн сан нь хүн амын болон айл өрхүүдийн авч байгаа зээл, хадгаламжийн нийт хэмжээг бүрэн илэрхийлж чадахгүй хэдий ч Монгол Улсын эдийн засагт эргэлдэж буй нийт зээл, хадгаламжийн сангийн томоохон хувийг бүрдүүлж байна. Монгол Улсын банкны системийн хамрах хүрээ харьцангуй өргөн хэдий ч хүн амын хамгийн ядуу хэсэг банкны системд хүрч үйлчлүүлэх боломж хязгаарлагдмал байна. Монгол Улсын насанд хүрсэн хүн амын 93 орчим хувь нь банкинд данс эзэмшиж байна (АХБ, 2019). Үүнээс гадна тус улсын интернет банкны хамрах хүрээ өргөн төдийгүй улам хурдацтай хөгжиж байна. 2020 оны 9-р сарын байдлаар арилжааны банкууд интернет банкны 2,5 сая хэрэглэгчтэй болсон бөгөөд 1,3 сая гар утасны банк хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлж байна (Монголбанк, 2020b).<sup>33</sup>

<sup>33</sup> Монгол Улсын насанд хүрсэн хүн ам (20 болон түүнээс дээш насны) 2019 онд 2.0 сая хүрсэн. Монгол Улсын Үндэсний статистикийн хороо @1212.mn. Хамгийн сүүлд 2021 оны 3-р сарын 8-нд үзэв.

## 4.2. Ядуурлын үзүүлэлтүүд

Бидний судлахаар зорьж буй гурав дахь асуудал бол Их өгөгдлийг ашиглан Монгол Улс дахь ядуурал, тэгш бус байдлыг шинжлэн судалж, КОВИД-19 цар тахлын үед ядуурал, тэгш бус байдал хэрхэн өөрчлөгдөж байгааг судлах явдал юм.

Нэг хүнд ногдох сарын хэрэглээ 2018 оны үнээр 166,580.3 төгрөг хэмээн албан ёсоор тодорхойлсон үндэсний ядуурлын шугамыг ашиглан ядуурлын хамралтын хүрээг тооцсон болно.<sup>34</sup>

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий бодит өсөлт 2019 онд 5.2 орчим хувь байсан бөгөөд хэрэглээний үнийн индекс (ХҮИ) 2019 онд 2018 оныхоос 5.2 хувиар өссөн байна(ҮСХ, 2020). Түүгээр ч зогсохгүй зарим салбарууд жилийн зарим улиралд бусад салбаруудаас илүү сайн гүйцэтгэлтэй байснаар их ялгаа гараагүй байна. Эдгээр өөрчлөлтийг харгалзаж үзэхийн зэрэгцээ ядуурлын мэдрэмжийн үзүүлэлтүүдэд өөрчлөлт бага ажиглагдаж байгаа (Уочи 2020, хуудас 25) учир судлаачид ӨНЭЗС-2018-ны тоо мэдээлэл нь цар тахлын хямралаас өмнөх нөхцөл байдлыг харьцангуй төлөөлөх чадвартай хэмээн үзсэн (АХБ, 2020) болно.

Ядуурлын шугамыг жишиг болгож Монгол Улсын ядуурлын хамралтын хүрээг тооцохдоо бодит цаг хугацааны зарлагын мэдээллийг бүрэн илэрхийлэх боломж бүхий Их өгөгдлийн түүврийг ашигласан.<sup>35</sup>

Нэгдүгээрт, өрхийн судалгаа болон Их өгөгдлийг ашиглан тооцсон ядуурлын хамралтын хүрээ буюу ядуурлын түвшин өөр хоорондоо ихээхэн ялгаатай байна. ӨНЭЗС-2018-ны нэг хүнд ногдох хэрэглээний үзүүлэлтийг үндэслэн тооцсон албан ёсны ядуурлын түвшин 28.4 хувь байна. Харин Их өгөгдлийн түүврээс тооцсон ядуурлын түвшин 56.6 хувь буюу судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн 56.6 хувь нь ядуурлын шугам болох 166.580 төгрөгөөс доош хэрэглээтэй амьдарч байна. Үнэндээ ядуурлын түвшний эдгээр тооцоо ихээхэн ялгаатай гарч байгаа нь асуудал биш юм. Харин үүнээс гадна хэд хэдэн үндсэн шалтгаан байна.

Эхний шалтгаан нь ӨНЭЗС-2018-гаар ядуурлын түвшинг тооцохдоо цахим төлбөрийн бүртгэлийн системд төлбөрийн баримтаа бүртгүүлсэн эсэхээс үл хамааран тухайн өрхийн бүх зардлын мэдээллийг үндэслэдэг. Харин Их өгөгдлийг ашиглаж тооцсон ядуурлын түвшинг зөвхөн хэрэглэгчдийн цахим төлбөрийн бүртгэлийн системд бүртгүүлсэн зарлагын мэдээллийг үндэслэн тооцсон. Тэгэхлээр хүн амын хэрэглээний нилээд хэсэг нь цахим төлбөрийн бүртгэлийн системд бүртгэгдэхгүй байх магадлалтай. Энэ нь ялангуяа албан бус хөдөлмөр эрхлэгчид олноор ажилладаг хүнсний заххаас хүнснийхээ хэрэгцээг хангадаг орлого багатай өрхүүдэд хамаатай байж болзошгүй.

Хоёрдахь шалтгаан нь ӨНЭЗС-ийн судалгаа нь өөрийн үйлдвэрлэл, хэрэглээг

<sup>34</sup> Uochi, I. (2020): Mongolia Poverty Update 2018 (English). Washington D.C.: World Bank Group. <http://documents.worldbank.org/curated/en/532121589213323583/Mongolia-Poverty-Update-2018>.

<sup>35</sup> Хэрэглэгчид ихэвчлэн татварын буцаан олголт, хонжворт сугалаа зарлах үетэй давхцуулан төлбөрийн баримтаа сарын сүүлчээр Е-баримт системд оруулах хандлагатай байгаа тул эдгээр мэдээллийг сараар нэгтгэн МУИС-ийн судлаачдад хүргүүлж байв.

мөн хамруулж тооцдог билээ. Хөдөөгийн малчин өрхүүд нь хоол хүнс, мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээнийхээ ихээхэн хувийг өөрийн үйлдвэрлэлээс ашигладаг тул нэг хүнд ногдох зарлага нь хот суурингийн өрхийнхөөс нилээд бага байна. Тухайлбал, малчин өрхүүд нь мах, махан бүтээгдэхүүний хэрэгцээнийхээ бараг 80 хувийг өөрийн мал аж ахуйгаас хангаж байна. Харин хөдөлмөр эрхэлж байгаа болон бизнесийн үйл ажиллагаа явуулж цалин хөлс авч, орлого олдог хот суурингийн оршин суугчид нь бараг хүнсний бүтээгдэхүүн нэг бүрийг зах зээлээс худалдан авч хүнсний хэрэгцээгээ хангаж байна.

Гурав дахь шалтгаан нь ӨНЭЗ-ийн судалгаагаар хэрэглээ (зарлага)-г тодорхойлохдоо НӨАТ-ын системээс илүү өргөн хүрээгээр авч үздэг. Тухайлбал, ӨНЭЗ-ийн 2018 оны судалгаа нь орон сууцны зардлыг тооцдог бол НӨАТ-ын Их өгөгдлийн системд эдгээр зардлын зарим нь орохгүй байна.

Иймээс, ялангуяа ядуу өрхүүд худалдаж авсан хоол хүнсэндээ зарцуулсан зардлаа бүртгэх боломжгүй байдаг төдийгүй өөрийн үйлдвэрлэл, эзэмшлийн хүнсний бүтээгдэхүүний зардал НӨАТ-ын системд огт бүртгэгдэхгүй байгаа учир НӨАТ-ын системээс тооцож буй зарлагын тооцоо ӨНЭЗ-ийн судалгааны зарлагын тооцооноос бага байх нь зайлшгүй. Түүнчлэн, айл өрхүүд удаан эдэлгээтэй бараа материал, орон сууцтай холбоотой зарим зардлыг Е-баримт системд огт бүртгэхгүй байгаа нь НӨАТ-ын тухай хууль тогтоомж, тогтолцоотой ч холбоотой байна. Энэ нь НӨАТ-ын Их өгөгдлийн түүвэрт үндэслэн тооцсон хэрэглээг ӨНЭЗ-ийн судалгаагаар тооцсон хэрэглээнээс бууруулж байгаа юм.


НӨАТ-ын системд зарлагыг дутуу бүртгэх, олон төрлийн зардал бүртгэгдэхгүй орхигдох, өөрийн үйлдвэрлэл, хэрэглээ хамрагдахгүй байгаа зэрэг дээрх гурван хүчин зүйлээс шалтгаалж ӨНЭЗ-ийн судалгааг үндэслэн тооцсон албан ёсны ядуурлын шугамыг жишиг болгон Их өгөгдлийг үндэслэсэн ядуурлын түвшингийн тооцоо нь ӨНЭЗ-ийн судалгаагаар тооцсон ядуурлын түвшингээс гарцаагүй өндөр байхад хүргэж байна. Энэ нь ядуурлын түвшин үнэндээ өндөр байна гэсэн үг биш бөгөөд НӨАТ-ын Их өгөгдлийг ашигласнаар ядуурлын түвшинг ӨНЭЗ-ийн судалгаанаас илүү сайн тооцно гэсэн үг ч бас огт биш юм. Ердөө л мэдээллийн хоёр эх сурвалжийг ашиглан хэрэглээний ялгаатай төрлүүдийг харьцуулж байна гэсэн үг юм.

Иймээс ядуурлын түвшинг бус цаг хугацааны явцад ядуурах үзэгдэл яаж өөрчлөгдөж болзошгүйг судлан хянаж байх нь илүү чухал юм. Бид үүнийг нэг ижил бөгөөд зөрүүгүй тохирох мэдээллийн санг ашиглан судалсан болно. Энэ тохиолдолд, НӨАТ-ын Их өгөгдлийн түүврийг ашигласан. Их өгөгдлийн түүврийг ашиглан тооцсон ядуурлын түвшин 2018 онд 56.6 хувь, 2019 онд 49.4 хувь, 2020 онд 44.6 хувь байна. Өөрөөр хэлбэл, НӨАТ-ын Их өгөгдлийн түүвэрт үндэслэн тооцсон ядуурлын түвшин 2020 онд бага зэрэг буурчээ. КОВИД-19 цар тахлын хямралын жил буюу 2020 онд 2019 онтой харьцуулахад бага хэмжээгээр ч болов ядуурлын түвшин буурсан байна.

Монгол Улсад 2020 онд ядуурлын түвшин буурсан гэсэн дүгнэлт нь зарим эргэлзээ төрүүлж болох ч Монгол Улсын Засгийн газраас 2020 онд хэрэгжүүлсэн эдийн засгаа дэмжих хөтөлбөрийн хүрээнд айл өрхүүдэд томоохон хэмжээний дэмжлэг туслалцаа үзүүлсэн нь ийм итгэл найдлагыг төрүүлж байгаа юм.

Их өгөгдлийн түүврийг ашиглан бид ядуурлын түвшинг сараар тооцох оролдлого хийсэн. Ядуурлын түвшин 2020 оны 1-р сард 53.9 хувь байсан хэдий ч КОВИД-19 цар тахлын жил буюу 2020 оны туршид буурсаар 2019, 2018 оныхоос ч доогуур түвшинд хүрсэн байна (Зураг 8-ийг үзнэ үү). Харин 2020 оны 11-р сард буюу хоёр дахь хатуу хөл хорио тогтоосон үед ядуурал 57.6 хувь болж өссөнөө 12-р сард дахин буурч 49.4 хувь болжээ.

**Зураг 8. Ядуурлын хамралтын хүрээ, сараар**



*Эх үүсвэр: НӨАТ-ын Их өгөгдөлд суурилсан Судлаачийн тооцоо*

НӨАТ-ын Их өгөгдлийн түүврийг үндэслэн ядуурлын түвшинг байршлаар мөн тооцсон. Хүснэгт 6-аас харахад хот суурингийн ядуурлын түвшин хөдөөгийнхөөс бага байна. Газарзүйн хувьд, хөдөө орон нутаг руу алслагдах тусам ядуурлын хамрах хүрээ тэлж байна. Улаанбаатар хотод ядуурлын түвшин хамгийн бага байгаа бөгөөд аймгийн төв, сумын төв, хөдөө орон нутаг гэсэн дарааллаар ядуурлын түвшин нэмэгдэж байна. Эдгээр хэв шинж нь ӨНЭЗ-ийн 2018 судалгаанд тооцсон ядуурлын хэв шинжтэй нийцэж байгаа хэдий ч дүн шинжилгээний үр дүнг тайлбарлах явцад НӨАТ-ын цахим төлбөрийн бүртгэлийн системд бүртгэгдээгүй хүнсний хэрэглээний хувийн жин өндөр, өөрийн үйлдвэрлэл, хэрэглээгээ бүртгэдэггүй хөдөө орон нутгийн өрхүүдэд (малчин өрх) хамгийн өндөр байх магадлалтайг анхаарах хэрэгтэй юм. Иймээс Их өгөгдлийн түүврийг ашигласнаар малчин өрхийн (хөдөө орон нутгийн) хэрэглээ дутуу бүртгэгдэж, ядуурлын тооцоо өндөр гарах нөхцөл үүсч болзошгүй юм.

**Хүснэгт 6. Зарлагаар тооцсон ядуурлын хамралтын хүрээ, хот, хөдөө, суурьшлаар**

	2018	2019	2020
Хот	49.9%	44.3%	40.3%
Хөдөө	68.9%	58.9%	52.6%
Улаанбаатар	45.9%	41.3%	38.6%
Аймгийн төв	58.5%	50.7%	44.0%
Сумын төв	67.1%	56.5%	51.9%
Хөдөө	73.0%	64.2%	54.1%

Эх үүсвэр: НӨАТ-ын Их өгөгдлийг үндэслэсэн Судлаачийн тооцоо

**4.3. Тэгш бус байдлын үзүүлэлтүүд**

Бидний судлахыг зорьж буй гурав, дөрөв дэх асуудлууд нь тэгш бус байдал, түүний өөрчлөлтийг Их өгөгдлийг ашиглан тооцоолох, өрхийн судалгаа болон Их өгөгдлийг ашигласан тооцоонуудад ямар ялгаа байгааг судлах юм.

**4.3.1. Индексээр тооцсон тэгш бус байдлын үзүүлэлтүүд**

Судалгааны дээрх асуудлуудад хариу олохын тулд тэгш бус байдлыг илэрхийлэх Жини, Тейл, Палма зэрэг индексийг тооцлоо. Жилээр тооцсон тэгш бус байдлын индексүүдийг Хүснэгт 7-д, сараар тооцсон тэгш бус байдлын индексүүдийг Зураг 9-д тус тус үзүүлсэн болно. Их өгөгдлийн түүврийг ашиглан тооцсон тэгш бус байдлын гурван индекс нь ӨНЭЗ-ийн 2018 оны судалгаагаар тооцсон албан ёсны үзүүлэлтүүдээс өндөр байна. Ядуурлын түвшний тооцоонд ялгаа гарч байсантай нэгэн адил Их өгөгдөл, ӨНЭЗ-ийн 2018 оны судалгааны мэдээлэлд суурилсан тэгш бус байдлыг илэрхийлэх тооцоонд маш их ялгаа гарч байгаа нь гайхах зүйл биш юм. Их өгөгдлийн түүврээс тооцсон Жини коэффициент 2018 онд 0.474 байгаа бол ӨНЭЗ-ийн 2018 оны судалгааны нэг хүнд ногдох зардлаар тооцсон Жини коэффициент 0.352 байна. Ингэснээр 2018 оны Их өгөгдөлд суурилсан Жини коэффициент нь ӨНЭЗ-ийн 2018 оны судалгаагаар тооцсон зардлын тэгш бус байдлыг илэрхийлэх Жини коэффициентоос даруй 0.12 пунктээр өндөр байна.<sup>36</sup>

Тейлийн индекс нь хувь хүмүүс буюу өрхүүд хоорондын зардлын тархалтын хэмжүүр юм. Орлогын хуваарилалт тэнцүү байх тохиолдолд хүн бүрт, аль эсвэл өрх бүрт ногдох орлого, зарлагын хувь хэмжээ адил тэнцүү байх ёстой. НӨАТ-ын Их өгөгдлийн түүврээс тооцсон Тейлийн индекс болон ӨНЭЗ-ийн 2018 оны судалгаагаар тооцсон Тейлийн индекс 2018 онд маш их ялгаатай байгаа нь (0.410 болон 0.215) магадгүй амьжиргаа сайтай чинээлэг өрхүүд НӨАТ-ын Их өгөгдлийн

<sup>36</sup> Ядуурал, тэгш бус байдлын үзүүлэлтүүдийг ихэвчлэн хэрэглээг үндэслэн тооцдог бөгөөд энэ нь зарлагын үзүүлэлтээс өөр билээ. Манай тохиолдолд, Их өгөгдлийн түүвэр нь нийт хэрэглээг бус зөвхөн зарлагын талаарх мэдээлэл агуулж байгаа учир ӨНЭЗ-ийн 2018 оны судалгаатай шууд харьцуулалт хийхийн тулд зарлагын үзүүлэлтийг ашиглах шаардлагатай. ӨНЭЗ-ийн 2018 оны судалгааны хэрэглээнд суурилсан тэгш бус байдлын индексүүд: Жини коэффициент 0.327, Тейлийн индекс 0.192, Палма харьцаа 2.45 байв.

түүвэрт илүү олноор хамрагдсан байх, түүнчлэн эдгээр өрхүүд төлбөрийн баримтаа НӨАТ-ын цахим төлбөрийн бүртгэлийн системд илүү тогтмол бүртгэдэг зэрэгтэй холбоотой байж болзошгүй юм.


Хүснэгт 7. Тэгш бус байдлын үзүүлэлтүүд, жилээр

Их өгөгдөл	Түүврийн хэмжээ	Жини коэффициент	Тейлийн индекс (GE1)	Палма харьцаа (p90/P40)
2018 нэг хүнд ногдох зардал	4463	0.474	0.410	3.86
2019 нэг хүнд ногдох зардал	4463	0.445	0.362	3.47
2020 нэг хүнд ногдох зардал	4463	0.419	0.329	3.15

2018 ӨНЭЭС	Түүврийн хэмжээ	Жини коэффициент	Тейлийн индекс (GE1)	Палма харьцаа (p90/P40)
НН expenditure per person	16,454	0.352	0.215	2.64

Эх үүсвэр: НӨАТ-ын Их өгөгдөлд суурилсан Судлаачийн тооцоо. ӨНЭЭС-ийн 2018 оны судалгааны мэдээллийг ҮСХ-оос гаргав. ҮСХ, 2019.

Зураг 9. Зардалд суурилж тооцсон тэгш бус байдлын үзүүлэлтүүд, сараар



Эх үүсвэр: Их өгөгдлийн түүвэрт суурилсан Судлаачийн тооцоо.

Цахим төлбөрийн бүртгэлийн системд ядуу өрхүүд зардлаа дутуу бүртгэх тохиолдолд Их өгөгдлийн түүвэрт суурилсан тэгш бус байдлын үзүүлэлтүүдийн тооцоо илүү өндөр гарах магадлалтай. Өмнөх хэсэгт өгүүлсэнчлэн хот суурингийн ядуу өрхүүд ихэвчлэн хоол хүнсээ албан бус хөдөлмөр эрхлэгчдийн ажиллуулдаг дэлгүүр захаас худалдан авах нь түгээмэл болон малчин өрхүүд (ядуу буурай хэсэг нь) мөн ихэвчлэн хоол хүнсээ өөрийн үйлдвэрлэл, эзэмшлээс авч хэрэглэдэг учир зардал хэрэглээгээ НӨАТ-ын цахим төлбөрийн бүртгэлийн системд тэр бүр бүртгэх боломжгүй буюу дутуу бүртгэдэг гэсэн үг юм. Ингэснээр Их өгөгдлийн түүврийг суурилсан тэгш бус байдлын үзүүлэлтүүдийн тооцоо ӨНЭЗ-ийн судалгааны тооцооноос өндөр гарах магадлалтай.

Үүний зэрэгцээ, амьжиргаа сайтай чинээлэг өрхүүдийн цахим төлбөрийн бүртгэлийн системд зардлаа дутуу бүртгэх тохиолдол ч Их өгөгдлийн түүврийг суурилж тооцсон тэгш бус байдлын үзүүлэлт дутуу гарахад нөлөөлж мэднэ. НӨАТ-ын буцаан олголт, хонжворт сугалаа сонирхлыг нь нэг их татахгүй учир чинээлэг айл өрхүүд төлбөрийн баримтаа цахим төлбөрийн бүртгэлийн системд тэр бүр бүртгэхгүй байх, аль эсвэл дутуу бүртгэх магадлал бий. Ийм өрхүүдийн төлбөрийн баримтаа цахим төлбөрийн бүртгэлийн системд бүртгэх түвшин ямар байгааг мэдэх арга замыг бид хараахан олоогүй байна. Өөр нэг хүчин зүйл бол чинээлэг айл өрхүүдийн түгээмэл хэрэглээ болсон хувийн хэвшлийн эрүүл мэнд, боловсролын зардлыг НӨАТ-аас чөлөөлж байгаа нь тэдгээр өрхийн зардлыг дутуу тооцох, улмаар тэгш бус байдлыг дутуу үнэлэхэд хүргэж болзошгүй байна.

Иймээс НӨАТ-ын Их өгөгдлийн зардлын мэдээлэл нь ӨНЭЗ-ийн судалгааны хэрэглээний мэдээллээс ялгаатай тул эдгээр мэдээллийн хоёр эх сурвалжийг ашиглан тооцсон тэгш бус байдлын үзүүлэлтүүд ялгаатай байх нь гарцаагүй. Тэгэхлээр НӨАТ-ын Их өгөгдлийн түүврийг ашиглан цаг хугацааны турш дахь тэгш бус байдлын чиг хандлагыг судлах нь илүү ач холбогдолтой болно.

Жини коэффициент 2019, 2020 онуудад 0.445; 0.419 болж ялимгүй буурчээ. Өөрөөр хэлбэл, КОВИД-19 цар тахлын үеэр Монгол Улсад өрхийн зарлагын тэгш бус байдал 2018, 2019 онуудтай харьцуулахад буурсан байна.

Их өгөгдлийн түүврийн нэг хүнд ногдох зарлагад суурилсан тооцооноос харахад 2018 онд Тейлийн индекс 0.410 байсан бол 2020 онд 0.329 болж буурчээ. Зарим судлаачид КОВИД-19 цар тахлын үед Монгол Улсын хүн амын зардлын тэгш бус байдал цар тахлын өмнөх үеийнхээс буурсан гэж үзэж магадгүй юм. Хүснэгт 5-с харахад КОВИД-19 цар тахлын үед хамгийн ядуу бүлгийн (Q1) өрхүүдийн зарлага 2-р бүлэг (Q2), 5-р бүлгийн (Q5) өрхүүдийнхтэй харьцуулахад харьцангуй бага хэмжээгээр буурсан байна.

Палма харьцаа 2018 онд 3.86 байжээ. Өөрөөр хэлбэл, Их өгөгдлийн түүвэрт хамрагдсан нийт хүмүүсийн хамгийн чинээлэг 10 хувь нь хамгийн ядуу 40 хувийнхнаас 3.8 дахин их мөнгө зарцуулж байна. 2020 онд уг харьцаа 3.15 болж буурчээ.

Дээр өгүүлсэн гурван индексийн өөрчлөлтөөс харахад Монгол Улсын хүн амын



зарлагын тэгш бус байдал 2020 онд буурсан байна.

Ийнхүү зарлагын тэгш бус байдал буурсан нь Монгол Улсын Засгийн газраас ядуу эмзэг бүлгийнхэнд чиглэсэн нийгмийн хамгаалал, халамжийн бодлогыг төсвийн дэмжлэгийн хөтөлбөрийн нэг хэсэг болгон хэрэгжүүлж байсан нь цар тахлын хямралыг даван туулахад чухал нөлөө үзүүлсэнтэй холбоотой гэж үзэж болох юм (ADB, 2020). Үнэн хэрэгтээ, Монгол Улсын Засгийн газраас нэмэгдүүлсэн нийгмийн халамжийн тусламж дэмжлэгийг авч эхэлснээр хамгийн ядуу хоёр бүлгийнхний (Q1, Q2) зарлага өссөн бөгөөд 2020 оны сүүлчээр хоёр дахь удаагийн хөл хорио тогтоох үед тэдгээрийн зарлага ерөнхийдөө буурч байсан ч дээд гурван бүлгийнхний (Q3, Q4, Q5) зарлагын бууралттай харьцуулахад бууралтын хэмжээ харьцангуй бага байгааг Хүснэгт 5-аас харж болно. Түүнчлэн, үүнийг 2020 онд чинээлэг өрхүүдийн сарын зарлагын хэмжээ тогтвортой буурч байсантай холбон тайлбарлаж болно (Хүснэгт 5, Q5 баганыг үзнэ үү). Хөл хорио тогтоосон, хилийн боомтууд хаагдсан зэрэг нь чинээлэг өрхүүдийн зарцуулалт, боломж эрс хязгаарлагдмал болсон гэсэн үг юм.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газар 2018 оноос НӨАТ-ын хамрах хүрээг үе шаттайгаар нэмэгдүүлж байгаатай холбоотойгоор илүү олон төрлийн бараа, үйлчилгээнд НӨАТ-ын татвар ногдуулах болсон тул өрхүүд, ялангуяа ядуу өрхүүд төлбөрийн баримтаа НӨАТ-ын цахим төлбөрийн бүртгэлийн системд бүртгэж хэвшихэд түлхэц болж хэмжигдэхүйц зарлагын тэгш бус байдлыг бууруулахад нөлөөлсөн байж болзошгүй юм.

Эцэст нь, дээрх гурван индексээр хэмжигдэх тэгш бус байдал буурсан нь зөвхөн зарлагын тэгш бус байдлыг илэрхийлж байна. Орлогын тэгш бус байдал нэмэгдсэн ч байж магадгүй юм. Чинээлэг өрхүүдийн зарлага хумигдсанаар хуримтлалаа нэмэгдүүлэх боломж нөхцөл 2020 онд илүү бүрдсэнээр Их өгөгдлийн түүврээс (зөвхөн зарлагын мэдээлэл) үзүүлэлтийг нь тооцох боломжгүй орлогын тэгш бус байдал нэмэгдсэн байж болзошгүй юм. Үнэхээр ч цар тахал дэгдсэн туйлын эргэлзээтэй үед бололцоотой хүмүүс нь эрсдлээс сэргийлж хуримтлалаа нэмэгдүүлэх арга зам хайхыг үгүйсгэхийн аргагүй билээ. Амьжиргаа сайтай чинээлэг өрхүүдийн орлого нь зарлагаасаа давах өндөр магадлалтай төдийгүй эдийн засаг дахь цэвэр хуримтлал 2020 онд өссөн нь амьжиргаа сайтай чинээлэг өрхүүд илүү хэмнэлт хийснээр тэгш бус байдлын үзүүлэлтүүд дутуу тооцогдсон байж болзошгүй гэж дүгнэж болох юм.

Дээр өгүүлснийг нэгтгэж дүгнэвэл НӨАТ-ын Их өгөгдлийг ашиглан тооцсон зарлагын тэгш бус байдал буурсан хэдий ч орлогын тэгш бус байдал 2020 онд өссөн байж болзошгүйг үгүйсгэхийн аргагүй.

#### **4.3.2. Тархалтаар нь тооцсон тэгш бус байдлын үзүүлэлтүүд**

Бид тархалтын хэмжүүрийг ашиглан тэгш бус байдлыг тооцохдоо судалгаанд хамрагдсан хүмүүсийг таван тэнцүү бүлгээр, тархалтын нягтралаар нь хувааж судалсан. Үүнээс гадна Их өгөгдлийн түүвэр нь өрхүүдийн нэгдсэн мэдээллийг

гаргах ховор боломжийг олгодог учир тэрхүү мэдээллийг ашиглан цаг хугацааны туршид тэгш бус байдал хэрхэн өөрчлөгдөж байгааг судалж болно.

Их өгөгдлийн түүврийг ӨНЭЗС-2018-ны түүвэрт үндэслэн тодорхойлсон билээ. ӨНЭЗ-ийн 2018 оны судалгаанд хамрагдсан өрхүүдийг хэрэглээний түвшингээр нь тэнцүү 5 бүлэг болгон хэдийнээ хуваасан байгаа тул бид тэдгээрийг суурь болгож авсан. Үүнээс гадна, Их өгөгдлийн түүвэр нь судалгаанд хамрагдсан өрхүүдийн 2018-2020 оны зарлагын мэдээллийг агуулж байгаа учир тэдгээрийг судалж буй онуудын НӨАТ-ын Их өгөгдлийн зарлагын мэдээллийг нь үндэслэн өрхүүдийг арай өөр тэнцүү таван бүлэгт хуваах боломж мөн бүрдсэн юм.

Хүснэгт 8-д 2018 оны НӨАТ-ын Их өгөгдлийн түүвэрт хамрагдсан өрхүүдийг зарлагын түвшингээр нь тэнцүү 5 бүлэг болгож хуваасныг ӨНЭЗС-2018-нд хамрагдсан өрхүүдийг хэрэглээний түвшингээр нь тэнцүү 5 бүлэг болгож хуваасантай хэрхэн дүйцэж байгааг үзүүллээ. Ийнхүү дүйцсэн өрхүүдийн хувийн жин буюу хоёр түүвэрт хоюуланд нь хамрагдсан адил хэрэглээ, зарлагатай бүлгүүдийг хүснэгтийн диагональ хэсэгт саарал өнгөөр тэмдэглэсэн болно.

Жишээлбэл, ӨНЭЗ-ийн 2018 оны судалгаанд хэрэглээгээр нь бүлэглэсэн хамгийн ядуу бүлгийн (Q1) нийт өрхийн 42.2 хувь нь НӨАТ-ын Их өгөгдлийн түүвэрт зарлагаар нь бүлэглэсэн хамгийн ядуу бүлэгт (Q1) хэвээр байгаа бол 20.5 хувь нь хамгийн ядуу 2 дахь бүлэгт (Q2) орсон байна. Үлдсэн 37.4 хувь нь Их өгөгдлийн түүврийн гурав (Q3), дөрөв (Q4), тав дахь (Q5) буюу хамгийн чинээлэг бүлэгт оржээ. Энэ нь олон ядуу өрхүүдийн цахим төлбөрийн бүртгэлийн E-баримт системд бүртгүүлсэн зарлага бусад бүлгүүдийн зарлагатай харьцуулахад өндөр байсан гэсэн үг юм. Энэ нь магадгүй арай чинээлэг бүлгийн өрхүүд төлбөрийн баримтаа тэр бүр системд бүртгэдэггүйг илэрхийлж байж болох бөгөөд НӨАТ-ын Их өгөгдлийн зарлагаар тооцвол тэд ядуу бүлэгт хамрагдахаар байна. Түүнчлэн энэ нь арай өөр дүр зургийг ч илэрхийлэх боломжтой. Тухайлбал, чинээлэг бүлгийн өрхүүд орон сууц, машин техник зэрэг үндсэн хөрөнгө худалдан авах, боловсрол, эрүүл мэнддээ зарцуулах зэргээр томоохон зардал гаргасан байж болох ч энэ нь НӨАТ-ын цахим төлбөрийн бүртгэлийн системд бүртгэгдэхгүй орхигдох, аль эсвэл дутуу бүртгэх асуудал гарч буйг илэрхийлж байж болзошгүй юм.

Үүний нэгэн адил ӨНЭЗС-2018-ндд хэрэглээгээр нь бүлэглэсэн хамгийн чинээлэг бүлгийн (Q5) өрхүүдийн 50.4 хувь нь НӨАТ-ын Их өгөгдлийн түүвэрт зарлагаар нь бүлэглэсэн хамгийн чинээлэг бүлэгт (Q5) орж байгаа бол тэдгээрийн 23.7 хувь нь дээрээсээ хоёр дахь чинээлэг бүлэгт (Q4), үлдсэн нь ядуу гурван бүлэгт (Q3, Q2, Q1) хуваагдан орж байна. Доорх хүснэгт ӨНЭЗС-2018 болон Их өгөгдлийн мэдээллүүд өөр хоорондоо ихээхэн ялгаатайг харуулж байна. НӨАТ-ын Их өгөгдлийн санд хүн амын хэрэглээний зарим мэдээлэл бүртгэгдэггүй учир тооцоо илүү, дутуу байх магадлалтай. Иймээс тэгш бус байдлын үзүүлэлтүүдийг үнэн зөв тооцоход НӨАТ-ын Их өгөгдлийн сан хангалттай мэдээлэл болж чадахгүйн зэрэгцээ ийм зорилгоор ӨНЭЗ-ийн 2018 оны судалгааг орлох ч боломжгүй билээ.

**Хүснэгт 8. ӨНЭЗС-2018-ны хэрэглээгээр нь бүлэглэсэн тэнцүү 5 бүлэг болон Их өгөгдлийн түүврээс зарлагаар нь бүлэглэсэн тэнцүү 5 бүлэг**

		2018 Их өгөгдлөөс зарлагаар нь бүлэглэсэн тэнцүү 5 бүлэг					Нийт
		Q1	Q2	Q3	Q4	Q5	
ӨНЭЗС-ны хэрэглээгээр нь бүлэглэсэн тэнцүү 5 бүлэг	Q1	42.2%	20.5%	23.6%	9.7%	4.1%	100.0%
	Q2	18.1%	29.1%	23.4%	18.6%	10.8%	100.0%
	Q3	16.1%	20.5%	23.4%	25.0%	15.0%	100.0%
	Q4	8.7%	17.3%	21.1%	26.1%	26.8%	100.0%
	Q5	3.3%	8.0%	14.6%	23.7%	50.4%	100.0%
<b>Нийт дүн</b>		<b>13.9%</b>	<b>18.3%</b>	<b>21.7%</b>	<b>23.1%</b>	<b>23.1%</b>	<b>100.0%</b>

*Санамж: Тэнцүү 5 бүлэг бүрийн дундаж зарлагаар тооцсон*

*Эх үүсвэр: ӨНЭЗС-2018 болон НӨАТ-ын Их өгөгдлийн түүврийг үндэслэсэн Судлаачийн тооцоо*

Иймээс тэнцүү 5 бүлгүүдийн хооронд гарч буй хөдөлгөөнийг Их өгөгдлөөс үүсгэсэн нэгдсэн тоо мэдээллүүд, он дараалсан өгөгдлүүд, 2018-2020 онуудын зарлагын талаарх тоо мэдээлэл зэрэг мэдээллийн тогтвортой эх үүсвэрийг ашиглан судлах нь маш чухал юм. Эдгээр ховор мэдээллийн санг ашиглан бид зөвхөн НӨАТ-ын Их өгөгдлийн түүврийн зарлагын мэдээлэлд дүн шинжилгээ хийж 2018-2020 оны хооронд зарлагаар нь бүлэглэсэн тэнцүү 5 бүлгийн хооронд хичнээн өрх, хэрхэн шилжиж байгааг судлах оролдлого хийсэн (Хүснэгт 9-ийг үзнэ үү). Хүснэгтээс харахад тэнцүү 5 бүлгийн хооронд нэлээд хөдөлгөөн гарсан байна. 2018 онд хамгийн ядуу бүлэгт (Q1) орж байсан өрхүүдийн 60 орчим хувь нь 2020 он гэхэд тухайн бүлэгтээ хэвээр байв. Өөрөөр хэлбэл, эдгээр өрхүүдийн зарлага, хэрэглээ 2020 он хүртэл өөрчлөгдөөгүй хэвээр байгаа аж. Гэхдээ энэ бүлгийн өрхүүдийн 22.7 хувь нь хоёр дахь бүлэгт (Q2), 10 хувь нь дунд бүлэгт (Q3) шилжсэн бол цөөхөн хувь нь буюу 4.8 хувь, 2.8 хувь нь дээд бүлгүүдэд (Q4, Q5) шилжсэн байна. Үүнтэй төстэйгөөр 2018 онд хамгийн чинээлэг бүлэгт (Q5) орж байсан өрхүүдийн 60 гаруй хувь нь (зарлагаар) 2020 онд мөн бүлэгтээ хэвээр байсан бөгөөд 24.2 хувь нь 4-р бүлэг (Q4) рүү, үлдсэн хувь нь ядуу бүлгүүд рүү тус тус шилжсэн байна. Эдгээр хөдөлгөөн нь нийгмийн хөдөлгөөнийг илэрхийлэх зарлагын бодит өөрчлөлтийг болон цахим төлбөрийн бүртгэлийн E-баримт системд өрхүүд төлбөрийн баримтаа бүртгэх нь нэмэгдсэн, аль эсвэл буурсан эсэхийг бүрхэгдүүлж байгаа юм.

**Хүснэгт 9. Зарлагаар нь бүлэглэсэн тэнцүү 5 бүлэг хоорондын өрхүүдийн хөдөлгөөн, 2018-2020**

		2020 Их өгөгдлөөс зарлагаар нь бүлэглэсэн тэнцүү 5 бүлэг					
		Q1	Q2	Q3	Q4	Q5	Нийт
2018 Их өгөгдлөөс зарлагаар нь бүлэглэсэн тэнцүү 5 бүлэг	Q1	59.8%	22.7%	10.0%	4.8%	2.8%	100.0%
	Q2	24.0%	33.5%	26.6%	11.9%	4.0%	100.0%
	Q3	11.0%	27.1%	30.2%	22.9%	8.8%	100.0%
	Q4	4.0%	12.8%	23.8%	36.3%	23.2%	100.0%
	Q5	2.0%	3.0%	9.4%	24.2%	61.3%	100.0%


Санамж: Тэнцүү 5 бүлэг бүрийн дундаж зарлагаар

Эх үүсвэр: НӨАТ-ын Их өгөгдлийн түүврийг үндэслэсэн Судлаачийн тооцоо

Хоёр оны түүврийн аль алиных нь дунд бүлгүүдэд орсон өрхүүдийн хувьд ямар өөрчлөлт гарав? Тэдгээрийн зарлага яаж өөрчлөгдөв? 2020 он гэхэд тэдгээр өрхүүд дээш, доош бүлгүүд рүү шилжив үү? 2018 онд 3 дахь бүлэгт (Q3) орж байсан өрхүүдийн гуравны нэг нь 2020 онд мөн түвшиндээ хэвээр байсан бол 23 орчим хувь нь 4 дэх бүлэг рүү (Q4), 9 хувь нь хамгийн дээд бүлэг рүү (Q5) тус тус шилжсэн байна. Мөн 2018 онд 5 дахь бүлэгт (Q5) орж байсан өрхүүдийн 61.3 хувь нь 2020 онд мөн түвшиндээ байсан бол 2 хувь нь 1 дэх бүлэг рүү (Q1), 3 хувь нь 2 дахь бүлэг рүү (Q2) тус тус шилжсэн байгаа нь сонирхол татаж байна.

Зураг 10-т 2018-2020 оны хооронд өрхүүд таван тэнцүү бүлгүүдийн хооронд хэрхэн дээш, доош шилжсэнийг үзүүлээ.

**Зураг 10. Зарлагаар нь бүлэглэсэн тэнцүү 5 бүлэг хоорондын өрхүүдийн хөдөлгөөн, 2018-2020**




Санамж: Тэнцүү 5 бүлэг бүрийн дундаж зарлага

Эх үүсвэр: НӨАТ-ын Их өгөгдлийн түүврийг үндэслэсэн Судлаачийн тооцоо

2018-2020 онуудад гарсан зарлагын нягтралын муруйн шилжилтээр тэгш бус байдал яаж өөрчлөгдөж байгааг илүү тодорхой илэрхийлэх боломж бий. 2020 онд зарлагын нягтралын муруй баруун тийш шилжиж 2018 онтой харьцуулахад арай илүү өргөн дэлгэмэл хэлбэртэй байгаа нь зарлагын түвшин нэмэгдсэнийг, мөн тархалт нь жигд байгааг илэрхийлж байна.

**Зураг 11. Зардлын нягтралын муруй, 2018-2020**



## БҮЛЭГ 5. ДҮГНЭЛТ

### 5.1. Судалгааны үр дүнд хийсэн дүгнэлт

Өнгөрсөн 2020 онд дэлхий дахинд урьд өмнө тохиож байгаагүй халдварын цар тахал дэгдэж асар их хэмжээний эдийн засгийн хямралтай тулгарсан билээ. Энэхүү тайланд бид КОВИД-19 цар тахлын энэхүү хямрал 2020 оны туршид Монгол Улсын хүн амын хэрэглээ, ядуурал, тэгш бус байдалд хэрхэн нөлөөлснийг судлах оролдлого хийсэн юм. Тооны хувьд тасралтгүй өсөн нэмэгдэж байгаа олон мянган хэрэглэгчтэй Монгол Улсын НӨАТ-ын цахим төлбөрийн бүртгэлийн системийг ашиглан цар тахлын хямралын үеийн хүн амын хэрэглээ (зарлага), түүнчлэн ядуурал, тэгш бус байдлын үзүүлэлтүүдийг тооцож дүн шинжилгээ хийж хэвшсэн хандлагыг өөрчлөх онцгой завшаан бидэнд тохиосон юм. Ийм төрлийн Их өгөгдөл нь төрөл бүрийн мэдээллийн (цаг хугацааны дараалалтай) нэгдсэн, найдвартай эх сурвалж болох тул шаардлагатай бүхий л үзүүлэлтийг сарын давтамжтайгаар илүү шуурхай тооцох боломж олгох юм.

НӨАТ-ын цахим төлбөрийн бүртгэлийн системийн мэдээллийг ашиглаж хийсэн тооцооноос үзэхэд 2020 оны ихэнх саруудад хүн амын зарлага өсч байсан бөгөөд харин ядуурал, тэгш бус байдлын үзүүлэлтүүд 2019 оны мөн үеийнхтэй харьцуулахад буурсан байна. Мөн түүнчлэн өрхийн нийт зарлага 2020 оны 1-р сард огцом буурсан боловч 2020 оны 6-р сарын сүүлээс эргэн нэмэгдэж КОВИД-ын өмнөх үеийн түвшинд хүрчээ. Эдгээр үр дүн нь Монгол Улсад явуулсан саяхны судалгааны үр дүнгээр давхар нотлогдож байна (АХБ, 2020, НҮБ-ын Хүн амын сан, 2020). Гэхдээ халдварт цар тахлаас сэргийлж 2020 оны эхэн болон төгсгөлд тогтоосон хоёр удаагийн хатуу хөл хорио нь хүн амын хэрэглээ буурах, ядуурал, тэгш бус байдал нэмэгдэх зэрэг олон үр дагаврыг үзүүлсэн байна. Түүнчлэн 2020 оны туршид сараас сард хүн амын хэрэглээ тогтворгүй байж асар ихээр хэлбэлзэж байжээ. Илүү нарийвчилж үзвэл Монгол Улс 2020 оны 2-р сарын эхнээс 11-р сар хүртэл хил боомтоо хааж, хатуу хөл хорио, өндөржүүлсэн бэлэн байдлын арга хэмжээг хэрэгжүүлж, 1-3-р сард тогтоосон хатуу хөл хорионы дараагаас дотооддоо чөлөөтэй зорчих хөдөлгөөнийг нээж, эдийн засгийн үйл ажиллагааг сэргээсэн зэрэг арга хэмжээнүүд авч байсан юм. Түүнчлэн оны эхэн үеэс гадаад худалдаанаас хамааралтай эдийн засгийн үйл ажиллагаанууд зогсонги байдалд орсон ч дотоодын эдийн засгийн үйл ажиллагаа 2020 оны ихэнх хугацаанд ердийн байдлаараа өрнөж байсан.

Бүтэн жилийн байдлаар нь судалж үзэхэд өрхүүдийн 2020 оны зарлага 2019 оныхоос өндөр байгаа бөгөөд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн төсвийн дэмжлэгийн томоохон арга хэмжээний үр дүнд ядуурал, тэгш бус байдал буурч, 2020 оны 11-р сард дотоодод халдвар дэгдэх үе хүртэл эдийн засгийн зарим үйл ажиллагаа тасалдаагүй байна.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн төсвийн дэмжлэгийн хөтөлбөр, нийгмийн хамгааллын хөтөлбөрүүд үр дүнгээ өгч хүн амын хэрэглээ нэмэгдэх, ялангуяа эмзэг бүлгийнхнийг ядуурч доройтохоос хамгаалахад шууд бөгөөд мэдэгдэхүйц нөлөө үзүүлсэн байна. Түүнчлэн ядуу бус хэсгийнхний хэрэглээ нэмэгдэхэд ч нөлөөлсөн байх магадлалтай байна. Гэсэн хэдий ч, нийгмийн хамгааллын арга хэмжээнүүд нь хатуу хөл хорионы уршгаар хүн амын хэрэглээнд учрах сөрөг нөлөөллийг даван туулахад хангалттай бус байсныг бидний судалгааны үр дүн харуулж байна.

НӨАТ-ын Их өгөгдлийн түүврийг ашиглан тооцсон ядуурал, тэгш бус байдлын үзүүлэлтүүд нь ӨНЭЗС-2018-нд тооцсон үзүүлэлтүүдээс ихээхэн өндөр байна. Өрхийн судалгаагаар тооцдог бүх төрлийн зардлуудыг НӨАТ-ын Их өгөгдлийн түүврийг ашиглан тооцох боломжгүй гэдгийг угаасаа бид урьдчилан таамаглаж байсан билээ. Хамгийн гол нь НӨАТ-ын Их өгөгдлийн түүврээр болон албан ёсны өрхийн судалгаагаар тооцсон ядуурал, тэгш бус байдлын үзүүлэлтүүдийн түвшингийн ялгаа зөрүү гэхээсээ илүүтэй Их өгөгдлийг ашиглан хүн амын ядуурал, тэгш бус байдалд гарч буй өөрчлөлтийг зарлагын үзүүлэлтээр нь сараар тооцох боломж байгаад ач холбогдол нь оршиж байгаа юм.

НӨАТ-ын Их өгөгдлийн түүврийг ашиглан тооцсон ядуурлын түвшин 2018 онд 56.6

хувь байсан бол 2019 онд 49.4 хувь, 2020 онд 44.6 хувь болж буурсан байна. 2020 онд эдийн засгийн томоохон хямрал тохиож байсан хэдий ч хүн амын ядуурал тодорхой хэмжээгээр буурсан бөгөөд энэ нь Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлсэн нийгмийн хамгааллын арга хэмжээ, мөн эртнээс авч хэрэгжүүлж ирсэн нийгмийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой байж болох юм.

Тэгш бус байдлыг илэрхийлдэг Жини коэффициент, Тейлийн индекс, Палма харьцаагаар тооцсон тэгш бус байдал 2020 онд мөн тодорхой хэмжээгээр буурсан байна. Тухайлбал, Их өгөгдлийн түүврээр тооцсон Жини коэффициент (өрхийн судалгаанд тооцсоноос өндөр) 2018 онд 0.474, 2019 онд 0.445, 2020 онд 0.419 байна.

Эдгээр үр дүн нь хэд хэдэн болгоомжлолыг дагуулж байгаа юм. Манай тохиолдолд НӨАТ-ын Их өгөгдлийг ашиглан хүн амын зөвхөн зарлагын үзүүлэлтийг тооцох боломжтой бөгөөд НӨАТ-ын цахим төлбөрийн бүртгэлийн системийн хамрах хүрээ өргөн, хурдацтай хөгжиж байгаа хэдий ч хүн амын хэрэглээг бүрэн тооцох боломжгүй байна. Түүнчлэн энэхүү мэдээллийн сан нь ядуу болон амьжиргаа сайтай хүмүүс зарлага, хэрэглээг хэр бүртгэж хэвшиж байгааг хянах боломжгүй учир хүн амын хэрэглээ илүү, аль эсвэл дутуу бүртгэгдэж ядуурал, тэгш бус байдлыг илэрхийлэх үзүүлэлтийг бодитой тооцох нөхцөлийг хязгаарлаж байж болзошгүй юм. Ийм болохоор НӨАТ-ын Их өгөгдлийг ашиглан хийсэн дүн шинжилгээ нь тогтсон арга аргачлалаар явуулдаг өрхийн судалгааг бүрэн орлож чадахгүй юм. Үүнээс гадна НӨАТ-ын Их өгөгдлийг ашиглан тэгш бус байдал, ядуурлын үзүүлэлтүүдийг тооцохдоо орлогын бус зарлагын үзүүлэлтийг үндэслэдэг. Тэгэхлээр, зарлагын тэгш бус байдал буурсан байж болох ч орлогын тэгш бус байдал нэмэгдсэн байх магадлал бий.

Гэхдээ НӨАТ-ын Их өгөгдөл нь өрхийн хэрэглээ, ядуурал, тэгш бус байдлын үзүүлэлтүүдийг тооцоход ашиглах мэдээллийн нэмэлт чухал эх сурвалж болохын зэрэгцээ өнөөг хүртэл хэрэгжүүлж байгаагүй өндөр давтамжтайгаар мэдээллийг богино хугацаанд шуурхай гаргах боломж олгоно. Монгол Улсын хөгжүүлсэн НӨАТ-ын цахим төлбөрийн бүртгэлийн энэхүү систем буюу ийм Их өгөгдөлтэй болсноор ядуурал, тэгш бус байдлын үзүүлэлтүүд нь удаан хүлээгдэж байж гардаг үзүүлэлтүүд биш болж байна. Эдгээр үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг тогтмол давтамжтайгаар сар бүрээр шуурхай гаргах боломж байгааг бидний судалгаа харууллаа. Ингэснээрээ нийгмийн хамгааллын төсвийн зарцуулалт, татвартай холбоотой арга хэмжээ зэрэг бодлогын өөрчлөлт нь ядуурал, тэгш бус байдалд хэрхэн нөлөөлж байгааг цаг алдалгүй судлах боломжийг олгож байна. Тэгэхлээр Их өгөгдөлд суурилсан судалгаа шинжилгээг нягт нямбай хийж чадвал төр засгийн бодлого шийдвэрт дэмжлэг үзүүлэх чухал хэрэгсэл болж чадна.

## 5.2. Их өгөгдлийг ашиглах зөвлөмж

НӨАТ-ын Их өгөгдөл нь бодлого шийдвэр гаргагчдад үнэтэй мэдээлэл өгөх боломж байна. Үүний зэрэгцээ, хувь хүний нууц, мэдээллийн нууцлалыг хүндэтгэн

хамгаалах нь нэн чухал. Энэ судалгааг хэрэгжүүлэх явцад бид Монгол Улсад анх удаа хувь хүний нууц, мэдээллийн нууцлалыг хадгалж хамгаалах тухай протокол зааврыг боловсруулан мөрдөхийн зэрэгцээ бодлогын шийдвэр гаргахад тус болохуйц шинжилгээ судалгааны ажлыг хийсэн болно.

Цаашид ижил төстэй судалгааг хийхдээ эдгээр протокол зааврыг ашиглах боломжтой (Бүлэг 2.2-ийг үзнэ үү). Мэдээлэл цуглуулах, боловсруулах, түгээх үйл явцыг цаашид хэрхэн сайжруулах арга замын талаар доор өгүүлнэ.

Нэгдүгээрт, тус системд зарлагын илүү олон төрөл ангиллыг бүртгэх боломжийг баталгаажуулахын тулд пос терминал машинуудыг илүү олноор суурилуулах ажлыг үргэлжлүүлэх хэрэгтэй. Пос терминал машиныг түгээн суурилуулахад санхүүгийн хүндрэл учрах тохиолдолд жижиг аж ахуйн нэгжүүд, албан бус аж ахуйн нэгжүүд, зах зээл дээр хөдөлмөр эрхлэгчид пос терминал машиныг хамтран ашиглах зохицуулалтын системийг бий болгох нь зохистой.

Хоёрдугаарт, ядуу буурай болон хөдөөгийн өрхүүдийн хувьд интернет холбоо, ухаалаг гар утасны хэрэглээ хязгаарлагдмал учир цахим төлбөрийн бүртгэлийн E-баримт системийг тэр бүр ашиглаж чадахгүй байгаа учир Засгийн газраас ийм хүмүүст боломж олгох үүднээс ухаалаг гар утас хэрэглэлгүйгээр төлбөрийн баримтаа системд бүртгүүлэх өөр арга зам, хэрэгсэлийг бодож олох хэрэгтэй. Жишээлбэл, вэб-д суурилсан E-баримтын интерфэйсийг сайжруулах (ухаалаг гар утасны аппликейшнаас гадна), Монгол Улсад түгээмэл ашиглагдах болсон нийтийн үйлчилгээний автомат ТҮЦ машинаас E-баримтын системд нэвтрэх боломжийг олгох, ерөнхийдөө, бүх нийтийг интернет хэрэглэх боломж нөхцөлийг өргөжүүлэх замаар ийм ажлыг хийх боломж бий.

Гуравдугаарт, зарлагыг төрлөөр нь ангилах боломж нөхцөлийг бүрдүүлэхийн зэрэгцээ төлбөрийн баримтыг системд бүртгэх хэт олон алхам бий болгож хэрэглэгчдэд дарамт учруулахгүйн тулд илүү хялбар сайн арга замыг бодож олох шаардлагатай.

Дөрөвдүгээрт, цахим төлбөрийн бүртгэлийн систем дэх аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл нь хувь хүмүүсийнхийг бодвол илүү бүрэн байдаг учир хэрэглэгчид болон аж ахуйн нэгжүүд (худалдан авагч, борлуулагч талууд)-ийн нууцлалыг чанд хадгалж нэр, хаяггүй мэдээллийг судалгаа шинжилгээ хийхэд ашиглах боломжийг бүрдүүлэх талаар Засгийн газар судалж үзэх хэрэгтэй. ӨНЭЗС-ны микро мэдээллийн санг судалгаанд хамрагдсан хүмүүсийн нэр хаяггүйгээр олон нийтэд ил болгосны нэгэн адил E-баримт системийн мэдээллийг нээлттэй болгох талаар Засгийн газрын зүгээс тодорхой алхам хийх боломж бий.

Тавдугаарт, татварын мэдээллийн төвийн техник хангамж, програм хангамж, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж мэдээлэл боловсруулалтыг илүү сайжруулах шаардлагатай байна. Өнөөгийн нөхцөлд, түүврийн мэдээллийг сонгож татахын тулд 24/7 цагийн горимд ажилладаг системийг зогсоох шаардлагатай болж байна. Гэтэл систем ажиллаж байх явцад шаардлагатай мэдээллийг системээс цуглуулж татах боломж нөхцөл бүрдсэн байх учиртай. Энэхүү үнэ цэнэтэй мэдээллийг зохих



ёсоор боловсруулах нөхцөлийг сайтар бүрдүүлэхийн тулд хүний нөөцийн чадавхи илүү сайн байх шаардлагатай.

Зургаадугаарт, энэхүү судалгаанд ашигласан арга зүй аргачлал нь аливаа мэдээллийн санг ашиглан судалгаа шинжилгээ хийх явцад тулгарч болзошгүй техникийн болоод хүнд суртлын саад бэрхшээлээс сэргийлэх, НӨАТ-ын цахим төлбөрийн бүртгэлийн E-баримт системийн мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах, нууцлалыг чандлан хадгалах зэрэг асуудлыг агуулсан заавал дагаж мөрдөх журам протоколыг бий болгох үндэс суурь болж чадна.

Энэхүү мэдээллийн системийг төрийн бодлого шийдвэрийг илүү оновчтой, цаг тухайд нь шуурхай гаргаж байхад тус болох мэдээллийн чухал эх сурвалж болгоход төрийн байгууллагууд, судлаачид, олон улсын байгууллагуудын үр дүнтэй хамтын ажиллагаа маш чухал байна.

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖУУД

АХБ (2019). Strengthening the Protection of Financial Consumers in Mongolia's Banking Sector. ADB East Asia Working Paper Series No 20. December 2019.

АХБ(2020). Үрдүнтэйнийгмийнхаламжийнсистемийнчадавхибэхжүүлэх(9-рсарын дугаар). <https://www.adb.org/sites/default/files/project-documents/51387/51387-001-tacr-en.pdf>

Батаагийн Эрдэнэбат, Батбэхийн Соёлмаа, (2020). Ковид-19 цар тахлын үеийн эдийн засгийн нөхцөл байдал, үзүүлэх нөлөө, хариу арга хэмжээний саналууд [Feedback and comments on response to the COVID affect to the economy], available from: [https://www.researchgate.net/publication/347945492\\_Kovid-19\\_car\\_tahlyn\\_eijn\\_edijn\\_zasgijn\\_nhcl\\_bajdal\\_zleh\\_nl\\_hariu\\_arga\\_hemzeenij\\_sanaluud](https://www.researchgate.net/publication/347945492_Kovid-19_car_tahlyn_eijn_edijn_zasgijn_nhcl_bajdal_zleh_nl_hariu_arga_hemzeenij_sanaluud)

Четти, Р., Хиндрин, Н., Жонес, М. Р., & Портер, С. Р. (2020). Race and economic opportunity in the United States: An intergenerational perspective. *The Quarterly Journal of Economics*, 135(2), 711-783.

Четти, Р., Фриедман, Ж. Н., Хиндрин, Н., Степнер, М., & TOI TEAM. (2020). The economic impacts of COVID-19: Evidence from a new public database built using private sector data. Working Paper 27431, National Bureau of Economic Research.

Касейчао, П.Н., & Ферэйра, П. М. (2005). The Young Person's Guide to the Theil Index: Suggesting Intuitive Interpretations and Exploring Analytical Applications. *SSRN Electronic Journal*, January 2019. <https://doi.org/10.2139/ssrn.228703>

Диатон, А., С. Зайди. 1999. Guidelines for Constructing Consumption Aggregates for Welfare Analysis. Princeton, Woodrow Wilson School - Development Studies.

Эйнав, Л., & Левин, Ж. (2014). Economics in the age of big data. *Science*, 346(6210). <https://doi.org/10.1126/science.1243089>

Химэлэйн, К. (2014). Weight Calculations for Panel Surveys with Subsampling and Split-off Tracking. *Statistics and Public Policy*, 1(1), 40-45. <https://doi.org/10.1080/2330443X.2013.856170>

Монголбанк (2020b). Mobile Banking Report. 3rd quarter of 2020.

Монголбанк (2020a). Банкуудын нэгдсэн балансын үзүүлэлтүүд. 2020 оын 12- сар. Цахим холбоос: <https://www.mongolbank.mn/liststatistic.aspx?id=8>. 2021 оны 3-р сарын 8-нд үзэв.

ҮСХ (Үндэсний статистикийн хороо). Дэлхийн банк, НҮБХХ (НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр). 2004. Өрхийн орлого, зарлагын судалгаа/Амьжиргааны түвшний судалгаа 2002-2003. Улаанбаатар, ҮСХ.

ҮСХ (Үндэсний статистикийн хороо). 2019. Өрхийн нийгэм-эдийн засгийн судалгаа 2018.

ҮСХ (Үндэсний статистикийн хороо). (2020a). Дотоодын нийт бүтээгдэхүүн. Үндсэн үзүүлэлтүүд, 2020(4). <https://doi.org/10.1787/54ace363-en>

ҮСХ (Үндэсний статистикийн хороо). (2020b). Монгол Улсын Нийгэм, эдийн засгийн төлөв байдал, сарын танилцуулга (1-12), 2020. Цахим холбоос: <https://www.1212.mn/BookLibrary.aspx?category=005&fbclid=IwAR3EQHutTrToQddOa4H1qKhkZ8DJz4Lb-VdN0eRvgdy50iqOU6LltMUCBWg>

ҮСХ (Үндэсний статистикийн хороо). 2021. Цахим хуудас: 1212.mn. 2021 оны 3-р сарын 20-нд үзэв.

ҮСХ, Дэлхийн банк. КОВИД-19 цар тахлын нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгаа – Эхний шатны үр дүн Цахим холбоос: <http://documents1.worldbank.org/curated/en/656061595316484647/pdf/Results-of-Mongolia-COVID-19-Household-Response-Phone-Survey-Round-1.pdf> 2021 оны 1-р сарын 4-нд үзэв.

Филзмосер, Р., Гүссэнбаяр, Ж., & Темпл, М. (2016). Detecting outliers in household consumption survey data. Vienna, Austria: Vienna University of Technology.

Уочи Икүко. (2020). Ядуурлын дүр төрх 2018 (No. 148387). <https://documents.worldbank.org/en/publication/documents-reports/documentdetail/532121589213323583/mongolia-poverty-update-2018>

НҮБХС. КОВИД-19 цар тахлын нөхцөл байдлын тайлан No. 6 (2020) <https://www.unfpa.org/resources/covid-19-situation-report-no-6-unfpa-mongolia>

## ХАВСРАЛТУУД

### 6.1. Их өгөгдлийг боловсруулах арга зүй, аргачлал

Энэхүү судалгаанд Татварын мэдээллийн төвийн НӨАТ-ын цахим төлбөрийн бүртгэлийн систем болон ҮСХ-ны 2018 оны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа (ӨНЭЗС-2018) гэсэн мэдээллийн хоёр эх сурвалжийг хамтад нь ашигласан.

Судалгааг эхлэх үед Монгол Улсад хамгийн сүүлд хийгдсэн өрхийн судалгаа нь ӨНЭЗС-2018 байсан билээ. ӨНЭЗС-2018-ны түүвэр нь тус улсын нийт хүн амыг төлөөлөх чадвартай бөгөөд санамсаргүй, шатлалт түүврийн аргаар өрхүүдийг сонгосон.<sup>37</sup> ӨНЭЗС-2018-нд нийт 16454 өрх хамрагдсан бөгөөд энэ нь тус улсын нийт өрхийн 1.8 хувь юм.

ӨНЭЗС-2018-ны түүврийг бид өөрийн судалгааны түүврийг баталгаажуулах мэдээллийн үндсэн багц болгон ашигласан. Үүнийг хийх болсон хэд хэдэн шалтгаан бий.

Нэгдүгээрт, Татварын мэдээллийн төвөөс энэхүү судалгаанд зориулж НӨАТ-ын Их өгөгдлийн зөвхөн түүврийг бидэнд гаргаж өгсөн юм. Их өгөгдлийн бүрэн мэдээллийг боловсруулахад төвөгтэй байсан нь мэдээллийн хэмжээ асар их, шилжүүлж дамжуулах явцад учирч болох багагүй эрсдэлтэй, тооцооллын өндөр хүчин чадал шаардагдсан зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж байсан. Гэсэн хэдий ч Их өгөгдлийн түүвэр нь манай судалгааны шаардлагыг хангаж байсан учир бүрэн мэдээллийг заавал ашиглах шаардлага гараагүй. Иймээс НӨАТ-ын Их өгөгдлийн сангаас түүвэр хийхийн тулд түүвэрлэлт хийх баталгаатай арга аргачлалыг ашиглах шаардлага тавигдсан. Нэгэнт ӨНЭЗС-2018-ны түүврийн хэмжээ улсын нийт хүн амыг төлөөлөх чадвартай тул бидний олж чадсан шийдэл бол НӨАТ-ын Их өгөгдлөөс ӨНЭЗС-2018-нд хамрагдсан өрхүүдийн мэдээллийг “сугалж авах” явдал байлаа. Ингэснээр ӨНЭЗС-2018-нд ашигласан түүвэрлэлтийн аргыг хэрэглэн НӨАТ-ын Их өгөгдлөөс түүвэрлэлт хийсэнтэй бидний хувьд утга адил болж байгаа юм.

Мэдээллийн хоёр эх сурвалжийг холбож ашигласны дараагийн гол шалтгаан бол хэрэглээ, ядуурал, тэгш бус байдлыг өрхийн түвшинд тооцох шаардлагатай байсанд оршиж байгаа юм. Гэтэл НӨАТ-ын Их өгөгдөл зөвхөн хувь хүмүүсийн мэдээллийг агуулдаг. Тэгэхлээр мэдээллийн эх сурвалжуудыг холбосноор НӨАТ-ын Их өгөгдлийн түүврээс авсан хувь хүмүүсийн мэдээллийг<sup>38</sup> ӨНЭЗС-2018-ны өрхийн түвшний мэдээлэлтэй холбох боломж бүрдсэн. Мэдээллийн эх сурвалжуудыг холбох ийм аргыг Четти болон бусад (2014) бүтээлд тодорхой тайлбарласан байдаг.


Ингээд НӨАТ-ын Их өгөгдлийг 2018 оны өрхийн судалгааны мэдээлэлтэй тохируулж дүйцүүлэх ажиллагааг яаж хийсэн талаар дараагийн хэсэгт алхам алхамаар нь тайлбарлана.

<sup>37</sup> Энэхүү судалгааг 2020 оны 10-р сард эхлэх үед.

<sup>38</sup> Хэн ч худалдан авалт хийсэн бай, төлбөрийн баримтыг тухайн өрхийн хэн нь ч буюу өөрөө, хань ижил, үр хүүхэд, гэр бүлийн бусад гишүүдийн аль нь ч Е-баримтын системд бүртгэх (сканнердах) боломжтой. Үүнийг ихэвчлэн эмэгтэйчүүд хийж байна. Гэхдээ хэрэглээ, зарлагыг үнэн бодитой тооцохын тулд тэдгээр бүртгэлийг эхлээд өрх бүрээр нэгтгээд, дараа нь өрхийн ам бүлийн тоонд хуваах хэрэгтэй.

Мэдээллийн хоёр эх сурвалжийн тоо мэдээллийг холбохдоо Улсын бүртгэлийн ерөнхий газраас тус улсын шинээр төрсөн иргэн бүрт олгодог Улсын бүртгэлийн дугаар буюу Регистрийн дугаар (РД) гэсэн хүн бүрийн өвөрмөц дахин давтагдаагүй дугаарыг ашигласан. Регистрийн дугаар (РД)-ын мэдээлэл нь маш нууцлалын зэрэгтэй бөгөөд түүнийг ҮСХ-ны Хүн ам, өрхийн мэдээллийн сан (ХАӨМС) удирдах үүрэгтэй. Хувь хүний нууцыг хамгаалах, мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах, РД-ыг зөвшөөрөлгүй этгээдэд дамжуулахгүй байх талаарх холбогдох хуулийн заалтыг чандлан дагаж мөрдөхийн тулд энэхүү судалгааны явцад баримтлах журам протоколыг боловсруулж хатуу мөрдсөн болно. Хариуцсан албан үүргийнхээ хүрээнд судалгааны багийн эрх бүхий гишүүд болон ҮСХ, Татварын мэдээллийн төвийн хариуцлагатай албан тушаалтнууд РД-тай мэдээллийг ашиглаж, эхний шатны боловсруулалтыг хийсэн. Түүвэрлэлт болон мэдээллийн эхний шатны боловсруулалтыг хийсний дараа түүвэрлэж авсан мэдээллийн нууцлалыг хангаж, дараа дараагийн боловсруулалт, шинжилгээг хийлгэхээр МУИС-ийн судлаачдын багт илгээсэн. Түүвэрлэлт, мэдээллийн боловсруулалт, нууцлалыг хангах үйл явцыг Зураг 12-т үзүүлсэн бөгөөд дараа дараагийн алхамуудыг удаах хэсгүүдэд дэлгэрэнгүй тайлбарласан болно.

**Зураг 12. Тус судалгаанд зориулсан Их өгөгдлийн эхний шатны боловсруулалт**



Нэгдүгээрт, ҮСХ-ны статистикчид ҮСХ-ны Хүн ам, өрхийн мэдээллийн сангаас (ХАӨМС) ӨНЭЗС-2018-нд хамрагдсан хүмүүсийн РД-тай мэдээллийг ашиглах зөвшөөрөл авсан.<sup>39</sup> Тэдгээр статистикчид “ӨНЭЗС-2018”-нд хамрагдсан 59820 хүний нэр, өрхийн дугаарыг гаргаж ХАӨМС-руу илгээсэн.

Хоёрдугаарт, ХАӨМС-гийн мэргэжилтнүүд нийт 59820 хүнээс зөвхөн 13733 өрхөд

<sup>39</sup> Судалгаанд хамрагдсан хүмүүсийн РД-ыг ӨНЭЗС-нд тэмдэглэж авдаггүй.

хамаарах 42991 хүний РД-ыг тогтоож чадсан.<sup>40</sup> Иймээс нэр, овог буруу бичигдсэн зэрэг шалтгаанаас болж зарим мэдээллийг сангаас сугалж авах боломжгүй болсон (РД нь олдоогүй).

Гуравдугаарт, ҮСХ эдгээр 42991 хүний РД-ыг тохируулахаар Татварын мэдээллийн төвд илгээсэн. Татварын мэдээллийн төвийн мэдээллийн ажилтнууд эдгээр 42991 хүний РД-ыг Татварын мэдээллийн төвийн НӨАТ-ын цахим төлбөрийн бүртгэлийн Е-баримт системд төлбөрийн баримтаа бүртгэдэг хүмүүсийн мэдээлэлтэй тулгаж шалгахад зөвхөн 23600 хүний РД тохирсон бөгөөд тэдгээрийн бүртгэсэн зарлагын мэдээлийг сараар нэгтгэж гаргасан.

Дөрөвдүгээрт, Татварын мэдээллийн төвөөс Цахим төлбөрийн баримтын Е-баримт системээс сараар гаргасан зарлагын мэдээллийг хүлээн авмагц ҮСХ-ны статистикчид эдгээр 23600 хүн 9826 өрхөд харьяалалтай болохыг тогтоож, ӨНЭЗС-2018-ны түүврийн мэдээлэлтэй тулгаж тохируулсан. Эдгээр хувь хүмүүсийн болон өрхүүдийн мэдээллийн нэрийн нууцлалыг хийсний (РД, нэрийг хассан) дараа уг мэдээллийн багцийг дараагийн шатны боловсруулалт, шинжилгээ хийлгэхээр МУИС-ийн судлаачдад илгээсэн болно.

Тавдугаарт, МУИС-ийн судлаачид мэдээллийн хоёр дахь шатны боловсруулалтыг хийсэн. Тэд олон нийтэд ил болсон ӨНЭЗС-2018-нд хамрагдсан хүмүүсийн хүйс, нас, байршил, өрхийн ам бүлийн тоо, хүүхдийн тоо зэрэг хувь хүн, өрхийн ерөнхий шинж байдлыг илэрхийлсэн мэдээллийг олж авсны зэрэгцээ эдгээр ерөнхий шинж байдлаар нь Их өгөгдлийн түүврийн нэрийг нь нууцалсан зарлагын мэдээлэлтэй нэгтгэж дүн шинжилгээ хийсэн.<sup>41</sup> Зарлагын мэдээлэл нь дутуу хүмүүсийн бүртгэлээс шалтгаалах хүндрэлийг багасгах<sup>42</sup> үүднээс МУИС-ийн судлаачид төлбөрийн баримтаа тогтмол бүртгэдэггүй хүмүүсийг тусад нь ялгасан. Мэдээллийн эхний боловсруулалтаас сонгогдсон 9826 өрхөөс 2018-2020 онд жил дараалан гишүүд нь жилд ядаж нэг удаа төлбөрийн баримтаа Е-баримт системд бүртгэсэн өрх дөнгөж 7127 байсан. Дахин цааш нь шүүж үзэхэд гишүүд нь улиралд ядаж нэг удаа төлбөрийн баримтаа Е-баримт системд бүртгэсэн өрх 5069, эдгээр гурван жилийн хугацаанд гишүүд нь сард ядаж нэг удаа төлбөрийн баримтаа Е-баримт системд бүртгэсэн өрх 4463 байгааг олж тогтоосон. Эцсийн шалгуурыг ийнхүү илүү нарийсгах замаар сард ядаж нэг удаа төлбөрийн баримтаа Е-баримт системд бүртгэсэн өрхүүдийг л түүвэрт үлдээсэн болно. Ингээд судалгаанд ашиглах түүвэрт 4463 өрхийг хамруулсан бөгөөд тэдгээрийг энэхүү тайланд цаашид “Их өгөгдлийн түүвэр” гэж нэрлэнэ (Зураг 12-ыг үзнэ үү).

Их өгөгдлийн түүвэрлэлтийг хийсэн алхам болон мэдээллийн нууцлалыг хэрхэн хангасан талаарх үйл явцыг доорх хүснэгтэд үзүүлээ.

<sup>40</sup> 13733 өрх бол “ӨНЭЗС-2018-ны өрхүүдээс Е-баримт системд олдсон өрхүүд” юм.

<sup>41</sup> Монгол Улсад ӨНЭЗС-нд хамрагдсан хүмүүсийн нэрийг нь нууцалсан задгай мэдээлэл олон нийтэд нээлттэй болсон.

<sup>42</sup> Хүмүүс төлбөрийн баримтаа Е-баримт системд тэр бүр бүрэн бүртгэхгүй, дутуу бүртгэх нь түгээмэл бөгөөд сар бүр тогтмол бүртгэхгүй байх тохиолдол ч олон. Иймээс Е-баримт системийн мэдээлэл нь хувь хүмүүсийн зарлагын талаар бүрэн мэдээллийг өгөхгүй.

Олон нийтэд хэдийнээ нээлттэй болсон ӨНЭЗС-2018-нд хамрагдсан өрхүүдийн задгай мэдээллийн багц, НӨАТ-ын Их өгөгдлийн түүврээс тооцсон зарлагын мэдээллийн багц зэргийг агуулсан нэгдсэн мэдээлэл (цаг хугацааны дараалалтай) нь үр дүнгийн мэдээллийн багц болно.

**Хүснэгт 10. НӨАТ болон ӨНЭЗС-2018-ны мэдээллийн эхний шатны боловсруулалтын үйл явц**

Алхам	Мэдээллийн эх сурвалж	Мэдээлэл хүлээн авагчид	Өрхийн тоо	Хүний тоо	Тайлбар
1. ӨНЭЗС-2018-ны түүвэрт хамрагдсан нийт хүн амыг тодорхойлох	ҮСХ, ӨНЭЗС 2018	ҮСХ, ХАӨМС	16,454	59,820	ӨНЭЗС-2018-нд хамрагдсан 16454 өрхийн 59820 хүний мэдээллийг Тооллогын мэдээлэлтэй тулган шалгаж 13733 өрхийн 42991 хүний РД-ыг олж тогтоосон.  Үлдсэнийх нь овог, нэр нь алдаатай болон бусад шалтгаанаар РД-ыг нь олж чадаагүй. Энэ алхамыг ҮСХ-ны ХАӨМС-ийн РД-тай мэдээлэлтэй ажиллах эрх бүхий хүмүүс гүйцэтгэсэн
2. РД-ыг нь олсон хүмүүсийн мэдээллийг Татварын мэдээллийн төв рүү илгээх	ҮСХ	Татварын мэдээллийн төв	13,733	42,991	ҮСХ-ны ХАӨМС дээрх 42991 хүний РД-ыг олж Татварын мэдээллийн төвд хүргүүлсэн.
3. Е-баримт системээс түүвэр хийхийн тулд мэдээллийг тулгаж шалгах	Татварын мэдээллийн төв	ҮСХ	9,826	23,600	Эдгээр 42991 хүнээс 23600 хүнийх нь мэдээлэл Е-баримт системд олдсон. Энэ нь үлдсэн 19391 хүн нь Е-баримт системийг ашигладаггүй гэсэн үг юм.
4. Их өгөгдлийн түүвэрт хамрагдсан хүмүүсийн нэрийг нууцлах	ҮСХ	МУИС-ын судлаачид	9,826	23,600	Ингээд ҮСХ эдгээр 23600 хүний мэдээллийн багцийг нэрийг нь нууцлан (РД-ыг арилгаад) судлаачид руу илгээсэн.

5. Түүврийг илүү нарийвчилж тогтоох	ҮСХ	МУИС-ын судлаачид	9,826 ↓ 4,463	37,382 <sup>43</sup> ↓ 17,607	<p>Мэдээллийн багцийн чанарыг баталгаажуулах үүднээс судлаачид дахин шүүж E-баримт системийг тогтмол ашигладаг өрхүүдийг ялгаж авсан. 2018-2020 онуудад дараах байдал ажиглагдсан:</p> <ul style="list-style-type: none"> <li>• 7127 өрх жилд ядаж нэг удаа E-баримт системийг ашигласан байв.</li> <li>• 5069 өрх улиралд ядаж нэг удаа E-баримт системийг ашигласан байв.</li> <li>• 4463 өрх сард ядаж нэг удаа E-баримт системийг ашигласан байв.</li> </ul> <p>Энэ судалгаанд ашиглах түүвэрт 4463 өрхийг сонгосон бөгөөд тэдгээрийг энэхүү тайланд цаашид “Их өгөгдлийн түүвэр” гэж нэрлэнэ</p>
-------------------------------------	-----	-------------------	---------------------	-------------------------------------	---

## 6.2. Мэдээлэл боловсруулалтын хоёр дахь үе шат

Их өгөгдлийн түүвэр нь зарим хэт утгыг (outliers) агуулж байна. Жишээлбэл, зарим нэг өрхийн сарын зарлага 100 сая төгрөг<sup>44</sup> болж байгаа бол зарим өрхийн сарын ердийн зарлага нь нэг сая орчим төгрөг байх зэрэг тохиолдлууд ч байна. Ийм хэт утгууд орсноор тэгш бус байдлыг илэрхийлэх үзүүлэлтүүд, регрессийн коэффициентод мэдэгдэхүйц нөлөө үзүүлж байна.

Бид өгөгдлийн утгыг Вох-Сох бүлийн хувиргалт хийх замаар нэг хувьсагчтай хэт утгыг (outlier) илрүүлэх аргыг ашигласан (Filzmoser, Guesenbauer, and Templ, 2016).<sup>45</sup> Тухайлбал, 2016 онд E-баримт системд сарын 100 сая гаруй төгрөгийн зарлага бүртгүүлсэн 6 өрх байгааг бид олж тогтоосон. Үүний нэгэн адил, сард 100 сая гаруй төгрөгийн төлбөрийн баримтыг E-баримт системд бүртгэсэн өрхийн тоо 2017 онд 12 байсан бол ийм өрхүүдийн тоо 2018 онд 40, 2020 онд 59 болсон байна. Бид хэт өндөр, аль эсвэл хэт бага утгыг илрүүлмэгц тухайн өрхийн тэргүүний

<sup>43</sup> НӨАТ-ын Их өгөгдлийн түүвэрт 9826 өрхийн 23600 хүн, ӨНЭЗС-2018 түүвэрт 9826 өрхийн 37382 хүн тус тус хамрагдсан байна. Учир нь НӨАТ-ын Их өгөгдлийн системд ихэвчлэн насанд хүрсэн хүмүүс төлбөрийн баримтаа бүртгэдэг учир зөвхөн тэдгээрийн мэдээлэл орж байна. Харин ӨНЭЗС-2018-нд зөвхөн худалдан авалт хийдэг насанд хүрсэн хүмүүс бус хүүхэд, хөгшид зэрэг гэр бүлийн бусад бүх гишүүдийн мэдээлэл орж байгаа юм.

<sup>44</sup> Одоогийн ханшаар 35087 ам. доллар

<sup>45</sup> Бид “медиан+/-3IQR” дүрмийг мөрдсөн. IQR-interquartile range.



ажилладаг салбарыг ӨНЭЗС-2018-ны түүврийн мэдээллээс хайж үзэхэд тэдгээр хүмүүс ихэвчлэн үйлчилгээний салбарт ажилладаг болохыг тогтоосон. Бүр гүнзгийрүүлэн судалж үзэхэд томоохон худалдан авалт хийдэг өрхийн тэргүүн төдийгүй бусад гишүүд нь худалдаа, үйлчилгээний салбарт ажилладаг болох нь ч мөн тогтоогдож байв. Энэ нь бизнесийн байгууллагуудын үйлчилгээний салбарын ажилтнууд бусад үйлчлүүлэгчдийн төлбөрийн баримтыг (хууль бусаар) Е-баримт системд өөрсдийнх мэт бүртгэх (сканнердах) үйлдэл хийж байж болзошгүй гэсэн дүгнэлт хийхэд хүргэж байгаа юм. Татварын мэдээллийн төвийн ажилтнууд ч энэ таамаглалыг үгүйсгээгүй билээ. Ийм хэт утга илэрч байгаа хүмүүсийн зарлагын тооцоог тэдгээрийн ердийн үеийн зарлагатай дүйцүүлж шинжилсэн.

### 6.3. Дахин жинлэлт болон зөрүүний тохируулга

ӨНЭЗС-2018-нд санамсаргүй түүврийн аргаар нийт 16488 өрхийг сонгосон бөгөөд эдгээр нь улс, бүс, аймгийг (Улаанбаатар, аймаг, сум, хөдөө) төлөөлөх чадвартай.

Гэхдээ хөдөө орон нутгийн өрхүүд төлбөрийн баримтаа тэр бүр НӨАТ-ын Е-баримт системд бүртгэхгүй байгаа учир НӨАТ-ын Их өгөгдлийн түүвэрт (4463 өрх нь ӨНЭЗС-2018-ны түүврийн нэг хэсэг юм) тэдгээрийн төлөөлөх чадвар сул байна. Хөдөөгийн айл өрхүүдээс, ялангуяа, хөдөө орон нутагт амьдардаг хүмүүс (малчин өрхүүд) манай судалгааны түүвэрт маш сул төлөөлөлтэй байгаа юм. Манай түүвэрт хамрагдсан хөдөөгийн өрхүүд ӨНЭЗС-2018-нд хамрагдсан хөдөөгийн өрхүүдийн дөнгөж 8.3 хувийг бүрдүүлж байгаа нь улсын дундаж болох 27.1 хувиас ихээхэн бага байна). Сумын төвийн айл өрхүүдийн төлөөлөл ч мөн сул байгаа төдийгүй улсын дунджаас ч бага буюу 22.3 хувь байна. Харин эсрэгээрээ Улаанбаатар хот болон аймгийн төвийн өрхүүдийн төлөөлөл улсын дунджаас харьцангуй өндөр буюу 37.1, 35.8 хувь байна.

Ийм тэнцвэргүй, зөрүүтэй түүврийг ашиглах аваас нийт хүн амыг төлөөлөх чадвар сул болох бөгөөд гарсан үр дүнд нь ч дүгнэлт хийх боломж хязгаарлагдана. Иймээс өрхүүдийг байршлын дөрвөн төрлөөр (Улаанбаатар, аймаг, сум, хөдөөгийн түвшин) жинлэж тус бүрийг нь төлөөлөх дэд түүврийн хүрээг тогтоосон.<sup>46</sup>

Тухайлбал, ӨНЭЗС-2018-ны түүвэрт Х өрх 50 гэсэн жинтэй байсан гэж үзье. Тэгвэл тухайн өрх тус улсын нийт өрхүүдээс 50 өрхийг нь төлөөлнө гэсэн үг. Гэхдээ Х өрх цаашид ӨНЭЗС-2018-ны түүвэрт дахин “сонгогдох” эсэх магадлал байж болох ч, мөн эцсийн түүвэрлэлтэд орох ч магадлал бас бий. Жишээлбэл, ӨНЭЗС-2018-нд хамрагдсан Улаанбаатар хот болон аймгийн төвд амьдардаг өрхийн 30 гаруй хувь нь л Их өгөгдлийн эцсийн түүвэрт орсон бол сумын төвд амьдардаг өрхийн дөнгөж 22.3 хувь, хөдөөгийн өрхийн 8.3 хувь нь Их өгөгдлийн түүвэрт хамрагдсан байна. Хэрэв бидний дээр өгүүлсэн ӨНЭЗС-2018-нд хамрагдсан Х өрх маань Их өгөгдлийн түүвэрт орсон тохиолдолд хэрэв Улаанбаатарынх бол нийт өрхүүдийн дундаас 135 орчим өрхийг (50/0.371 ~ 135) төлөөлөх болно. Харин хөдөөнийх бол

<sup>46</sup> Бусад бүлгүүдийн төлөөлөл бага байж болох ч ӨНЭЗС-ны жинлэх аргачлалын дагуу жинг зөвхөн байршлаар хийсэн болно.

ойролцоогоор 602 өрхийг (50/0.083 ~ 602) төлөөлөхөөр байна.

Дахин жинлэлтийн эдгээр жишээнүүдийг төсөөлөл хэлбэрээр хялбаршуулж үзүүлсэн болно.

Ийм дахин жинлэлтийг Улаанбаатар, аймгийн төв, сумын төв, хөдөө гэсэн байршлын дөрвөн төрлөөр хийсэн. Түүнчлэн ядуурал, тэгш бус байдлын үзүүлэлтүүдийг тооцохдоо эдгээр өрхийн жинлэлтийг харгалзан үзсэн тул эцсийн үр дүнгүүд нь улсын нийт хүн ам болон байршлаар нь тодорхойлсон хүн амыг бүрэн төлөөлөх чадвартай болох юм.

Хүснэгт 11-т жинлэсэн болон жинлээгүй өрхүүдийн хувийн жинг байршлаар нь үзүүлэв. Жинлэсэн тохиолдолд, сум, хөдөөгийн айл өрхүүдийн хувийн жинд зарим ялгаа байгаа хэдий ч НӨАТ-ын Их өгөгдлийн түүвэр нь ӨНЭЗС-2018-ны түүвэртэй тун төстэй байна (Их өгөгдлийн түүврийн жингийн талаарх илүү дэлгэрэнгүй тайлбарыг Хавсралт 1-ээс үзнэ үү).

**Хүснэгт 11. Их өгөгдлийн түүвэрт хамрагдсан өрхийн хувийн жин, байршлаар, жинлэлтийн өмнө болон дараа**

	Жинлээгүй		Жинлэсэн	
	ӨНЭЗС	НӨАТ	ӨНЭЗС	НӨАТ
<b>Улаанбаатар</b>	21.7%	29.7%	45.8%	44.4%
<b>Аймаг</b>	32.8%	43.3%	20.5%	20.3%
<b>Сум</b>	25.4%	20.8%	18.1%	24.3%
<b>Хөдөө</b>	20.1%	6.1%	15.6%	11.0%
	100.0%	100.0%	100.0%	100.0%

#### 6.4. Тооцооллын аргачлал

Энэхүү судалгааны явцад бид статистикийн байгууллагуудын ашиглаж ирсэн хэрэглээ, ядуурал, тэгш бус байдлын үзүүлэлтүүдийг тооцох арга аргачлалыг аль болохоор ашиглаж сайжруулахыг хичээсэн. Гэхдээ хэрэглээний үзүүлэлтүүд, түүнчлэн Их өгөгдлийг ашиглан тооцсон ядуурал, тэгш бус байдлын үзүүлэлтүүд нь өрхийн судалгаагаар тооцсон үзүүлэлтүүдээс ялгаатай байгаа нь эдгээр эх сурвалжуудын үндсэн эх мэдээллийг цуглуулсан арга хэлбэрээс шалтгаалж байгааг тэмдэглэх нь чухал юм. Иймээс эдгээр үзүүлэлтүүдийг тооцохдоо ашигласан арга аргачлал, мөн өмнө өгүүлсэн мэдээллийн хоёр эх сурвалжаас тооцсон үзүүлэлтүүдийн ижил төстэй болон ялгаатай талыг нь энэ хэсэгт дэлгэрэнгүй тайлбарлана.

#### 6.4.1. Хэрэглээний (зарлагын) тооцоолол

НӨАТ-ын Их өгөгдлийн түүврээс тооцсон хэрэглээний үзүүлэлтүүд нь ӨНЭЗС-гаар тооцсон хэрэглээний үзүүлэлтүүдээс ялгаатай. ӨНЭЗС болон НӨАТ-ын Их өгөгдлийн түүврийг ашиглан тооцсон хэрэглээний үзүүлэлтүүд ихээхэн зөрүүтэй байна.

НӨАТ-ын Е-баримт системд хүмүүс зөвхөн төлбөрийн баримтуудаа бүртгэж байгаа учраас хүмүүсийн өөрийн үйлдвэрлэлийн болон эзэмшлийн эд зүйл, орон сууцны “хэрэглээ” зэрэг зардлууд уг системд бүртгэгдэхгүй байна. Монгол Улсын малчин өрхүүдийн дийлэнх нь мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүнийг өөрсдөө бэлтгэн хэрэглэж байгаа нь тэдний хүнсний хэрэглээний зонхилох хувийг бүрдүүлж байна (Шигтгээ 1-ийг үзнэ үү). Үндэсний Статистикийн Хорооноос явуулдаг өрхийн судалгаанд өөрийн үйлдвэрлэлийн болон эзэмшлийн бүтээгдэхүүн, хувийн өмчийн орон сууцны хэрэглээг тооцохдоо тухайн өрх өөрийн үйлдвэрлэлийн болон эзэмшлийн эд зүйлгүй, хувийн орон сууцгүй тохиолдолд тухайн өрх ийм хэрэгцээндээ ямар хэмжээний зардал гаргаж болохыг баримжаалж тооцож байна. Харин бидний судалгааны тооцоо бүхэлдээ Их өгөгдөлд суурилж байгаа бөгөөд НӨАТ-ын Е-баримт системд өрхүүдийн бүртгүүлсэн төлбөрийн баримтаар гарч байгаа нийт зарлагын мэдээлэлд үндэслэсэн.

Тоймлон авч үзвэл, өөрийн үйлдвэрлэлийн болон эзэмшлийн эд зүйлийн хэрэглээ нь хүн амын хэрэглээ, зарлагын ялгааг бий болгож байна. Зарлага буюу зардлын үзүүлэлт нь зөвхөн зах зээлээс худалдан авсан эд зүйлсийн хэрэглээг илэрхийлж байгаа бол хэрэглээний үзүүлэлт нь бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээ, түүний дотор зах зээлээс гадуур олж авсан эд зүйлсийн хэрэглээг хамтад нь илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл,

***ӨНЭЗС-ны Хэрэглээ = Зарлага + Өөрийн үйлдвэрлэлийн болон эзэмшлийн эд зүйлийн хэрэглээ***

Энэ утгаараа, НӨАТ-ын Их өгөгдлийн түүврээс зөвхөн зарлагын үзүүлэлтүүд гарах бөгөөд энэ нь бидний судалгаанд хэрэглээний үзүүлэлтийг орлож байгаа юм.

Үүнээс гадна, зарим бүтээгдэхүүн, үйлчилгээ НӨАТ-аас чөлөөлөгдсөн, татварын буцаан олголт байдаггүй учир хэрэглэгчид ийм төрлийн төлбөрийн баримтаа НӨАТ-ын Е-баримт системд бүртгэхэд түлхэц болох ямар нэгэн хөшүүрэг үгүй байна. Түүнчлэн зарим төлбөрүүд ПОС терминал машингүй жижиг хэмжээний болон албан бус худалдаа арилжаа эрхлэгчдээр дамжин хийгдэж байгаа тул ийм төрлийн төлбөрийн баримтууд Е-баримт системд бүртгэгдэхгүй байна. Монгол Улсын Засгийн газраас жижиг хэмжээний болон албан бус худалдаа арилжаа эрхлэгчдэд хандан ПОС терминал машины системийг суурилуулахыг шаардаж байгаагийн хүчинд ПОС терминал машин хэрэглэгч жижиг аж ахуйн нэгжийн тоо сүүл үед нэмэгдэж эхэлсэн боловч хамралтын хүрээ бага хэвээр байна. Энэ нь эдийн засгийн үйл ажиллагааны багагүй хэсэг нь албан бус хэвээр байгаатай холбоотой байна. Монгол Улсад хөгжүүлсэн НӨАТ-ын Е-баримтын системд хамрагдаж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Шигтгээ 1-ээс үзнэ үү.


Бидний судлахыг зорьсон бас нэг асуудал бол КОВИД-19 цар тахлын хямралын үед

хэрэглэгчдийн зарлагын төрөл ангилалд ямар өөрчлөлт гарсныг судлах байсан юм. Гэсэн хэдий ч НӨАТ-ын Их өгөгдлийн төрөл ангилал хязгаарлагдмал байсан учир энэ зорилго маань бүтээгүй юм (Шигтгээ 1-ийг үзнэ үү).

**Шигтгээ 1. Хэрэглээний төрөл, Монгол Улсын НӨАТ-ын Е-баримт систем**

Эхний ангиллыг хуулийн этгээдийн бүртгэлийн төрлийг үндэслэн хийнэ. Тухайн хуулийн этгээд боловсрол, эрүүл мэнд, худалдаа гэх мэт ямар салбарт үйл ажиллагаа явуулж байгаа зэргээс нь хамаарч холбогдох салбарт нь бүртгэнэ. Хэрэв тухайн хуулийн этгээд олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалт эрхэлдэг бол Е-баримтыг “бусад” гэсэн ангилалд бүртгэнэ. Жишээлбэл, том хүрээний худалдаа арилжаа эрхэлдэг бол, өөрөөр хэлбэл, супермаркет, их дэлгүүрийг “бусад” гэж ангилах учир эдгээр дэлгүүрт хийсэн худалдан авалтыг “бусад” гэж ангилна. Үүнээс үүдэн НӨАТ-ын Их өгөгдлийн системд бүртгэгдсэн зардлын бараг 90 орчим хувь нь “бусад” гэсэн ангилалд орж байгаа учир, систем дэх зардлын ангиллын ач холбогдолыг нь сулруулж байгаа юм.

Хоёрдахь төрлийн ангилал нь хэрэглэгчид төлбөрийн баримтыг Е-баримт системд бүртгэхдээ (сканердахад) үүсгэх зарлагын ангиллыг үндэслэнэ. Энэ хувилбарыг 2019 оны 1-р сараас ашиглаж эхэлсэн. Хэрэглэгч төлбөрийн баримтаа НӨАТ-ын Е-баримт системд бүртгээд “оруулах” товч дарахын өмнө дэлгэц дээр гарч ирэх зардлын 12 төрлийн категориос тохирохыг нь сонгон тэмдэглэх боломжтой болсон (Баруун талын зургийг үзнэ үү. Хэрэглэгч зардлаа ангилах боломжийг харуулсан Е-баримт системийн дэлгэцийн зураг). Гэхдээ ийнхүү зардлаа ангилах аргыг саяхнаас



нэвтрүүлж эхэлсэн бөгөөд дийлэнх хэрэглэгчид зардлаа ангилах энэхүү нэмэлт алхамыг хийж хэвшээгүй байна.

Эдгээр шалтгааны улмаас КОВИД-19 цар тахлын хямралын үед Монгол Улсын хүн амын хэрэглээний төрөл ангилал хэрхэн өөрчлөгдсөн тухай судалгааныхаа асуултад бид хариу олж чадаагүй билээ. Гэхдээ доорх хүснэгтэд бид НӨАТ-ын Е-баримт системээс тооцох боломжтой зардлын 12 төрлийн категорийн хамралтын хүрээг аль болох өргөжүүлэх боломжийн талаарх тайлбарыг оруулсан. Ингэснээр өрхийн судалгаа болон НӨАТ-ын цахим төлбөрийн бүртгэлийн систем зэрэг мэдээллийн эх сурвалжаас тооцсон хэрэглээ болон зарлагын үзүүлэлтүүдийн ялгааг илүү сайн ойлгох боломж бүрдэнэ.

**Хүснэгт 12. Е-баримт систем дэх зарлагын категориуд, хамралтын хүрээ**

Зарлагын категориуд	НӨАТ-ын Е-баримт системийн хамралтын хүрээ
<b>Хүнс</b>	<p>Дотоодын үйлдвэрлэлийн хүнсний бүтээгдэхүүний борлуулалт НӨАТ-аас чөлөөлөгддөг. Тэгэхлээр импортын хүнсний бүтээгдэхүүн, гэр ахуйн бараа бүтээгдэхүүн зэрэг бусад бараа бүтээгдэхүүнтэй хамт худалдаж аваагүй л бол дотоодын үйлдвэрлэлийн хүнсний бараа бүтээгдэхүүн худалдан авсан төлбөрийн баримтаа хэрэглэгчид Е-баримт системд заавал бүртгэх тодорхой хөшүүрэг байдаггүй. Практик дээр ихэнх худалдан авалт хийгдэж байгаа супермаркетууд болон олон төрлийн бараа бүтээгдэхүүн борлуулдаг томоохон хэмжээний хүнсний дэлгүүрүүдийн төлбөрийн баримтуудыг хэрэглэгчид Е-баримт системд оруулах нь түгээмэл байгаа бөгөөд харин хүнсний захуудын албан бус лангуугаар зарж борлуулдаг хүнсний бүтээгдэхүүний төлбөрийн баримтаа хэрэглэгчид тэр бүр Е-баримт системд оруулахгүй байна.</p> <p>Өөрийн үйлдвэрлэлийн хүнсний хэрэглээ зах зээлээр дамжин гүйлгээ хийгддэггүй учир Е-баримт системд бүртгэгдэхгүй байна.</p>
<b>Бэлэн хувцас</b>	<p>Бэлэн хувцасны борлуулалтад НӨАТ ногдуулдаг тул ихэнх бэлэн хувцасны худалдан авалтын төлбөрийн баримтыг хэрэглэгчид Е-баримт системд бүртгэж байна. Гэхдээ жижиг худалдаа эрхлэгчдээс бэлэн хувцас худалдан авсан болон өөрийн үйлдвэрлэлийн бэлэн хувцас хэрэглэсэн зэрэг тохиолдлууд Е-баримт системд бүртгэгдэхгүй байна.</p>

<p><b>Ахуйн хэрэглээ</b></p>	<p>Ахуйн үйлчилгээ, үсчин, гоо сайхны салон, засварын газар, угаалгын газар, хими цэвэрлэгээ зэрэг үйлчилгээ нь НӨАТ-тай. Иймээс эдгээр үйлчилгээний төлбөрийн баримтыг албан бус үйлчилгээ л бус бол ихэнх тохиолдолд хэрэглэгчид E-баримт системд бүртгэж байна.</p> <p>Энэ ангилалд НӨАТ-тай гэр ахуйн цахилгаан хэрэгсэл гэх мэт удаан эдэлгээтэй гэр ахуйн бараа бүтээгдэхүүн орно. Эдгээр бараа бүтээгдэхүүний дийлэнх нь импортынх байдаг бөгөөд ихэнхдээ жижиглэнгийн худалдаа эрхэлдэг томоохон дэлгүүр газруудаар худалдаалагддаг тул эдгээр барааны төлбөрийн баримт E-баримт системд ихэвчлэн бүртгэгдэж байна. Гэсэн хэдий ч НӨАТ-ын Их өгөгдөл болон өрхийн судалгаагаар тооцсон ахуйн хэрэглээний бараа бүтээгдэхүүн худалдан авахад зарцуулсан зарлагын дүн нилээд ялгаатай байна. Өрхийн судалгаанд эдгээр бараа бүтээгдэхүүнийг хэдийд ямар зориулалтаар худалдан авсныг нь бүртгэж ашиглагдаж байгаа хугацаагаар нь хэрэглээг тооцоход ашигладаг бол бидний хийсэн Их өгөгдлийн түүвэр судалгаанд эдгээр бараа бүтээгдэхүүнийг худалдан авсан тухайн цаг хугацаанд нь “бөөнөөр” нь бүртгэж байна.</p>
<p><b>Харилцаа холбоо</b></p>	<p>Харилцаа холбооны үйлчилгээ НӨАТ-тай бөгөөд эдгээр үйлчилгээний төлбөрийн баримтыг хэрэглэгчид ихэвчлэн E-баримт системд бүртгэж байна.</p>
<p><b>Боловсрол</b></p>	<p>Боловсролын үйлчилгээ нь НӨАТ-аас чөлөөлөгддөг. Төрийн өмчийн бага, дунд, бүрэн дунд боловсролын үйлчилгээ төлбөргүй. Хувийн хэвшлийн боловсролын байгууллагууд өсөн нэмэгдэж байгаа хэдий ч хүмүүс хүүхдүүдээ ихэнхдээ улсын сургууль, цэцэрлэгт хамруулж байна. Иймээс ихэнх боловсролын үйлчилгээний төлбөрийн баримтыг хэрэглэгчид НӨАТ-ын E-баримт системд бүртгэхгүй байна. Учир нь боловсролын үйлчилгээтэй холбоотой зах зээлийн гүйлгээ гардаггүйн зэрэгцээ хувийн хэвшлийн боловсролын үйлчилгээний төлбөрийн баримтууд, төрийн өмчийн дээд боловсролын үйлчилгээний төлбөрийн баримтуудыг хэрэглэгчид E-баримт системд бүртгэхэд түлхэц болох тодорхой хөшүүрэг үгүй байна. Гэсэн хэдий ч боловсролын үйлчилгээ эрхлэгчдийг ПОС терминал машин суурилуулж, E-баримт системд зардлаа бүртгэж байх шаардлага тавигддаг бөгөөд сургалтын төлбөрийн баримтаа элдэв урамшуулал харгалзалгүй бүртгэж байгаа хэрэглэгчдийн тоо цөөн байна.</p>

<p><b>Эрүүл мэнд</b></p>	<p>Боловсролын үйлчилгээний нэгэн адил эрүүл мэндийн үйлчилгээ НӨАТ-аас чөлөөлөгддөг. Үүнд мал эмнэлгийн үйлчилгээ ч мөн хамаарч байна. Гэхдээ хувийн хэвшлийн байгууллагуудын эрхэлдэг эрүүл мэндийн үйлчилгээ болон нийтийн эрүүл мэндийн төлбөртэй үйлчилгээний хувь хэмжээ боловсролын салбарынхаас өндөр байна. Эрүүл мэндийн үйлчилгээ эрхлэгчид төлбөрийн баримтуудаа Е-баримт системд бүртгэж байгаа бөгөөд хэрэглэгчдийн багагүй хувь нь эрүүл мэндтэй холбоотой зардлаа Е-баримт системд бүртгэж байна.</p>
<p><b>Төрийн үйлчилгээ</b></p>	<p>Төрийн үйлчилгээ НӨАТ-аас чөлөөлөгддөг. Гэхдээ төрийн төлбөртэй зарим үйлчилгээ авч буй хэрэглэгчдийн багахан хувь нь төлбөрийн баримтаа Е-баримт системд бүртгэж байна.</p>
<p><b>Амралт зугаалга</b></p>	<p>Зочид буудал, зоогийн газар, нийтийн хоолны үйлчилгээ зэрэгт НӨАТ ногдуулдаг. Бодит байдал дээр ийм төрлийн үйлчилгээ эрхэлж буй жижиг болон албан бус аж ахуй эрхлэгчид ПОС терминал машин ашиглахгүй байгаагийн зэрэгцээ Е-баримт системд уншуулахад тохирохоор төлбөрийн баримт олгохгүй байна.</p> <p>Нийтийн тээврийн үйлчилгээнээс бусад тээврийн үйлчилгээнд НӨАТ ногдуулдаг. Гэсэн хэдий ч тээврийн албан бус үйлчилгээ Монгол Улсад ихээхэн түгээмэл төдийгүй өргөн цар хүрээтэй тул тээврийн зардлын үлэмж хэсэг нь НӨАТ-ын Е-системд бүртгэгдэхгүй байх магадлалтай.</p> <p>Түлшинд НӨАТ ногдуулдаг. Дизель, бензин гэх зэрэг тээврийн хэрэгслийн түлш шатахууны худалдан авалтын дийлэнх хувь нь НӨАТ-ын Е-баримт системд бүртгэгдэх магадлал өндөр байна.</p>
<p><b>Үзвэр үйлчилгээ</b></p>	<p>Эдгээр үйлчилгээнд НӨАТ ногдуулдаг. Жижиг болон албан бус үйлчилгээ эрхлэгчдийн үзүүлж буй үзвэр үйлчилгээний төлбөрийн баримт НӨАТ-ын Е-баримт системд бүртгэгдэх магадлал тун бага байна.</p>
<p><b>Орон сууц</b></p>	<p>Орон сууцны түрээс, санхүүгийн үйлчилгээ зэрэг нь НӨАТ-аас чөлөөлөгддөг.</p> <p>Түүнчлэн, хувийн орон сууцны хэрэглээг ӨНЭЗС-д баримжаалан тооцож байгаа бол ийм хэрэглээг энэхүү судалгаанд тооцоогүй болно.</p>

<p><b>Машин</b></p>	<p>Ерөнхийдөө тээврийн хэрэгсэлд НӨАТ ногдуулдаг. Гэхдээ аж ахуй эрхлэгчид хуучин автомашин худалдан авах тохиолдолд татвар ногдуулахгүй байгаа нь хуучин автомашин худалдан авагчид төлбөрийн баримтаа Е-баримт системд бүртгэхэд түлхэц болох ямар нэгэн хөшүүрэг байхгүй байна.</p>
<p><b>Бусад</b></p>	<p>Санхүүгийн үйлчилгээ, оршуулгын ёслол, соёлын өвийг сэргээн засварлах үйлчилгээ, шашны үйлчилгээ, аялал жуулчлалын үйлчилгээ, хүмүүнлэгийн болон хөгжлийн тусламжийн зориулалтаар импортолсон бараа бүтээгдэхүүн, шинжлэх ухааны судалгаа, хайгуул, туршилт, импортын модон эдлэл, зарим салбарт зориулан импортолсон тоног төхөөрөмж зэрэг бүтээгдэхүүн, үйлчилгээнээс бусад ихэнх бүтээгдэхүүн, үйлчилгээнд НӨАТ ногдуулдаг.</p> <p>Ерөнхийдөө албан салбарын дунд болон томоохон хэмжээний аж ахуйн нэгжүүдийн борлуулсан “бусад” категорит орж байгаа бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний төлбөрийн баримт Е-баримт системд бүртгэгдэх магадлал өндөр байна.</p>

#### 6.4.2. Ядуурлын үзүүлэлтүүдийн тооцоо

Өрхийн судалгаанд ядуурал, тэгш бус байдлын үзүүлэлтүүдийг хэрэглээнд суурилан тооцдог (гэхдээ зарлагад суурилан тооцох боломжтой ч) бол бидний судалгаанд дээрх үзүүлэлтүүдийг зарлагад суурилж тооцсон болно. Өөрөөр хэлбэл, бид хэрэглээг зарлагын үзүүлэлтээр орлуулан тооцсон гэсэн үг.

Ядуурлын үзүүлэлтүүдийг тооцож байгаа статистикийн стандарт аргачлалтай нийцүүлэхийн тулд НӨАТ-ын Их өгөгдлөөс авсан зарлагын мэдээлэлд бид хэд хэдэн тохируулга тооцоог хийсэн.

Нэгдүгээрт, хувь хүмүүсийн зарлагын үзүүлэлтийг нэг хүнд ногдох өрхийн зарлага болгон хувиргасан. Ядуурал, тэгш бус байдлын үзүүлэлтийг тооцоход хувь хүний бус өрхийн түвшний хэрэглээний үзүүлэлтийг үндэслэдэг учир Их өгөгдлийн түүврийн мэдээллийг ашиглан хувь хүмүүсийн зарлагыг тэдний харьяалагдах өрхийнх нь нийт зарлага болгон нэгтгэсэн юм. Улмаар өрхийн нийт зарлагыг ам бүлийнх нь тоонд хувааж нэг хүнд ногдох зарлагыг гаргасан.<sup>47</sup> Өөрөөр хэлбэл, аав, ээжийнх нь хийсэн худалдан авалт өрхдөө л зориулагддаг учир өрхийн нийт зарлагыг ам бүлийн тоонд нь хувааж тооцох шаардлагатай.

Хоёрдугаарт, инфляцийн түвшинтэй уялдуулж зарлагын үзүүлэлтэд зохих тохируулга хийсэн. 2018, 2019, 2020 оны НӨАТ-ын Их өгөгдлийн түүврээс гаргасан

<sup>47</sup> 23600 хүний зарлагыг 9826 өрхийн зарлагад нэгтгэсэн. Түүнчлэн ӨНЭЗС-2018-ны мэдээллийн багц болон Их өгөгдлийн түүврийг тулгаж шалгахад судалгаанд хамрагдсан өрхүүдийн нийт гишүүдийн тоо (Е-баримт системд зарлагаа бүртгэдэг насанд хүрэгсэдээс гадна) 37382 байв.



зарлагын дүнг өнөөгийн үнээр тооцсон болно. Бодит өөрчлөлтийг тооцож сарын зарлагад тохируулга хийхийн тулд сарын хэрэглээний үнийн индексийг (ХҮИ) 2018 оны 1-р сарын суурь үетэй харьцуулж тоосон. Бүс нутгуудаар юмны үнэ ихээхэн ялгаатай байсан. Тухайлбал, Улаанбаатар хотоос хамгийн хол алслагдсан баруун бүсэд төвийн бусад бүсүүдтэй харьцуулахад ачаа тээврийн зардал өндөр учир юмны үнэ өндөр байх хандлагатай байна. Иймээс бид амьжиргааны түвшин, зардлын үнэлгээг үнэн бодитой хийх зорилгоор аймаг, нийслэлийн ХҮИ-ийг ашигласан. Үүний үр дүнд цаг хугацаанаас болон орон зайнаас шалтгаалсан инфляцыг тооцсон нэг хүнд ногдох сарын хэрэглээг тооцсон болно.

Ийнхүү инфляцийн өөрчлөлтийг тусгасан нэг хүнд ногдох өрхийн зарлагыг тооцсоны дараа ядуурлын түвшний үзүүлэлтийг гаргахын тулд ядуурлын шугам шаардлагатай болсон. Ядуурлын шугам нь хүнсний болон хүнсний бус ядуурлын шугамын нийлбэрээр тодорхойлогдоно. ӨНЭЗС-2018-ны ядуурлын шугамыг ашиглан НӨАТ-ын Их өгөгдлийн түүврээс хэрэглээний ядуурлын үзүүлэлтүүдийг тооцсон. ҮСХ-оос тооцож гаргасан ядуурлын шугам нь 2018 оны үнээр нэг хүнд ногдох сарын хэрэглээ 166580 төгрөг байв. 2019, 2020 оны ядуурлын шугамыг ӨНЭЗС-2018-аар тооцсон бөгөөд улмаар тэдгээрт 2019, 2020 оны хүнсний болон хүнсний бус хэрэглээний үнийн индексийн өөрчлөлтийг тусгаж тохируулга хийсэн. Үүний үр дүнд 2019 оны ядуурлын шугам 178471 төгрөг, 2020 оны ядуурлын шугам 185753 төгрөг болж тус тус өөрчлөгдсөн.<sup>48</sup> Ингээд дээрх ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй цахим төлбөрийн бүртгэлийн Е-баримт системд зарлагаа бүртгэсэн хувь хүмүүс, өрхийг ядуу, бусдыг нь ядуу бус хэмээн энэхүү тооцоонд тодорхойлсон болно.

Үүний дараагаар судалгааны үр дүнгийн төлөөлөх чадварыг сайжруулах зорилгоор ядуурал, тэгш бус байдлын үзүүлэлтүүдийн тооцоог хийхдээ тодорхой жинг ашигласан.

Өмнөх хэсэгт өгүүлсэнчлэн хүн амын хэрэглээнд суурилдагаараа онцлогтой ӨНЭЗС-нд ашигласан ядуурлын шугамыг Их өгөгдлийн түүврийн зарлагын тооцоонд ашигласан учир Их өгөгдлийн түүврээс тооцсон ядуурлын үзүүлэлтүүд нь ӨНЭЗС-ныхаас ялгаатай байх нь гарцаагүй билээ. Эдгээр шалтгааны улмаас бидний хийсэн дүн шинжилгээний гол ач холбогдолтой үр дүн бол хэрэглээний болон ядуурлын түвшин гэхээс илүүтэйгээр хүн амын хэрэглээ, ядуурлын түвшинд гарч буй өөрчлөлтийг судалсанд оршиж байгаа юм.

Ядуурлын хамралтын түвшинг ядуурлын шугамаас доогуур орлоготой (зарлагатай) хүн амын тоог нийт хүн амын тоонд хувааж тооцно.

$$P^0 = \frac{\sum_{i=1}^n I(y_i < p)}{n}$$

<sup>48</sup> Ядуурлын шугамын тооцоо нь урьдчилсан дүн болно.

$y_i$  -  $i$ - дахь хүний сарын зарлага, тухайн хүний зарлагын дүнг өрхийнх нь нийт ам бүлийн тоонд хувааж тооцно.

$p$  – ядуурлын шугам

$n$  – нийт хүн ам

$PO$  – ядуурлын хамралтын хүрээ.

Их өгөгдлийн түүврээс ядуурлын хамралтын хүрээг тооцохдоо бид ӨНЭЗС-2018-ны ядуурлын шугамыг ашигласан болно. Мөн инфляцийн өөрчлөлтийг тусгах замаар 2019, 2020 онуудын ядуурлын шугамд тохируулга (нэмэгдүүлсэн) хийсэн.

Их өгөгдлийн түүвэрт сонгогдсон янз бүрийн өрхүүдийн онцлогоос шалтгаалах магадлалыг тусгах зорилгоор ядуурлын хамралтын хүрээг жинлэж тооцсон.

#### 6.4.3. Тэгш бус байдлын үзүүлэлтүүдийн тооцоо

Тэгш бус байдлын үзүүлэлтийг тооцохдоо ядуурлын түвшинг тооцоход ашигласан нэг хүнд ногдох зарлага, инфляцийн өөрчлөлтийг тусгасан нэг хүнд ногдох өрхийн зарлагын мэдээллийг ашигласан болно. Тэгш бус байдлыг илэрхийлэх дараах индексүүдийг тооцсон болно. Эхний үзүүлэлт болох Жини коэффициентийг дараах томъёог ашиглан тооцно:

$$G = \frac{1}{n-1} \left( n+1 - 2 \times \frac{\sum_{i=1}^n (n+1-i)y_i}{\sum_{i=1}^n y_i} \right)$$

$n$  – хүн ам;  $y_i$  -  $i$ -дахь хүний өрхийн нэг хүнд ногдох зарлага.

Тэгш бус байдлыг илэрхийлэх дараагийн үзүүлэлт болох Тейлийн индексийг дараах томъёог ашиглан тооцно.

$$T_T = T_{\alpha=1} = \frac{1}{N} \sum_{i=1}^N \frac{y_i}{\mu} \ln\left(\frac{y_i}{\mu}\right)$$

$N$  – хүн ам;  $y_i$  -  $i$ - дахь хүний зарлага;  $\mu$  – дундаж зарлага. Натурал логарифм авч шинжилж үзэхэд тэгш бус байдалд гарч буй өөрчлөлт нь нийт зардалд (үндэсний) эзлэх чинээлэг хүмүүсийн зардлын хувийн жин тогтоосон босгоос хэтрэх буюу тодорхой хэмжээгээр давах тусам илүү мэдрэг болж байна. Ингэхдээ тэгш бус байдлын үзүүлэлт нь нийт зардалд эзлэх чинээлэг хүмүүсийн зардлын хувийн жингийн өсөлтөөс илүү огцом өсч байна.

Тэгш бус байдлыг илэрхийлэх гурав дахь үзүүлэлт болох Палма харьцааг – Их өгөгдлийн түүвэрт хамрагдсан нийт хүн амыг нэг хүнд ногдох зардлын түвшнээр

нь тэнцүү 10 бүлэгт хуваасны хамгийн чинээлэг 10 хувийн (Q10) нэг хүнд ногдох зардлыг хамгийн ядуу 40 хувийнхтай буюу 4 бүлгийн (Q1-Q4)-хтэй харьцуулсан харьцаагаар буюу дараах томъёогоор тооцно.

$$Palma\_index = \frac{\sum_{i=1}^n y_i (y_i \in percentile_{90}^{100})}{\sum_{i=1}^n y_i (y_i \in percentile_1^{40})}$$